

## ТАНИЛЦУУЛГА

Сүүлийн жилүүдэд ББСБ-ууд хөрөнгийн зах зээлд гарч, нээлттэй хувьцаат компани болох, банк банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагааг эрхлэх, олон улсаас хөрөнгө оруулалт татах, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр нягтлан бодох бүртгэл, тайлагналыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэх, салбарын нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг шинэчлэх, шаардлага зайлшгүй үүсээд байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын төслийг боловсрууллаа.

Шинэчлэн боловсруулсан журмын төсөлд СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр, СТОУС-13 Бодит үнэ цэнийн хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа зэрэг СТОУС, НББОУС-ын дагуу санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжих, ажил гүйлгээний бүртгэлийг дэлгэрэнгүй байдлаар оруулсан.Үүнд:

- ББСБ-ын үндсэн үйл ажиллагаа нь зээл, факторингийн үйл ажиллагаа зэрэг авлага цуглуулах үйл ажиллагаа байдаг. Иймд зээлийг үнэлж, хүлээн зөвшөөрөх хэмжилтийн сууриуд, үнэ цэнийн өсөлт бууралт, хүүг хуримтлуулан тооцох, шимтгэл хураамжийг хойшлуулан бүртгэх, тэнцлээс хасах, тэнцлээс хассан зээлийн орлогыг хүлээн зөвшөөрөх, эрсдэлийн санг СТОУС-ын дагуу ангилах, бүртгэлийн арга хандлагыг нарийвчлан зохицуулсан.
- Хадгаламжийн сертификаттай холбоотой бүртгэлийг нэмж, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх, хорогдуулсан өртгөөр илэрхийлэх, бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаасны ангиллыг тодорхойлж, хөнгөлөлт урамшуулал, үнэ цэнийн бууралтыг тооцох, ангилал шилжүүлэх зэрэг заавар удирдамжаар хангасан.
- Үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой форвард, своп, опшин, нуугдмал дерватив, хейж зэрэг хэлцлийн төрлүүдийг нарийвчлан тусгаж, түүнийг үнэлж, хэмжих, бүртгэх, үнэ цэнийн өсөлт бууралтыг тооцох, ангилах зэрэг заавар удирдамжаар хангасан.
- Түүнчлэн Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх заавар, дансны жагсаалтыг шинээр боловсрууллаа.

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэгт заасны дагуу Сангийн яамны болон Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд олон нийтээс санал авахаар байршуулсан хийгээд ББСБ-ын нягтлан бодогч нарын төлөөлөл болсон нийт 50 орчим оролцогчдын дунд хэлэлцүүлгийг 2022 оны 11 дүгээр сарын 31, 2023 оны 6 дугаар сарын 06-ны өдөр тус тус зохион байгуулсан. Сангийн яамны ХЭЗГ, СБГ-ын хэлтсүүдээс санал авч, ирүүлсэн саналыг тусгасан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох газрын мэргэжилтнүүдтэй уулзалт, хэлэлцүүлгийг 2023 оны 3, 4 дүгээр саруудад зохион байгуулан санал, зөвлөмжийг журмын төсөлд тусгасан болно.

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГАЗАР**  
**САНГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2023 оны ... дүгээр  
сарын ..-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тушаалын хавсралтаар батлагдсан журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн банк бус санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газар (Б.Итгэлсүрэн), Хяналт шалгалт, зохицуулалтын газар (Б.Долгорсүрэн)-т, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар (Б.Болормаа), үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад тус тус үүрэг болгосугай.

3.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан заавар, журмыг баримтлан гаргахаар тогтсугай.

САНГИЙН САЙД

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЖАВХЛАН

Д.БАЯРСАЙХАН

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын  
2023 оны ..... дугаар сарын ..... өдрийн хамтарсан  
..... тушаалын хавсралт

## **БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ДАГАЖ МӨРДӨХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1. Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “ТЗЭ” гэх) нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайланг бэлтгэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэ журамд Монгол Улсын банк бус санхүүгийн үйл ажиллагаанд нийтлэг тохиолддог ажил гүйлгээг хамруулсан бөгөөд харин тус журамд тусгагдаагүй ажил гүйлгээ гарсан тохиолдолд холбогдох СТОУС-ын заалтыг мөрдөнө.

1.3. ТЗЭ нь энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан “Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх аргачлал”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Санхүүгийн тайлангийн маягт”, гуравдугаар хавсралтаар баталсан “Дансны жагсаалт”-ыг тус тус дагаж мөрдөнө.

1.4. ТЗЭ нь энэ журамд нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөнө. Энэ журамд тусгагдаагүй шинэ бүтээгдэхүүн, арилжааг бүртгэх дансны харилцаа, бүртгэлийн зарчмыг Хороонд урьдчилан мэдэгдэнэ.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**

2.1. Өнгөрсөн үйл явдлын үр дүнд аж ахуйн нэгж хяналтдаа оруулсан эдийн засгийн өнөөгийн нөөцийг хөрөнгө гэнэ.

2.2. Санхүүгийн хөрөнгөд мөнгөн хөрөнгө, авлага, зээл, бусад байгууллагын өмчийн хэрэгсэл, санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрх, дериватив, тэдгээртэй ижил төстэй гэрээ, хэлцэл багтана.

#### **2.3. Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

2.3.1. Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь аж ахуйн нэгжид орох нилээд их магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартайгаар хэмжиж чадах үед хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

2.3.2. ТЗЭ нь санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг тал болсон үед санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

2.3.3. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийг Монголбанкнаас зарласан албан ханшаар үнэлж, ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

2.3.4. Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн хүүг өдөр тутам хуримтлуулж бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө, түүний бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, олз, гарзыг тухайн тайлант хугацаанд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ**

3.1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой, богино хугацаат өндөр хөрвөх чадвартай хөрөнгө юм.

3.2. Мөнгөн хөрөнгөд касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө багтана.

3.3. Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь 90 хоног буюу 3 сарын дотор мөнгөнд хөрвөх чадвартай, ямар нэгэн нөхцөлөөр хязгаарлагдаагүй байна. Энэ шалгуурыг хангаагүй мөнгөтэй адилтгах хөрөнгийг банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, эсхүл хөрөнгө оруулалтаар бүртгэнэ.

3.4. Монголбанк болон Засгийн газраас бусад этгээдийн гаргасан бонд, вексел зэрэг үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын эрсдэл тодорхойгүй тул мөнгө ба мөнгөтэй адилтгах зүйл гэж үзэхгүй. Ийм төрлийн хөрөнгө оруулалтыг 90 хоногоос богино хугацаатай байсан ч хөрөнгө оруулалтаар бүртгэнэ. Үүний нэгэн адил үнэ цэнийн бууралтын эрсдэлтэй, эсхүл мөнгөн хөрөнгийг хязгаарласан бөгөөд шууд зарцуулах боломжгүй тохиолдолд банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөөр бүртгэнэ.

3.5. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөд дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, анх гаргасан хугацаанаас хойш 3 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө, мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бусад хөрөнгө хамаарна.

### **3.6. Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

3.6.1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болон банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг эзэмшиж, захиран зарцуулах эрх нь ТЗЭ-д байгаа үед хүлээн зөвшөөрнө.

3.6.2. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь бүртгэх ба тайлагналын өдөр хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

3.6.3. Энэ хөрөнгөтэй холбоотой хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дүнд оруулж, санхүүгийн тайланд толилуулна.

3.6.4. Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэх ба тайлагналын өдөр хорогдуулсан өртгөөр бүртгэж, тусгана.

3.6.5.Хугацаа хэтэрсэн буюу үнэ цэнэ буурсан санхүүгийн хэрэгсэл нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тодорхойлолтод нийцэхгүй тул холбогдох ангилалд шилжүүлэн бүртгэх ба хөрөнгийн үнэ цэнэ буурсан санхүүгийн хэрэгсэлд эрсдэлийн сан байгуулна.

### **3.7.Дансны бичилт**

3.7.1.Бэлэн мөнгөнд касс дахь бэлэн мөнгө, замд яваа мөнгө, жижиг мөнгөн сан, тоолж шалгаагүй мөнгө хамаарна.

3.7.2.Бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ хийхэд:

3.7.2.а.Бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийхэд:

Дебет: Бэлэн мөнгө

Кредит: Холбогдох данс (Харилцах данс)

3.7.2.б.Бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийхэд:

Дебет: Холбогдох данс (Харилцах данс)

Кредит: Бэлэн мөнгө

3.7.3.Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдлыг бүртгэхэд:

3.7.3.а.Бэлэн мөнгөний үлдэгдэл нь бүртгэсэн дүнгээс их байх тохиолдолд:

Дебет: Бэлэн мөнгө

Кредит: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдал

3.7.3.б.Бэлэн мөнгөний илүүдлийн шалтгааныг тогтоож, эзэн тодорхойгүй бол бусад орлогоор, тодорхой эзэнтэй бол буцаан олгохоор бүртгэхэд:

Дебет: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдал

Кредит: Холбогдох данс (Бусад орлого, бэлэн мөнгө)

3.7.3.в.Бэлэн мөнгөний үлдэгдэл нь бүртгэсэн дүнгээс бага байх тохиолдолд:

Дебет: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдал

Кредит: Бэлэн мөнгө

3.7.3.г.Бэлэн мөнгөний дутагдлын шалтгааныг тогтоож, эзэн тодорхойгүй бол бусад зардлаар, харин тодорхой эзэнтэй бол төлүүлэхээр бүртгэхэд:

Дебет: Холбогдох данс (Бусад зардал, Бэлэн мөнгө, Бусдаас авах авлага)

Кредит: Бэлэн мөнгөний илүүдэл, дутагдал

3.7.4.Замд яваа мөнгөтэй холбоотой орлого, зарлагын гүйлгээ хийхэд:

3.7.4.а.Салбар нэгжээс төврүү бэлэн мөнгө тушаахад:

Салбар нэгж нь:

Дебет: Замд яваа мөнгө

Кредит: Бэлэн мөнгө

Төвөөс ирүүлсэн бэлэн мөнгө хүлээн авсан баримтыг үндэслэн:

Дебет: Салбар хоорондын тооцооны авлага

Кредит: Замд яваа мөнгө

Төв нь:

Дебет: Бэлэн мөнгө

Кредит: Салбар хоорондын тооцооны өглөг

3.7.4.б.Төвөөс салбар, нэгжрүү бэлэн мөнгөний зузаатгал хийхэд:

Төв нь:

Дебет: Замд яваа мөнгө

Кредит: Бэлэн мөнгө

Салбар нэгжээс ирүүлсэн бэлэн мөнгө хүлээн авсан баримтыг үндэслэн:

Дебет: Салбар хоорондын тооцооны авлага

Кредит: Замд яваа мөнгө

Салбар нэгж нь:

Дебет: Бэлэн мөнгө

Кредит: Салбар хоорондын тооцооны өглөг

3.7.5.Банк хоорондын тооцоогоор бэлэн мөнгөний зузаатгал хийхэд дээрхтэй нэгэн адил банк хоорондын тооцооны өглөг, авлагын дансанд бүртгэнэ.

3.7.6.Жижиг мөнгөн санг зөвхөн үнийн дүн багатай, жижиг зардлуудыг төлөхөд зарцуулна. Жижиг мөнгөн сангийн зардлыг уг санг нөхөн дүүргэх өдөр бүртгэнэ.

3.7.6.а.Жижиг мөнгөн сан байгуулахад:

Дебет: Жижиг мөнгөн сан

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

3.7.6.б.Жижиг мөнгөн санг нөхөн дүүргэхэд:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

3.7.6.в.Жижиг мөнгөн сангийн хэмжээг нэмэгдүүлэхэд:

Дебет: Жижиг мөнгөн сан

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

3.7.6.г.Жижиг мөнгөн сангийн хэмжээг хорогдуулахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Жижиг мөнгөн сан

3.7.6.д.Жижиг мөнгөн сангийн үлдэгдэл байвал зохих үлдэгдлээс дутагдвал:

Дебет: Бэлэн мөнгөний илүүдэл дутагдал

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

3.7.6.е.Жижиг мөнгөн сангийн үлдэгдэл байвал зохих үлдэгдлээс илүүдвэл:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Бэлэн мөнгөний илүүдэл дутагдал

3.7.7.Тайлант хугацааны эцэс хүртэл мөнгө илүүдсэн, дутагдсан шалтгааныг нь тодруулан бэлэн мөнгөний илүүдэл, дутагдал дансыг холбогдох дансанд (бусад орлого, бусад зардал, эсхүл холбогдох этгээдээс авах авлага) хааж өгнө.

3.7.8.Салбар нэгжээс тушаасан бэлэн мөнгө, харилцагчаас тушаасан бэлэн мөнгийг тоолж шалгах хүртэл тоолж шалгаагүй мөнгө дансанд бүртгэнэ.

3.7.8.а.Салбар нэгжээс эсхүл харилцагчаас бэлэн мөнгө тушаахад:

Дебет: Тоолж шалгаагүй мөнгө

Кредит: Салбар хоорондын тооцооны өглөг эсхүл харилцагчийн харилцах данс

3.7.8.б.Тухайн бэлэн мөнгийг тоолсны дараа кассад шилжүүлэх тохиолдолд:

Дебет: Бэлэн мөнгө

Кредит: Тоолж шалгаагүй мөнгө

3.7.8.в.Бэлэн мөнгийг тоолж, шалгахад байвал зохих үлдэгдлээс дутагдвал:

Дебет: Салбар хоорондын тооцооны авлага, эсхүл харилцагчийн харилцах данс

Дебет: Бэлэн мөнгө

Кредит: Тоолж шалгаагүй мөнгө

3.7.8.г.Бэлэн мөнгийг тоолж, шалгахад байвал зохих үлдэгдлээс илүүдвэл:

Дебет: Бэлэн мөнгө

Кредит: Салбар хоорондын тооцооны өглөг, эсхүл харилцагчийн харилцах данс

Кредит: Тоолж шалгаагүй мөнгө

3.7.9.Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөд дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан төгрөг, гадаад валютын харилцах, хадгаламж багтана.

3.7.10.Банк, санхүүгийн байгууллагад харилцах, хадгаламжийн данс нээхэд холбогдох гэрээ, хэлцэл, удирдлагын шийдвэрийг үндэслэнэ.

3.7.10.а.Банк, санхүүгийн байгууллагад харилцах, хадгаламж байршуулахад:

Дебет: Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө, эсхүл хөрөнгө

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

3.7.10.б.Хүү тооцож, хуримтлуулан бүртгэхэд:

Дебет: Хүүгийн авлагын холбогдох данс

Кредит: Хүүгийн орлогын холбогдох данс

3.7.10.в.Хуримтлуулсан хүү төлөгдөхөд:

Дебет: Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө, эсхүл хөрөнгө

Кредит: Хүүгийн авлагын холбогдох данс

3.7.10.г.Харилцах, хадгаламжаас бэлэн мөнгө зарлагдах буюу дансаа хаахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө, эсхүл хөрөнгө

3.7.11.Мөнгөтэй адилтгах хөрөнгөд 3 хүртэлх сарын хугацаатай Монголбанкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, хадгаламжийн сертификат хамаарна.

3.7.11.а.Үнэт цаас худалдан авахад:

Дебет: Мөнгөтэй адилтгах хөрөнгө

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

3.7.11.б.Хүү тооцож, хуримтлуулан бүртгэхэд:

Дебет: Мөнгөтэй адилтгах хөрөнгийн хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Кредит: Хөрөнгө оруулалтын хүүгийн орлого

3.7.11.в.Хуримтлуулсан хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Мөнгөтэй адилтгах хөрөнгийн хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

3.7.11.г.Үнэт цаасны хугацаа дуусахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Мөнгөтэй адилтгах хөрөнгө

3.7.12.Гадаад валют худалдах, худалдан авах замаар арилжааны зөрүүгээс ашиг олох үйл ажиллагааг гадаад валютын арилжаа гэх бөгөөд валютын нэр төрөл тус бүрээр нэрийн данс нээж, төгрөг, валютаар бүртгэнэ.

3.7.12.а.Гадаад валют худалдан авахад худалдан авсан гадаад валютын хувьд хэлцлийн ханшаар бүртгэж, дансны үнээр нь (Монголбанкнаас зарласан ханшаар) холбогдох мөнгөн хөрөнгийн дансыг бууруулахад:

Дебит: Гадаад валютын холбогдох данс

Кредит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Дебит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

3.7.12.б.Валютын хөрвүүлэлтийн дансыг орлого, зардлын дансанд хаахад:

Ашигтай үед:

Дебит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай үед:

Дебит: Гадаад валютын арилжааны зардал

Кредит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

3.7.12.в.Гадаад валют худалдах үед гадаад валютыг худалдахдаа хэлцлийн ханшаар бүртгэж, дансны үнээр нь (Монголбанкнаас зарласан ханшаар) холбогдох мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэхэд:

Дебит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Дебит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Кредит: Гадаад валютын холбогдох данс

Ашигтай үед:

Дебит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Алдагдалтай үед:



Дебит: Гадаад валютын арилжааны зардал  
Кредит: Гадаад валютын хөрвүүлэлтийн түр данс

3.7.12.г.Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютыг Монголбанкнаас зарласан албан ханшаар үнэлж, үүссэн зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх тохиолдолд:

Гадаад валютын ханш буурсан бол:  
Дебит: Гадаад валютын үнэлгээний зардал  
Кредит: Гадаад валютын холбогдох данс

Гадаад валютын ханш өссөн бол:  
Дебит: Гадаад валютын холбогдох данс  
Кредит: Гадаад валютын үнэлгээний орлого

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

4.1.Хөрөнгө оруулалтад 3 сараас дээш хугацаатай Монголбанкны болон Засгийн газрын үнэт цаас, мөнгөтэй адилтгах хөрөнгийн тодорхойлолтод багтаагүй бусад өрийн үнэт цаас, арилжааны зориулалттай, эсхүл борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт хамрагдах ба эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн бүртгэнэ.

4.2.Хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс байгуулсан эрсдэлийн санг хасаж, хуримтлуулан тооцсон хүүгийн авлагыг нэмсэн дүнгээр толилуулна.

4.3.Хөрөнгө оруулалтыг хадгаламжийн сертификат, үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэж хоёр ангилна.

4.4.Хадгаламжийн сертификат нь хүүгийн түвшин, хүчинтэй байх хугацааг нь тусгайлан заасан, хадгаламжаар баталгаажсан, арилжааны банкнаас гаргасан үнэт цаас бөгөөд хугацаанаас нь өмнө борлуулах, өвлүүлэх, гэрээслэх, барьцаалах боломжтой санхүүгийн хэрэгсэл юм.

### **4.5.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

4.5.1.Хадгаламжийн сертификат (3 сараас дээш)-ыг эзэмшиж, захиран зарцуулах эрх үүссэн үед хүлээн зөвшөөрнө.

4.5.2.Хадгаламжийн сертификатыг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бодит үнэ цэнэ нь гэрээний дагуу байршуулсан хөрөнгийн дүнтэй тэнцүү байна.

4.5.3.Хадгаламжийн сертификатын хөнгөлөлт урамшууллыг үр ашигт хүүгийн аргаар тооцно.

4.5.4.Санхүүгийн тайланд хадгаламжийн сертификатыг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Хорогдуулсан өртгийг тодорхойлохдоо анх хүлээн зөвшөөрч хэмжсэн бодит үнэ цэнэ дээр тайлант хугацаанд нэмэгдсэн хадгаламжийн сертификатын орлого болон хүүгийн авлагыг нэмж, зарлага болон холбогдох шимтгэлийг хасна.

4.5.5.Хүүгийн авлагыг гэрээнд заасан хувиар тооцоолж, хуримтлуулан бүртгэнэ.

#### **4.6.Дансны бичилт**

4.6.1.Дотоод болон гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламжийн сертификаттай холбоотой ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

4.6.1.а.Хадгаламжийн сертификат худалдан авахад:

Дебет: Хадгаламжийн сертификат

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

4.6.1.б.Хадгаламжийн сертификатын хүү тооцож, хуримтлуулахад:

Дебет: Хадгаламжийн сертификатын хүүгийн авлага

Кредит: Хүүгийн орлого

4.6.1.в.Хуримтлагдсан хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хадгаламжийн сертификатын хүүгийн авлага

4.6.1.г.Хадгаламжийн сертификатын хугацаа дуусахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хадгаламжийн сертификат

4.6.1.д.Хөнгөлөлттэй хадгаламжийн сертификат худалдан авахад:

Дебет: Хадгаламжийн сертификат

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хадгаламжийн сертификатын хөнгөлөлт

4.6.1.е.Хөнгөлөлтийг орлогод хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Хадгаламжийн сертификатын хөнгөлөлт

Кредит: Хүүгийн орлого

4.6.1.ё.Хадгаламжийн сертификатын хугацаа дуусахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хадгаламжийн сертификат

4.6.2.Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт, өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэсэн хэлбэртэй байна. Бусад хэлцэлд барьцаа болгон ашигласан үнэт цаасыг барьцаанд тавьсан үнэт цаас дансанд тусгаарлан бүртгэнэ.

4.6.3.Үнэт цаасыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх, хорогдуулсан өртгөөр илэрхийлэх, бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх гэж гурав ангилна.

#### **4.7.Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас**

4.7.1.Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас нь үнийн өөрчлөлтөөс ашиг хүртэх зорилгоор худалдан авч, богино хугацаанд

эргүүлэн худалдах зориулалттай эзэмшиж буй өрийн ба өмчийн үнэт цаас, эсхүл богино хугацаатай багцад багтсан үнэт цаас юм.

#### **4.7.2.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

4.7.2.а.Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр буюу худалдан авахад төлсөн мөнгөн дүнгээр илэрхийлнэ.

4.7.2.б.Энэ ангиллын үнэт цаасыг сар бүрийн эцэст бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

4.7.2.в.Үр ашигт хүүгийн аргыг ашиглан арилжааны үнэт цааснаас тооцсон хүүг тухайн тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Хэрэв ногдол ашиг авах эрх үүссэн, авах магадлалтай гэж үзвэл ногдол ашгийн орлогоор бүртгэнэ.

4.7.2.г.Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасыг данснаас хасах үед дансны үнэ ба борлуулсан үнийн зөрүүгээр арилжааны орлого, зардал бүртгэнэ.

4.7.2.д.ТЗЭ-ийн удирдлагын шийдвэрийг үндэслэн үнэт цаасны зориулалтыг өөрчилж, бусад ангилалд шилжүүлж болно. Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны ангиллыг өөрчлөх үед тухайн өдрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Ангилал өөрчлөхөөс өмнө хүлээн зөвшөөрч бүртгэсэн орлого, зардлыг буцаахгүй.

4.7.2.е.Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны хувьд үнэ цэнийн бууралтыг тусгайлан тооцохгүй.

4.7.2.ё.Гадаад валютаар илэрхийлэгдсэн үнэт цаасны хувьд гадаад валютын ханшийн өөрчлөлтийг бодит үнэ цэнийн орлого, зардлаас салгаж бүртгэхгүй.

#### **4.7.3.Дансны бичилт**

4.7.3.а.Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасыг худалдан авахад:

Дебет: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

4.7.3.б.Үнэт цаасыг урамшуулалттай худалдан авахад:

Дебет: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас (нэрлэсэн дүнгээр)

Дебет: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны хорогдуулаагүй урамшуулал (зөрүүгээр)

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

4.7.3.в.Хэрэв үнэт цаасыг хямдруулалттай худалдан авах тохиолдолд:

Дебет: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас (нэрлэсэн дүнгээр)

Кредит: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны хорогдуулаагүй хямдруулалт (зөрүүгээр)  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

4.7.3.г. Үнэт цаасны хүүг тооцоолж, хуримтлуулахад:

Дебет: Үнэт цаасны хүүгийн авлага  
Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого

4.7.3.д. Үнэт цаасны хүүг хүлээн авахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Үнэт цаасны хүүгийн авлага

4.7.3.е. Үнэт цаасны хүүг хуримлуулахгүйгээр хүлээн авахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого

4.7.3.ё. Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасыг дараагийн тайлант үед хэмжихэд:

Үнэт цаасны ханш өссөн бол зөрүүгээр нь:

Дебет: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны хорогдуулаагүй урамшуулал, хямдруулалт  
Кредит: Үнэт цаасны үнэлгээний өөрчлөлтийн олз

Үнэт цаасны ханш буурсан бол зөрүүгээр нь:

Дебет: Үнэт цаасны үнэлгээний өөрчлөлтийн гарз  
Кредит: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны хорогдуулаагүй урамшуулал, хямдруулалт

4.7.3.ё. Тайлант хугацааны эцэст үнэт цаасны үнэлгээний өөрчлөлтийн олз, гарзыг хааж, цэвэр дүнг гаргахад:

Дебет: Үнэт цаасны үнэлгээний өөрчлөлийн олз  
Кредит: Үнэт цаасны үнэлгээний үнэлгээний өөрчлөлтийн гарз

4.7.3.ж. Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасыг борлуулах үед үнэт цаас худалдсан өдрийн дансны үлдэгдэл ба борлуулсан үнийн зөрүүгээр арилжааны орлого, зардлыг хүлээн зөвшөөрнө.

Ашигтай бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого  
Кредит: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны данс

Алдагдалтай бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Дебет: Үнэт цаасны арилжааны зардал  
Кредит: Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны данс

4.7.3.з. Үнэт цаасны үнэлгээний өөрчлөлтийн олз, гарзыг үнэт цаасны арилжааны хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэхэд:

Дебет: Үнэт цаасны үнэлгээний өөрчлөлтийн гарз  
Кредит: Үнэт цаасны арилжааны орлого

Эсхүл:

Дебет: Үнэт цаасны арилжааны зардал  
Кредит: Үнэт цаасны үнэлгээний өөрчлөлтийн олз

4.7.3.и.Үнэт цаасны арилжааны орлого, зардлыг санхүүгийн тайланд цэвэр дүнгээр толилуулна.

#### **4.8.Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас**

4.8.1.Санхүүгийн хөрөнгийг дараах нөхцөл хангагдсан тохиолдолд хорогдуулсан өртгөөр хэмжинэ:

4.8.1.а.гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулан авахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой;

4.8.1.б.тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь тогтоосон өдрүүдэд үндсэн дүн ба хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээ үүсгэдэг.

#### **4.8.2.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

4.8.2.а.Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр холбогдох шууд зардал(шууд зардал гэдэгт үнэт цаас худалдан авахтай холбогдон гарах хураамж, шимтгэлийн зардал хамаарна)-ыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

4.8.2.б.Үнэт цаасны хорогдуулсан өртөг нь анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцсон хямдруулалт, урамшууллын хорогдуулалтыг нэмэх буюу хасаж, эрсдэлийн сангаар тохируулсан дүн юм. Үнэт цаасны хорогдуулсан өртөгт уг үнэт цаасанд хуримтлуулан тооцсон хүүгийн авлага багтана.

4.8.2.в.Үр ашигт хүүгийн аргаар үнэт цаасны урамшуулал, хямдруулалтын хорогдуулалтыг тооцохдоо анхны үнээс тооцсон үр ашигт хүүгийн дүнгээс хүүгийн төлбөрийг хасна. Урамшуулал, хямдруулалтаас тайлант хугацаанд ногдох хорогдуулсан дүнг хүүгийн орлогоор бүртгэнэ.

4.8.2.г.Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаасны ангилал өөрчлөгдөх үед бодит үнэ цэнээр нь үнэлж, үүссэн үнэлгээний зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

4.8.2.д.ТЗЭ нь хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаасны эрсдэлийн санг байгуулахдаа энэ журмын "Зээл" бүлэгт заасны дагуу хэмжиж, бүртгэнэ.

#### **4.8.3.Дансны бичилт**

4.8.3.а.Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаасыг худалдан авахад:

Урамшуулалтай бол:

Дебет: Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас

Дебет: Үнэт цаасны урамшуулал

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Хямдруулалттай бол:

Дебет: Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Үнэт цаасны хямдруулалт

4.8.3.б. Үнэт цаасны хүү тооцож, хуримтлуулахад:

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Кредит: Хүүгийн холбогдох орлого

4.8.3.в. Үнэт цаасыг анх урамшуулалттай авсан бол урамшууллыг үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалтын дүнгээр хүүгийн орлогыг бууруулахад:

Дебет: Хүүгийн холбогдох орлого

Кредит: Үнэт цаасны урамшуулал

4.8.3.г. Үнэт цаасыг анх хямдруулалттай авсан бол хямдруулалтыг үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалтын дүнгээр хүүгийн орлогыг нэмэгдүүлэхэд:

Дебет: Үнэт цаасны хямдруулалт

Кредит: Хүүгийн холбогдох орлого

4.8.3.д. Үнэт цаасны хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

4.8.3.е. Үнэт цаасны хугацаа дуусаж, үндсэн төлбөр төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас

4.8.3.ё. Үнэт цаасны үнэ цэнийн бууралтыг тооцож, эрсдэлийн сан байгуулахад:

Дебет: Үнэт цаасны эрсдэлийн сангийн зардал

Кредит: Үнэт цаасны эрсдэлийн сан

4.8.3.ж. Үнэт цаасны үнэ цэнийн бууралтыг буцаах тохиолдолд:

Дебет: Үнэт цаасны эрсдэлийн сан

Кредит: Үнэт цаасны эрсдэлийн сангийн зардал эсхүл бусад олз

#### **4.9. Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас**

4.9.1. Санхүүгийн хөрөнгийг дараах нөхцөл хангагдсан тохиолдолд бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ:

4.9.1.а. гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулан авах ба санхүүгийн хөрөнгийг борлуулах гэсэн хоёр зорилготой;

4.9.1.б. тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь тогтоосон өдрүүдэд үндсэн дүн ба хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээ үүсгэдэг.

4.9.2. ТЗЭ нь өмчийн үнэт цаасыг бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийж болно.

### **4.9.3.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

4.9.3.а.Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр холбогдох шууд зардлыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

4.9.3.б.Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг үнэт цаасны дахин үнэлгээний сан дансанд хуримтлуулан бүртгэж, бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана.

4.9.3.в.Дахин үнэлгээний сан дансанд дараах зүйлсийг бүртгэхгүй ба тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ:

- Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн орлого, зардал;
- Үнэт цааснаас хүлээн авах ногдол ашгийн орлого;
- Эрсдэлийн сангийн зардал.

4.9.3.г.Үнэт цаасыг бусдад худалдах болон шилжүүлэх, данснаас хасах үед дахин үнэлгээний сан дансны үлдэгдлийг тайлант хугацааны орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

4.9.3.д.Үнэт цаасны зах зээлийн жишиг үнийг ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлох ба харин жишиг үнэ байхгүй тохиолдолд СТОУС 13-д заасан үнэлгээний аргачлалыг ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлно. Үнэт цаасны бодит үнэ цэнийг хэмжих боломжгүй тохиолдолд өртгөөр нь бүртгэх бөгөөд энэ нь зөвхөн жишиг үнэгүй өмчийн хэрэгсэл ба түүнд суурилсан деривативт хамаарна.

4.9.3.е.Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар тооцно. Хүүгийн орлого, хүүгийн төлбөрийн зөрүүг урамшуулал, хямдруулалтын хорогдуулалтаар бүртгэнэ.

4.9.3.ё.ТЗЭ нь хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн цаасны эрсдэлийн санг байгуулахдаа энэ журмын "Зээл" бүлэгт заасны дагуу хэмжинэ.

4.9.3.ж.Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасанд эрсдэлийн сан байгуулахдаа уг үнэт цаастай холбоотойгоор дахин үнэлгээний сан дансанд хуримтлуулж, бүртгэсэн дүнг тухайн тайлант хугацааны эрсдэлийн сангийн зардалд шилжүүлэн бүртгэнэ.

4.9.3.з.Өрийн үнэт цаасны эрсдэлийн сангийн зардлын буцаалтыг орлого, зардлын дансанд бүртгэнэ. Жишиг үнэгүй, өртгөөр бүртгэсэн өмчийн үнэт цаасны хувьд эрсдэлийн сангийн зардлыг буцаахгүй.

### **4.9.4.Дансны бичилт**

4.9.4.а.Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасыг худалдан авахад:

Дебет: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

4.9.4.б.Үнэт цаасны хүүг тооцоолж, хуримтлуулахад:

Дебет: Үнэт цаасны хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого

4.9.4.в. Үнэт цаасны хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Үнэт цаасны хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

4.9.4.г. Үнэт цаасны хүүг хуримтлуулахгүйгээр төлөх үед:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Үнэт цаасны хүүгийн орлого

4.9.4.д. Үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бүртгэхэд:

Үнэт цаасны бодит үнэ цэнэ нь дансны үнээс их бол:

Дебет: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас

Кредит: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны дахин үнэлгээний сан

Үнэт цаасны бодит үнэ цэнэ нь дансны үнээс бага бол:

Дебет: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны дахин үнэлгээний сан

Кредит: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас

4.9.4.е. Үнэт цаасны дахин үнэлгээний сан дансанд хуримтлуулсан дүнг эрсдэлийн сангийн зардалруу бүртгэхэд:

Дебет: Үнэт цаасны арилжааны зардал

Кредит: Үнэт цаасны дахин үнэлгээний сан

4.9.4.ё. Үнэт цаасыг борлуулсан үед үнэт цаасны дансны үнэ ба борлуулсан үнийн зөрүүг арилжааны орлого, зардлаар бүртгэхэд:

Ашигтай бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Дебет/Кредит: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны дахин үнэлгээний сан

Кредит: Үнэт цаасны арилжааны орлого

Кредит: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас

Алдагдалтай бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Дебет/Кредит: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны дахин үнэлгээний сан

Дебет: Үнэт цаасны арилжааны зардал

Кредит: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас

4.9.4.ж. Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны ангиллыг өөрчлөх үед:

Дебет: Үнэт цаасны холбогдох данс



Кредит: Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаас

#### **4.10.Гадаад валютаар хийсэн хөрөнгө оруулалт**

4.10.1.ТЗЭ нь гадаад валютаар хийсэн санхүүгийн хөрөнгө(гадаад валютын хейж хамаарахгүй)-ийг НББОУС 21-ийн дагуу бүртгэнэ.

#### **4.10.2.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

4.10.2.а.Гадаад валютаар хийсэн бүх төрлийн хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрөх үед албан ханшаар хөрвүүлэн бүртгэнэ.

4.10.2.б.Хүүгийн орлого, эрсдэлийн сангийн зардал зэргийг ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлж, хүлээн зөвшөөрнө.

4.10.2.в.Гадаад валютаар хийсэн хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасаар ангилсан тохиолдолд гадаад валютын ханшийн өөрчлөлтийн зөрүүг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарзаас салгаж бүртгэхгүй.

4.10.2.г.Гадаад валютаар хийсэн хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасаас бусад ангиллаар бүртгэсэн тохиолдолд мөнгөн зүйл эсхүл мөнгөн бус зүйлийн хэлбэртэй байгааг харгалзана. Өрийн үнэт цаасыг мөнгөн зүйл, харин өмчийн үнэт цаасыг мөнгөн бус зүйл гэж үзнэ.

4.10.2.д.Гадаад валютаар хийсэн мөнгөн зүйлсийн хөрөнгө оруулалтын тайлагналын өдрөөрх үлдэгдлийг тухайн өдрийн хаалтын ханшаар хөрвүүлж, үүссэн ханшийн зөрүүг тайлант үеийн орлого, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Мөн ийм хөрөнгө оруулалт эргэн төлөгдөх үед ханшийн зөрүү үүсвэл тайлант үеийн орлого, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

4.10.2.е.Мөнгөн бус зүйлсийн хөрөнгө оруулалтыг хаалтын ханшаар хөрвүүлэх эсэх нь тэдгээрийг түүхэн өртөг эсхүл бодит үнэ цэнээр бүртгэснээс шалтгаална. Түүхэн өртгөөр бүртгэсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө оруулалтад ханшийн зөрүүгээр тохируулга хийхгүй. Бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бүртгэхдээ тухайн өдрийн албан ханшаар хөрвүүлнэ. Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх хөрөнгө оруулалтын хувьд ханшийн зөрүүг үнэт цаасны дахин үнэлгээний сан дансанд бүртгэнэ.

4.10.2.ё.Гадаад валютаар хийсэн санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан тохиолдолд тухайн хөрөнгө оруулалтын дансны үнийг гадаад валютаар тооцоолон гаргаж, ангилал өөрчилсөн өдрийн албан ханшаар хөрвүүлнэ.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ЗЭЭЛ**

5.1.Зээл гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр бусад этгээдэд хүүтэй буюу хүүгүй олгосон мөнгөн хөрөнгийг ойлгоно.

## **5.2.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

5.2.1.Зээлийг зээлийн гэрээний нэг тал болсон үед санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

5.2.2.Зээлийн хугацаа дуусан, зээлдэгч гэрээнд заасан төлбөрөө барагдуулж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн, эсхүл гэрээгээр үүссэн эрхээ бусдад бүрэн шилжүүлсэн тохиолдолд зээлийг данснаас хасаж бүртгэнэ.

5.2.3.Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжих ба хэрэв зээл олгохтой шууд холбоотой ажил гүйлгээний зардал гарсан бол уг зардлыг бодит үнэ цэн дүн дээр нэмэх эсвэл хасах байдлаар хэмжинэ.

5.2.4.Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна.

5.2.5.Зээлдэгч тал үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон шимтгэл, хураамжийг хойшлуулан бүртгэж, холбогдох эх үүсвэрийн дүнг бууруулна. Үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон шимтгэл, хураамжийг хоёр төрөлд ангилж болно:

5.2.5.а.Зээл олгохтой холбоотой шимтгэл, хураамж (зээл олголтын хураамж)

5.2.5.б.Хэлцэлд заасан үүрэгтэй холбоотой шимтгэл, хураамж (хүлээсэн үүргийн хураамж).

5.2.6.Зээл олголтын хураамж нь дараах зүйлсээс бүрдэнэ:

5.2.6.а.Зээлдэгчийн “урьдчилж төлсөн” хүү эсхүл зээлийн нэрлэсэн хүүгийн түвшнийг бууруулах хураамж, шимтгэл буюу зээлдэгчийн санхүүгийн байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа хөрөнгө, бусад хэлцлийг үнэлж, гэрчлэх, нөхцөлийг харилцан зөвшилцөх, баримт боловсруулах зэрэг үйл ажиллагаатай холбоотой бол шимтгэл, хураамжийг зээл олголттой холбоотой гэж үзнэ.

5.2.6.б.Зээл олгох үйл ажиллагаанд шууд хамаарах бусад шимтгэл, хураамж (зээл олгосны шагналд төлсөн эсхүл хурдан хугацаанд зээл гаргахад зориулан зээлдэгчид төлсөн шимтгэл, хураамж).

5.2.7.Зээлийн шимтгэлийг хэрхэн бүртгэх нь зээл олгогдох магадлалтай эсэх болон зээлд хамаарах үүрэг нь СТОУС 9-ийн хүрээнд багтсан эсэхээс шалтгаалан тодорхойлогдоно. Хэрэв зээл олгогдох магадлалтай бөгөөд зээлд хамаарах үүрэг нь СТОУС 9-ийн хамрах хүрээнд багтаагүй тохиолдолд шимтгэлийг санхүүгийн хэрэгсэлд зориулагдсан төлбөр гэж үзэх тул хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар тохируулна. Хэрэв зээл олгогдоогүй тохиолдолд шимтгэлийг шийдвэр гарсан өдрөөр зээлдүүлэгч нь орлогод бүртгэнэ.

5.2.8.Зээлийн шугамыг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн ашиглах магадлалтай гэх нотолгоо байгаа бол шимтгэлийг СТОУС 9-д заасны дагуу хойшлуулан бүртгэнэ. Энэ тохиолдолд шимтгэлийг зээл олгох хүртэл хорогдуулж бүртгэхгүй. Зээлийн шугамыг нээж, үүнээс зөвхөн тодорхой хэсгийг ашиглаж, зээл олгосон бол нийт төлсөн хураамжийн жигнэсэн хэсэг нь харгалзах ажил гүйлгээний өртөг болох тул үүнийг зээл олгогдох хүртэл хойшлуулан бүртгэнэ. Зээлийн шугамыг ашиглах магадлалтай гэх нотолгоо байхгүй бол шимтгэл нь зээлийн шугамыг нээх төлбөр

болох ба үүнийг хойшлуулан бүртгэж, зээлийн шугамын хүчинтэй байх хугацаанд хорогдуулна.

### **5.3.Зээлийн эрсдэлийн сан (үнэ цэнийн бууралт)**

5.3.1.ТЗЭ нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу сар бүр зээлийн эрсдэлийн санг байгуулна. Түүнчлэн тайлант жилийн эцэст зээлийн үнэ цэнийн бууралтыг СТОУС-9-д нийцүүлэн тооцож болно.

5.3.2.СТОУС 9-д заасан үнэ цэнийн бууралтын загвар нь хүлээгдэж буй алдагдлын загвар бөгөөд алдагдал үүсэх үйл явдал тохиолдохоос өмнө үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрдөг. Иймд ТЗЭ нь зээлийн үнэ цэнийн бууралтыг хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнгээр үнэлж, бүртгэнэ.

5.3.3.ТЗЭ нь санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дараах дүнгээр хүлээн зөвшөөрнө:

5.3.3.а.Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдээгүй тохиолдолд 12 сарын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр;

5.3.3.б.Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдсэн тохиолдолд нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү дүнгээр.

5.3.4.Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь санхүүгийн хөрөнгийн төлбөр барагдуулахаар хүлээгдэж буй хугацаанд зээлийн алдагдлын магадлалаар жинлэсэн тооцоолол буюу бүх мөнгөн алдагдлын өнөөгийн үнэ цэнэ бөгөөд мөнгөн алдагдал нь гэрээний дагуу ТЗЭ-д төлөгдөх ёстой мөнгөн гүйлгээ ба тухайн ТЗЭ-ийн авахаар хүлээж буй мөнгөн гүйлгээний хоорондох зөрүү юм.

5.3.5.Тайлагналын өдрөөр зээлийн үнэлэмж буурсан бол ТЗЭ нь тухайн хөрөнгийн эрсдэлийн санг хасаагүй хорогдуулсан өртөг ба анхны үр ашигт хүүгийн түвшнээр дискаунтчилж тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн хоорондын зөрүүгээр хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжинэ. Түүнд хийх аливаа тохируулгыг эрсдэлийн сангийн зардал эсвэл бусад орлогоор хүлээн зөвшөөрнө.

5.3.6.Гадаад валютаар зээл олгосон тохиолдолд зээлийн ирээдүйн мөнгөн гүйлгээг гадаад валютаар тооцоолон, тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлнэ. Зээлийн өнөөгийн үнэ цэнийг төгрөгт хөрвүүлсэн дүн ба дансны үнийн зөрүүг эрсдэлийн сангийн зардалд бүртгэнэ.

### **5.4.Дансны бичилт**

5.4.1.Зээл олгох үед түүнтэй шууд холбогдох зардлыг зээлийн хойшлогдсон орлого дансанд хойшлуулан бүртгэж, зээлийн хугацаанд хорогдуулна.

5.4.1.а.Зээл олгох үед зээлийн гэрээний дүн буюу нэрлэсэн дүнгээр:

Дебет: Зээлийн холбогдох данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

5.4.1.б.Зээлд шууд хамаарах шимтгэл, хураамжийг хойшлуулан бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Зээлийн хойшлогдсон орлого

5.4.1.в.Хойшлуулсан орлогыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулж, хүүгийн орлогыг нэмэгдүүлж тохируулахад:

Дебет: Зээлийн хойшлогдсон орлого

Кредит: Зээлийн хүүгийн орлого

5.4.1.г.Зээл төлөгдөхөд:

Дебет: Зээлдэгчийн харилцах данс

Кредит: Зээлийн холбогдох данс

5.4.2.Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу зээлийг хугацаа болон чанарын үзүүлэлтээр нь хэвийн, анхаарал хандуулах, хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл гэж ангилна.

5.4.2.а.Хэвийн зээлийн ангиллаас анхаарал хандуулах зээл рүү шилжүүлэн ангилал бууруулахад:

Дебет: Анхаарал хандуулах зээл

Кредит: Хэвийн зээл

5.4.2.б.Зээлийн чанар сайжирвал дээрх бичилтийн урвуу бичилт хийнэ:

Дебет: Хэвийн зээл

Кредит: Анхаарал хандуулах зээл

5.4.3.Зээлийн хүүгийн орлогыг зээлийн гэрээ, холбогдох заавар, журамд заасан хувиар тооцоолж, хуримтлуулан бүртгэнэ.

5.4.3.а.Зээлийн хүүг хуримтлуулан тооцоход:

Дебет: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага

Кредит: Зээлийн хүүгийн орлого

5.4.3.б.Хуримтлуулан тооцсон зээлийн хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага

5.4.3.в.Зээлийн хүүг хуримтлуулан тооцолгүйгээр шууд суутгахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Зээлийн хүүгийн орлого

5.4.4.Зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөрийн аль нэг нь зээлийн гэрээнд заагдсан төлөгдөх хугацаанаас хойш 90 хоногийн дотор төлөгдөөгүй бол 91 дэх хоногоос эхлэн хүүг хуримтлуулан бүртгэхийг зогсоон, өмнө нь хуримтлуулсан хүүг буцааж, тэнцлийн гадуурх хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн хүү дансанд бүртгэнэ. Цаашид зээлд тооцох хүүг энэ дансанд нэмж бүртгэн, төлүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.Төлөгдсөн зээлийн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас зарлагдана. Бусад төрлийн санхүүгийн хөрөнгө, 90 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг дараах зарчмын дагуу бүртгэнэ.

5.4.4.а.Өмнө нь хуримтлуулсан хүүг буцаахад:

Дебет: Зээлийн хүүгийн орлогын буцаалт

Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага

5.4.4.б.Тэнцлийн гадуур бүртгэлтэй хүү төлөгдөхөд:  
Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Зээлийн хүүгийн орлого

5.4.5.Зээлийн эрсдэлийн сангийн зардал (үнэ цэнийн бууралт)-ыг тооцохдоо Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг баримтална.

5.4.5.а.Зээлийн эрсдэлийн сан байгуулахад:  
Дебет: Зээлийн эрсдэлийн сангийн зардал  
Кредит: Зээлийн эрсдэлийн сан

5.4.5.б.Илүү байгуулсан зээлийн эрсдэлийн санг буцаахад:  
Дебет: Зээлийн эрсдэлийн сан  
Кредит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал

5.4.5.в.Хэрэв зээлийн эрсдэлийн санг буцаах дүн нь тухайн өдрөөрх зээлийн эрсдэлийн зардлын үлдэгдлээс хэтэрсэн бол зээлийн эрсдэлийн зардлыг хаагаад үлдсэн зөрүүг бусад орлогоор бүртгэхэд:  
Дебет: Зээлийн эрсдэлийн сан  
Кредит: Бусад орлого - Зээлийн эрсдэлийн сангаас буцаасан орлого

5.4.5.г.Зээлийн эрсдэлийн сангийн зардал данс хангалттай үлдэгдэлтэй болсон тохиолдолд зээлийн эрсдэлийн сангаас буцаасан орлогыг зээлийн эрсдэлийн сангийн зардалд эргүүлэн хаахад:  
Дебет: Бусад орлого - Зээлийн эрсдэлийн сангаас буцаасан орлого  
Кредит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал

5.4.5.д.Хаасан зээлийн дүнгээр тэнцлийн гадуурх зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийн дансанд бүртгэж, зээлийг эргүүлж төлүүлэх ажиллагааг үргэлжлүүлнэ. Зээлийн эрсдэлийн сангаас зээл хаахад:  
Дебет: Зээлийн эрсдэлийн сан  
Кредит: Зээлийн холбогдох данс

5.4.5.е.Хэрэв хаагдсан зээл бүтнээрээ буюу хэсэгчлэн эргэн төлөгдөхөд (төлөгдсөн зээлийн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас мөн зарлагадна):  
Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Бусад орлого-Зээлийн эрсдэлийн сангаас хаагдсан зээлийн эргэн төлөлт

5.4.6.Холбогдох активын ангиллын журмаар тооцоолсон зээлийн эрсдэлийн сангийн дүн нь СТОУС-ын дагуу байгуулах эрсдэлийн сангаас бага гарвал СТОУС-ын дагуу тооцоолсон дүнгээр эрсдэлийн сангийн зардлыг бүртгэх ба түүнээс илүү гарсан дүнгээр эрсдэлийн сангийн нөөцөд бүртгэнэ.

5.4.6.а.ТЗЭ нь удирдлагын үйл ажиллагааны зорилгоор СТОУС-ын дагуу активын эрсдэлийн санг байгуулахад:  
Дебет: Зээлийн эрсдэлийн сангийн зардал  
Кредит: Зээлийн эрсдэлийн сан

5.4.6.б.Хэрэв холбогдох активын ангиллын журмаар тооцоолсон эрсдэлийн сангийн дүн СТОУС-ын дагуу байгуулах эрсдэлийн сангаас өндөр гарвал эдгээрийн зөрүүг өөрийн хөрөнгийн эрсдэлийн сангийн нөөц дансанд бүртгэхэд:

Дебет: Хуримтлагдсан ашиг

Кредит: Эрсдэлийн сангийн нөөц

5.4.7.Гадаад валютаар олгосон зээлийг албан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар бүртгэнэ.

5.4.7.а.Ханш өссөн бол:

Дебет: Зээлийн холбогдох данс

Кредит: Гадаад валютын ханшийн зөрүүний олз

5.4.7.б.Ханш буурсан бол:

Дебет: Гадаад валютын ханшийн зөрүүний гарз

Кредит: Зээлийн холбогдох данс

5.4.8.Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзыг хооронд нь хааж, цэвэр дүнгээр санхүүгийн тайланд толилуулна.

5.4.9.Гадаад валютаар олгосон зээлийн эрсдэлийн санг сар бүр хаалтын ханшаар хөрвүүлэх ба үүссэн ханшийн зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар бүртгэнэ. Зээлийн чанар муудсан, эсхүл сайжирснаас бусад тохиолдолд буюу тухайлбал гадаад валютын албан ханш өөрчлөгдсөнөөр зээлийн эрсдэлийн санг нэмэгдүүлэх буюу бууруулж бүртгэхгүй.

5.4.9.а.Ханш өссөн бол:

Дебет: Гадаад валютын ханшийн зөрүүний гарз

Кредит: Зээлийн эрсдэлийн сан

5.4.9.б.Ханш буурсан бол:

Дебет: Зээлийн эрсдэлийн сан

Кредит: Гадаад валютын ханшийн зөрүүний олз

5.4.10.Гадаад валютын ханшийн өөрчлөлттэй уялдуулан СТОУС-ын дагуу тооцоолсон эрсдэлийн сангийн зардлыг өөрчлөх шаардлагатай болсон бол дараах байдлаар бүртгэнэ:

5.4.10.а.Хэрэв зээлийн эрсдэлийн санг нэмэгдүүлэхэд:

Дебет: Зээлийн эрсдэлийн сангийн зардал

Кредит: Зээлийн эрсдэлийн сан

5.4.10.б.Хэрэв зээлийн эрсдэлийн санг бууруулахад:

Дебет: Зээлийн эрсдэлийн сан

Кредит: Зээлийн эрсдэлийн сангийн зардал

5.4.11.ТЗЭ өөрийн зээлийг, эсхүл зээлийн багцыг бусад банк, санхүүгийн байгууллага, хуулийн этгээдэд гэрээний дагуу худалдан борлуулах буюу шилжүүлж болно. Харилцагч зээлээ эргүүлэн төлөхгүй тохиолдолд эрхийг шилжүүлж авсан тал бүх хяналтыг хүлээн авсан бол тухайн хөрөнгийг данснаас хасах бөгөөд харин эрхээ

бүрэн шилжүүлээгүй, хяналтыг хэсэгчлэн тогтоож байгаа нөхцөлд эрсдэлд харгалзах хөрөнгийн хэсгийг бүртгэлдээ тусгаж, үлдсэн хэсгийг данснаас хасна.

5.4.11.а.Зээлийг шаардах эрхийн хамт худалдаж байгаа тохиолдолд тухайн зээл, түүний хуримтлуулсан хүүгийн дансыг хааж, худалдан авагч талд шилжүүлэх үед:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Дебет: Үйл ажиллагааны бусад зардал

Кредит: Зээлийн холбогдох данс

5.4.11.б.Зээлийг худалдахдаа шаардах эрхээ шилжүүлээгүй, зээлийн эрсдэлийг ТЗЭ хүлээх тохиолдолд худалдсан зээлийг данснаас хасалгүйгээр зээлийн бүртгэлийг үргэлжлүүлж, худалдсан өдрөөр өр төлбөр үүсгэн бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Дебет: Үйл ажиллагааны бусад зардал

Кредит: Бусад санхүүгийн өр төлбөр

5.4.11.в.Зээл худалдан авсан талд зээлийн төлбөрийг шилжүүлэх үед өр төлбөрийг бууруулан бүртгэхэд:

Дебет: Бусад санхүүгийн өр төлбөр

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

5.4.12.ТЗЭ зээлийн шаардах эрхээ гэрээний үндсэн дээр тусгай зориулалтын компанид шилжүүлж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж болох ба ТЗЭ нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг хэрэгжүүлж байгаа тохиолдолд хөрөнгөөс олох орлогыг баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц тус бүрээр, багцын тодорхой хэсгээр тусдаа дансанд хуримтлуулна.

5.4.12.а.Зээлийн шаардах эрхийг тусгай зориулалтын компанид шилжүүлж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Зээлийн холбогдох данс (Багцын дүнгээр)

5.4.12.б.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цааснаас үүсэх мөнгөн төлбөрийн шаардах эрхийг буюу үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг хэрэгжүүлэхэд:

Дебет: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага (Зээлийн холбогдох данс - Багцын дүнгээр)

Кредит: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг

5.4.12.в.Зээл, хүүгийн төлбөрийг цуглуулахад:

Дебет: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн авлага

Кредит: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүний орлого

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага

5.4.12.г.Үйлчилгээний шимтгэл, хураамж тооцоход:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Үйлчилгээний шимтгэлийн орлого - Хөрөнгөөр

баталгаажсан үнэт цаас

5.4.12.д.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас олгосон зээл болон түүнтэй холбогдон үүсэх аливаа хүүгийн орлого, хүүгийн авлагыг үндсэн

зээлийн данснаас тусгаарлан бүртгэж, гэрээнд заасан хугацаанд холбогдох төлбөр тооцоог тусгай зориулалтын компанид шилжүүлнэ. Зээл, хүүгийн төлбөрийг гэрээнд заасан дүнгээр шилжүүлэхэд:

Дебет: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

5.4.13.ТЗЭ харилцагчийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа, батлан даалт гаргаж болно.

5.4.13.а.Батлан даалтын хугацаа дуусаж, харилцагч зээлээ төлж чадаагүйгээс ТЗЭ зээлийг төлж барагдуулах нөхцөлд зээлийн төлбөрийг хийхийн өмнө зээлийн хувийн хэрэг, төлбөр тооцоо хийсэн баримт болон холбогдох баримт материалыг тухайн зээлийг олгосон эрх бүхий этгээдээс эх хувиар нь хүлээн авсны эцэст зээлд бүртгэхэд:

Дебет: Зээлийн холбогдох данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

5.4.13.б.ТЗЭ харилцагчид зээл олгосноор зээлдэгч өрөө барагдуулах чадваргүй болж болзошгүй тул зээл олгосны дараа зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцоолно.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТҮРЭЭС**

6.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор эрх олгосон тохиолдолд ТЗЭ нь санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг эрхлэж болно.

6.2 Санхүүгийн түрээсийг хүлээн зөвшөөрч бүртгэхдээ СТОУС 16-г дагаж мөрдөнө.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ ФАКТОРИНГИЙН ТООЦООНЫ АВЛАГА**

7.1.Факторингийн үйл ажиллагаа гэж бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгчээс борлуулсан бараа, ажил, үйлчилгээ болон хэлцлээс хүлээгдэж буй шаардах эрхээ шилжүүлэх, эрхийг хүлээн авагч нь бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр санхүүжилт олгох болон худалдан авагч, зээлдэгчээс нэхэмжлэлийн дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Факторингийн үйл ажиллагаа нь урьдчилгаа санхүүжилтийн, авлагын удирдлагыг хэрэгжүүлэх төрөлтэй байж болно.

### **7.2.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

7.2.1. Факторингийн үйл ажиллагаанд санхүүгийн өр төлбөрийг хүлээн авахад холбогдох эрсдэл, өгөөжийг бүгдийг хүлээн авах эсэхийг тогтоох ба шаардах эрхийг бүрэн хүлээн авсан бол уг санхүүгийн хэрэгслийг холбогдох дансанд бүртгэнэ. Харин эрсдэл өгөөжийг бүрэн хүлээн аваагүй бол хүлээн авсан хяналтын хэмжээгээр бүртгэнэ.

7.2.2.Факторингийг шаардах эрхийн хамт худалдан авч байгаа тохиолдолд тухайн факторинг, түүний хуримтлуулсан хүүгийн дансыг бүрэн шилжүүлж авна. Хэрэв фактор эрсдэлийг хэсэгчлэн хүлээх бол (харилцагч эрсдэлийн үлдсэн хэсгийг



хүлээнэ) хүлээж буй эрсдэлд харгалзах хөрөнгийн хэсгийг бүртгэлдээ тусгаж, үлдсэн хэсгийг холбогдох дансанд бүртгэнэ. Хэрэв харилцагч факторингийн авлагыг эргүүлэн төлөхгүй бол алдагдлыг хүлээх талыг гэрээгээр харилцан тохиролцсон байна.

7.2.3. Харилцагч факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлж буй хөрөнгийг худалдахдаа шаардах эрхээ шилжүүлээгүй бөгөөд эрсдэлийг харилцагч өөрөө хүлээх тохиолдолд ТЗЭ нь өр төлбөр үүсгэн бүртгэнэ.

### **7.3. Дансны бичилт**

7.3.1. Факторингийн үйл ажиллагаагаар санхүүжилт олгож, авлага, түүнтэй адилтгах санхүүгийн хөрөнгийг хүлээн авахад:

Дебет: Факторингийн тооцооны авлага

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

7.3.2. Факторингийн үйл ажиллагаа үзүүлснээс шимтгэлийн орлого хүлээн авахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Факторингийн тооцооны шимтгэлийн орлого

7.3.3. Факторингийн үйлчилгээнд хүү тооцож, хуримтлуулахад:

Дебет: Факторингийн тооцооны хүүгийн авлага

Кредит: Факторингийн тооцооны хүүгийн орлого

7.3.4. Факторингийн тооцооноос үүссэн хүүгийн авлага эргэн төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хуримтлуулж тооцсон факторингийн тооцооны хүүгийн авлага

7.3.5. Факторингийн тооцооноос үүссэн авлагыг цуглуулахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Факторингийн тооцооны авлага

7.3.6. Факторингийн тооцоогоор үүссэн авлагын ангиллыг зохих журмын дагуу ангилал бууруулахад:

Дебет: Анхаарал хандуулах факторингийн тооцооны авлага

Кредит: Хэвийн факторингийн тооцооны авлага

7.3.7. Хэрэв факторингийн тооцооны авлагын чанар дараа үеүдэд сайжирвал:

Дебет: Хэвийн факторингийн тооцооны авлага

Кредит: Анхаарал хандуулах факторингийн тооцооны авлага

7.3.8. Факторингийн тооцооны авлагад зээлийн нэгэн адил эрсдэлийн сан байгуулах бөгөөд холбогдох бүртгэлийг “Зээл” бүлгээс үзнэ үү.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ДЕРИВАТИВ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ**

8.1. Дериватив санхүүгийн хэрэгсэл гэж бусад төрлийн ижил төстэй гэрээтэй харьцуулахад анхны хөрөнгө оруулалт бага буюу эсхүл огт шаардагддаггүй,

ирээдүйд хэрэгжихээр хүлээгдэж буй, үнэлгээ нь суурь хүчин зүйлийн үнээс хамаарч өөрчлөгддөг гэрээ, хэлцлийг хэлнэ.

8.2.Хүүгийн түвшин, санхүүгийн хэрэгслийн үнэ, барааны үнэ, гадаад валютын ханш, үнийн индекс, зээлийн зэрэглэл, эсхүл зээлийн индекс гэх мэт үзүүлэлтийг дериватив санхүүгийн хэрэгслийн суурь хүчин зүйлээр тодорхойлно.

### **8.3.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

8.3.1.ТЗЭ нь гэрээ, хэлцэлд тал болон оролцож, хэлцэл хүчин төгөлдөр болсноор хэлцлээр үүссэн авлга, өглөгийг нийт дүнгээр нь хэлцлийн дуусах хугацаа хүртэл тэнцлийн гадуур бүртгэнэ. Харин санхүүгийн тайланд деривативыг хэлцлийн хугацаа дуусах хүртэл хэлцлийг бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэнэ.

8.3.2.Деривативын үнэлгээгээр орлого хүлээн зөвшөөрсөн тохиолдолд дериватив санхүүгийн хөрөнгө, зардал хүлээн зөвшөөрсөн үед дериватив санхүүгийн өглөгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

8.3.3.Деривативын үнэлгээний өөрчлөлтийн олз, гарзыг санхүүгийн тайланд цэвэр дүнгээр толилуулах ба мөн үүний нэгэн адил арилжааны орлого, зардлыг цэвэр дүнгээр тайлагнана.

8.3.4.Деривативыг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь үнэлэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлаар бүртгэнэ. Хэлцэл хийсэн өдөр деривативын бодит үнэ цэнийг тэг гэж үнэлсэн бол уг деривативыг санхүүгийн тайланд харуулахгүй. Деривативын нэрлэсэн дүнг тэнцлийн гадуурх дансанд бүртгэнэ. Хэрэв деривативыг үнэлэх тусгайлсан аргачлал байхгүй бол Монголбанкнаас зарласан ханш эсхүл зах зээлийн ханшийг үнэлгээний сууриар тооцож, үнэлгээ хийнэ. Деривативын хэлцлийн хугацаа дуусах үед эсхүл тухайн арилжааны позици хаагдах хүртэл сард нэгээс доошгүй удаа деривативын бодит үнэ цэнийн үнэлгээг дахин хийж, бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр тохируулан бүртгэнэ.

8.3.5.Деривативын бодит үнэ цэнэ эерэг утгатай гарвал санхүүгийн хөрөнгө, сөрөг утгатай гарвал санхүүгийн өр төлбөр үүснэ.

8.3.6.Санхүүгийн хэрэгсэл, санхүүгийн бус хэлцэлд агуулагдсан нөхцөл, заалт нь бие даасан деривативын нэгэн адил шинжийг хадгалсан бол нуугдмал дериватив болно. Санхүүгийн хэрэгсэлд агуулагдсан боловч тухайн хэрэгслээс салган бусдад шилжүүлэх боломжтой эсхүл энэ нь гуравдагч талтай байгуулсан хэлцэл бол үүнийг нуугдмал дериватив гэж үзэхгүй ба бие даасан тусдаа дериватив болно. Хэрэв нуугдмал деривативыг салгаж бүртгэсэн бол бусад деривативын дансанд бүртгэж, санхүүгийн тайланд тусад нь харуулна.

### **8.4.Хейж**

8.4.1.Дараах шалгууруудыг бүгдийг хангасан гэрээ, хэлцэлийг хейжээр бүртгэж, тайлагнана:

8.4.1.а.Хейжийн эхний өдөр хейжийг тодорхойлж, баримтжуулах ба уг хейжийг хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын зорилго, стратегийг гаргасан байна. Баримтжуулалтад хейжийн хэрэгслийг тодорхойлсон байдал, хейжээр

хамгаалагдсан зүйл эсхүл ажил гүйлгээ, хамгаалагдсан эрсдэл, хейжийн үр өгөөжийг хэрхэн үнэлэх талаар;

8.4.1.б.Тодорхой хейжтэй холбогдуулан анх баримтжуулсан эрсдэлийн удирдлагын стратегийн дагуу хейж хийсэн эрсдэлд хамаарах бодит үнэ цэнэ, мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тухайн хейж үр өгөөжтэйгөөр нөхөж чадна гэж таамагласан;

8.4.1.в.Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд түүнд хамаарах төлөвлөгөөт ажил гүйлгээ хэрэгжих магадлал өндөртэй байх;

8.4.1.г.Хейжийн үр өгөөж, бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой байх.

8.4.1.д.Хейжийг бүртгэх өдөр хейжийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь тэгээс ялгаатай утгатай байх.

8.4.2.Хейжийн үр өгөөжийг тодорхойлохдоо хейжийн хэрэгсэл ба хейжээр хамгаалагдсан зүйлийн бодит үнэ цэнэ буюу мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг хооронд нь харьцуулна. Хейжээр хамгаалагдсан зүйл ба хейжийн хэрэгслийн бодит үнэ цэнийг үнэлэх арга, загварыг ТЗЭ боловсруулж, мөрдөнө.

8.4.3.Хейжийг бодит үнэ цэнийн хейж, мөнгөн гүйлгээний хейж, гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэсэн гурван төрөлд ангилна.

8.4.4.Бодит үнэ цэнийн хейж нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш, зах зээлийн үнэ гэх мэт зарим үзүүлэлт өөрчлөгдсөнөөс шалтгаалан хейжээр хамгаалагдсан зүйлийн бодит үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдэлд хейж хийж, дериватив хэлцэл хийх буюу хейжийн хэрэгсэл гаргахыг хэлнэ.

8.4.5.Бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжээр хамгаалагдсан зүйл ба хейжийн хэрэгслийн аль алиных нь бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тайлант үеийн орлого, зардлаар бүртгэх замаар үүсэх орлого, зардлыг тэнцвэржүүлнэ.

8.4.6.Бодит үнэ цэнийн хейжийг дараах гурван үе шатаар бүртгэнэ:

8.4.6.а.Хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тайлант хугацааны ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогод толилуулахаар сонголт хийсэн өмчийн хэрэглүүрийн хувьд уг хейжийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө.

8.4.6.б.Хейжээр хамгаалсан эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр хааж, тайлант үеийн орлого, зардлаар бүртгэнэ;

8.4.6.в.Хейжээр хамгаалсан эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр хааж, ашиг, алдагдалд эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогод толилуулахаар сонголт хийсэн өмчийн хэрэглүүр байвал уг хейжийн хэрэгслийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө.

8.4.6.г.Үр өгөөжгүй хэсгийг тайлант хугацааны орлого, зардлаар бүртгэнэ.

8.4.7.Мөнгөн гүйлгээний хейж нь хейжээр хамгаалагдсан зүйлийн ирээдүйн мөнгөн гүйлгээ өөрчлөгдөх эрсдэлд хейж хийж, дериватив хэлцэл хийх буюу хейжийн хэрэгсэл гаргахыг хэлнэ.

8.4.8.Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн хэрэгслийн орлого, зардлын үр өгөөжтэй хейж гэж тодорхойлогдсон хэсгийг үнэт цаасны дахин үнэлгээний сан

дансанд, харин үр өгөөжгүй хэсгийг тайлант үеийн орлого, зардалд хүлээн зөвшөөрнө.

8.4.9.Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн бүртгэлийг зогсоосон бол дахин үнэлгээний санд хуримтлуулсан дүнг орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

8.4.10.Гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтын хейж нь гадаад валютын ханш өөрчлөгдөхөд гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтын дансны үнэ өөрчлөгдөх эрсдэлд хейж хийхийг хэлнэ. Энэ хейжийг гадаад дахь охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг гадаад валютаар илэрхийлэгдсэн зээлээр санхүүжүүлэхэд ашиглана.

8.4.11.ТЗЭ-ийн гаргасан өөрийн өмчийн хэрэгсэл нь санхүүгийн өр төлбөр болохгүй тул хейжийн хэрэгсэл болохгүй. Санхүүгийн хэрэгслийг хэсэгчлэн үзэж, тодорхой нэг хэсгийг хейжийн хэрэгсэл гэж тодорхойлж болно. Хүүгийн түвшний свопын нэг хэсгийг өр төлбөрийн хүүгийн түвшний эрсдэлд хамаарах мөнгөн гүйлгээний хейж гэж тодорхойлсон тохиолдолд хейжээр тодорхойлсон хэсэгт харгалзах бодит үнэ цэнийн өсөлт, бууралтыг өмчийн хэсэгт сан байгуулан тусгах ба харин үлдсэн хэсэгт харгалзах өсөлт, бууралтыг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.

8.4.12.Дараах тохиолдолд хейжийн бүртгэлийг зогсооно:

8.4.12.а.Хейжийн хэрэгслийн хугацаа дууссан, хэрэгслийг худалдсан, хэрэгжүүлсэн эсхүл зогсоосон;

8.4.12.б.Тухайн хейж нь хейжийн шалгуурыг хангахаа больсон;

8.4.12.в.Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд төлөвлөж буй ажил гүйлгээ хэрэгжихээ больсон;

8.4.12.г.Тухайн хэрэгслийг хейж гэж үзэхээ больсон.

## **8.5.Дансны бичилт**

### **8.5.1.Форвард хэлцэл**

8.5.1.а.Хэлцлээр хүлээсэн үүргийн дагуу үүсэх форвард арилжааны хөрөнгө, өр төлбөрийн нэрлэсэн дүнг хэлцэл хийсэн өдөр тэнцлийн гадуур бүртгэнэ. Форвард хэлцлийн хугацаа дуусах хүртэл форвард хэлцлээр үүсэх деривативыг бодит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн байдлын тайланд, холбогдох орлого, зардлыг орлогын тайланд толилуулна. Форвард хэлцлийг биелүүлэх буюу хэлцлийн хугацаа дуусахад форвард арилжааны деривативыг хааж, тэнцлийн гадуур бүртгэсэн форвард арилжааны хөрөнгө, өр төлбөрийн дансдыг зарлагадан, арилжааны орлого, зардлыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

8.5.1.б.Гадаад валютыг форвард хэлцлээр худалдан авах арилжаа хийхэд форвард хэлцлийг байгуулсан өдрөөр тэнцлийн гадуур форвард хэлцлийн авлага, өглөгийг бүртгэх ба форвард хэлцлийн хугацаа дуусах буюу позици хаагдахад тэнцлийн гадуурх авлага, өглөгийг зарлагадна. Санхүүгийн тайлагналын өдрөөр форвард хэлцлийн бодит үнэ цэнийг үнэлж, бодит үнэ цэнэ эерэг гарсан тохиолдолд хөрөнгө, сөрөг гарсан тохиолдолд өр төлбөр бүртгэнэ.

Санхүүгийн тайлагналын өдөр деривативын бодит үнэ цэнэ сөрөг гарсан тохиолдолд форвард хэлцлийн өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн гарз

Кредит: Форвард арилжаа (өр төлбөр)

Санхүүгийн тайлагналын өдөр деривативын бодит үнэ цэнэ эерэг гарсан тохиолдолд форвард хэлцлийн хөрөнгө хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Форвард арилжаа (хөрөнгө)

Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн олз

8.5.1.в.Форвард хэлцлийн хугацаа дуусахад худалдан авах валютын хэлцлийн дүнгээр холбогдох гадаад валютын дансыг нэмэгдүүлж, худалдах валютын гэрээнд заасан ханшаар илэрхийлсэн дүнгээр холбогдох мөнгөн хөрөнгийн дансыг бууруулахад:

Худалдан авах валютын хувьд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн гадаад валютын холбогдох данс

Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Худалдах валют буюу төгрөгийн хувьд:

Дебет: Валют хөрвүүлэлтийн түр данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

8.5.1.г.Форвард арилжаа дансны үлдэгдлийг дээрх гүйлгээнээс үүссэн валют хөрвүүлэлтийн түр дансанд хаахад:

Форвард арилжааны данс кредит үлдэгдэлтэй бол:

Дебет: Форвард арилжаа

Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Форвард арилжааны данс дебет үлдэгдэлтэй бол:

Дебет: Валют хөрвүүлэлтийн түр данс

Кредит: Форвард арилжаа

8.5.1.д.Дээрх бичилтүүд хийгдсэний дараа валют хөрвүүлэлтийн түр дансны үлдэгдлээр арилжааны үр дүнг тодорхойлоход:

Хэрэв ашигтай бол:

Дебет: Валют хөрвүүлэлтийн түр данс

Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв алдагдалтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зардал

Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Дээрх гүйлгээнүүдийн үр дүнд валют хөрвүүлэлтийн түр данс болон тухайн хэлцэлтэй холбоотой үүссэн форвард арилжааны данс үлдэгдэлгүй болно.

8.5.1.е.Арилжааны позицийг хаах үед гадаад валютын хэрэгжээгүй (цэвэр) орлого, зардалд бүртгэсэн деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг гадаад валютын арилжааны хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэхэд:

Хэрэгжээгүй цэвэр орлогын хувьд:

Дебет: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн олз (хэрэгжээгүй)

Кредит: Гадаад валютын арилжааны орлого (хэрэгжсэн)

Хэрэгжээгүй цэвэр зардлын хувьд:

Дебет: Гадаад валютын арилжааны зардал (хэрэгжсэн)

Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн гарз (хэрэгжээгүй)

8.5.1.ё.Гадаад валютыг форвард хэлцлээр худалдах, арилжаа хийхэд дээрх худалдан авах арилжааны бичилтийн урвуугаар бүртгэнэ.

### **8.5.2.Своп хэлцэл**

8.5.2.а.Гадаад валютын своп хэлцлийн эхний арилжааг спот арилжааны нэгэн адил бүртгэж, үүссэн арилжааны зөрүүг орлого, зардлаар бүртгэнэ. Своп хэлцлийн хугацаа дуусах хүртэл хэлцлээр үүсэх деривативыг бодит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн хөрөнгө эсхүл санхүүгийн өр төлбөрөөр тайлагнах ба холбогдох орлого, зардлыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Своп хэлцлээр хийгдэх хоёр дахь арилжааг форвард арилжааны нэгэн адил бүртгэхэд:

Своп хэлцлийн дагуу эхний арилжааг бүртгэхдээ худалдсан валютын дүнгээр:

Дебет: Валют хөрвүүлэлтийн түр данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Худалдан авсан валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

8.5.2.б.Своп позици хаах хүртэл хэлцлийн хоёр дахь арилжаагаар төлөгдөхөөр зөвшөөрсөн ирээдүйн мөнгөн гүйлгээний нэрлэсэн дүнг тэнцлийн гадуур бүртгэнэ.

8.5.2.в.Тайлагналын өдөр (сарын эцэст) своп хэлцлийн бодит үнэ цэнийг тооцоолж, деривативын бодит үнэ цэнээр хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрч, бүртгэхэд:

Санхүүгийн тайлагналын өдөр деривативын бодит үнэ цэнэ сөрөг гарсан тохиолдолд валютын своп хэлцлийн деривативыг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн гарз

Кредит: Валютын своп арилжаа

Санхүүгийн тайлагналын өдөр деривативын бодит үнэ цэнэ эерэг гарсан тохиолдолд валютын своп хэлцлийн деривативыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Валютын своп арилжаа

Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн олз

8.5.2.г.Своп хэлцлийн дагуу хоёр дахь арилжааг бүртгэхдээ хэлцлийн гэрээгээр худалдан авах валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Хэлцлээр худалдах гадаад валютын дүнгээр:

Дебет: Валют хөрвүүлэлтийн түр данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

8.5.2.д.Своп арилжаа дансны үлдэгдлийг дээрх гүйлгээнээс үүссэн валют хөрвүүлэлтийн түр дансанд хаах үед:

Своп арилжааны данс кредит үлдэгдэлтэй бол:  
Дебет: Валютын своп арилжаа  
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Своп арилжааны данс дебет үлдэгдэлтэй бол:  
Дебет: Валют хөрвүүлэлтийн түр данс  
Кредит: Валютын своп арилжаа

Дээрх бичилтүүд хийгдсэний дараа валют хөрвүүлэлтийн түр дансны үлдэгдлээр арилжааны үр дүн тодорхойлогдоно:

Хэрэв ашигтай бол:  
Дебет: Валютын своп арилжааны түр данс  
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв алдагдалтай бол:  
Дебет: Гадаад валютын арилжааны зардал  
Кредит: Валютын своп арилжааны түр данс

Хоёр дахь арилжааны үед нэрлэсэн дүнгээр тэнцлийн гадуур бүртгэсэн дансдыг зарлагадна.

8.5.2.е.Гадаад валютын хэрэгжээгүй орлого, зардалд бүртгэсэн деривативын бодит үнэ цэнд гарсан өөрчлөлтийг гадаад валютын арилжааны хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ:

Хэрэгжээгүй цэвэр орлогын хувьд:  
Дебет: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн олз  
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэгжээгүй цэвэр зардлын хувьд:  
Дебет: Гадаад валютын арилжааны зардал  
Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн гарз

### **8.5.3.Опшин хэлцэл**

8.5.3.а.Хэлцэл байгуулсан өдрөөр опшин хэлцэлд заасан худалдах ба худалдан авах дүнгээр тэнцлийн гадуурх дансанд өглөг, авлага бүртгэнэ. Хэлцэл хийсэн өдрөөр опшин арилжааны премиумыг деривативаар бүртгэж (премиум төлсөн бол хөрөнгө, премиум авсан бол өр төлбөр бүртгэнэ), хэлцлийн хугацаа дуусах буюу тухайн опшин хэрэгжих хүртэл дахин үнэлж, үнэлгээний зөрүү (деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлт)-г тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Хэлцлийн хугацаа дуусах буюу тухайн опшин хэрэгжих үед опшины деривативыг хааж, арилжааны эцсийн үр дүнг орлого, зардалд хүлээн зөвшөөрч, тэнцлийн гадуурх дансанд бүртгэсэн дүнг зарлагадна.

8.5.3.б.Гадаад валют арилжааны эрхийг худалдахдаа дараах байдлаар бүртгэнэ:

Хэрэв гадаад валютын опшин хэлцлийн эрхийг худалдсан бол авсан дүнгээр опшин арилжааны дансанд бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Опшин арилжаа

Хэрэв опшиныг дахин үнэлэх үед бодит үнэ хэлцлийн үнээс давсан бол:

Дебет: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн гарз  
Кредит: Опшин арилжаа

Хэрэв опшиныг дахин үнэлэх үед бодит үнэ хэлцлийн үнээс бага бол:

Дебет: Опшин арилжаа  
Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн олз

8.5.3.в.Хэлцэл биелсэн үед гэрээгээр худалдан авах валютын дүнгээр:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Худалдах валют, үнэт металлын дүнгээр:

Дебет: Валют хөрвүүлэлтийн түр данс  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Валютын опшин арилжааны дансыг валют хөрвүүлэлтийн түр дансанд хаах үед:

Дебет: Опшин арилжаа  
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

Дээрх гүйлгээ хийгдсэний дараа тухайн арилжааны үр дүнг тооцох үед:

Хэрэв ашигтай бол:

Дебет: Валют хөрвүүлэлтийн түр данс  
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

Хэрэв алдагдалтай бол:

Дебет: Гадаад валютын арилжааны зардал  
Кредит: Валют хөрвүүлэлтийн түр данс

8.5.3.г.Хэлцэл биелээгүй бол зөвхөн премиумын дансыг орлогод хааж хэрэгжээгүй орлого, зардлыг хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэхэд:

Дебет: Опшин арилжаа  
Кредит: Гадаад валютын арилжааны орлого

8.5.3.д.Гадаад валют арилжааны эрхийг худалдан авахад дээрх худалдах бичилтийн урвуугаар бүртгэнэ.

#### **8.5.4.Хейж**

8.5.4.а.Хейжийн үр нөлөөгөөр тодорхойлогдсон хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжиж, бүртгэнэ:

Хейжийн хэрэгсэл болгон гаргасан дериватив нь санхүүгийн хөрөнгө бол:

Дебет: Холбогдох деривативын данс (хөрөнгө)  
Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн олз



Хейжийн хэрэгсэл болгон гаргасан дериватив нь санхүүгийн өр төлбөр бол:  
Дебет: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн гарз  
Кредит: Холбогдох деривативын данс (өр төлбөр)

8.5.4.б.Бодит үнэ цэнийн хейжийн хувьд санхүүгийн тайлагналын өдөр хейжийн хэрэгслийн үнэлгээний өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө:

Хэрэв санхүүгийн тайлагналын өдөр деривативын бодит үнэ цэнэ буурсан бол:  
Дебет: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн гарз  
Кредит: Холбогдох деривативын данс (хөрөнгө)

Хэрэв санхүүгийн тайлагналын өдөр деривативын бодит үнэ цэнэ өссөн бол:  
Дебет: Холбогдох деривативын данс (хөрөнгө)  
Кредит: Деривативын бодит үнэ цэнийн үнэлгээний өөрчлөлтийн олз

Хэрэв деривативыг анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн өр төлбөр үүссэн бол дээрх бичилтийн урвуугаар бүртгэнэ.

8.5.4.в.Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд санхүүгийн тайлагналын өдөр хейжийн хэрэгслийн үнэлгээний өөрчлөлтийн үр өгөөжтэй ба үр өгөөжгүй хэсгийг ялгаатай бүртгэнэ:

Деривативын бодит үнэ цэнэ буурсан бол уг бууралтын үр өгөөжтэй хэсгийг бусад дэлгэрэнгүй орлогод тусган, хейжийн дахин үнэлгээний санд бүртгэж, өөрийн хөрөнгөөр тайлагнахад:

Дебет: Өмчийн бусад хэсэг (Хейжийн дахин үнэлгээний сан)  
Кредит: Холбогдох деривативын данс (хөрөнгө)

Деривативын бодит үнэ цэнийн бууралтын үр өгөөжгүй хэсгийг зардалд бүртгэхэд:

Дебет: Гадаад валютын ханшийн зөрүүний гарз эсхүл холбогдох зардлын данс  
Кредит: Холбогдох деривативын данс (хөрөнгө)

8.5.4.г.Хэрэв деривативын бодит үнэ цэнэ өссөн бол уг өсөлтийн үр өгөөжтэй хэсгийг бүртгэхэд:

Дебет: Холбогдох деривативын данс (хөрөнгө)  
Кредит: Өмчийн бусад хэсэг (Хейжийн дахин үнэлгээний сан)

Деривативын бодит үнэ цэнийн өсөлтийн үр өгөөжгүй хэсгийг бүртгэхэд:

Дебет: Холбогдох деривативын данс (хөрөнгө)  
Кредит: Гадаад валютын ханшийн зөрүүний олз эсхүл холбогдох орлогын данс

8.5.4.д.Хэрэв деривативыг анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн өр төлбөр үүссэн бол дээрх бичилтийн урвуугаар бүртгэнэ.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**

9.1.Бусад санхүүгийн хөрөнгө гэж бусад аж ахуйн нэгжээс мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрхийг хэлнэ. Хэрэв мөнгө болон санхүүгийн

бусад хөрөнгийг авах гэрээний эрх үүсээгүй тохиолдолд уг хөрөнгийг бусад санхүүгийн бус хөрөнгө гэж үзнэ.

9.2.Зээлээс бусад тооцооны авлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага, салбар хоорондын тооцоо, өмчлөх бусад хөрөнгө (зээлдэгчээс зээлийн төлбөрт авсан үнэт цаас гэх мэт санхүүгийн хөрөнгө), бусад санхүүгийн хөрөнгийг хамруулна.

9.3.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны авлага, санхүүгийн хөрөнгө хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгийг энэ журмын "Хөрөнгө оруулалт" бүлэгт заасны дагуу хэмжиж, бүртгэнэ.

#### **9.4.Авлага хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

9.4.1.Авлагыг эрсдэлийн санг хассан цэвэр дүнтэй тэнцэх хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

9.4.2.Гадаад валютаар төлөгдөх авлагыг Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар хүлээн зөвшөөрнө.

#### **9.5. Авлагын дансны бичилт**

9.5.1.Иргэн, хуулийн этгээд тус бүрээр нэрийн данс нээж хөтөлнө. Авлагын дансны үлдэгдэл нь түр хугацааны шинж чанартай бөгөөд эцсийн тооцоо хийгдэхэд хаагдана:

9.5.1.а.Авлагыг хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Авлагын холбогдох данс

Кредит: Мөнгөн хөрөнгө эсхүл холбогдох данс

9.5.1.б.Авлага төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгө эсхүл холбогдох данс

Кредит: Авлагын холбогдох данс

9.5.1.в.Авлагад эрсдэлийн сан байгуулахад:

Дебет: Авлагын эрсдэлийн зардал

Кредит: Авлагын эрсдэлийн сан

9.5.1.г.Авлага төлөгдсөн дүнгээр түүнд байгуулсан эрсдэлийн санг буцаахад:

Дебет: Авлагын эрсдэлийн сан

Кредит: Авлагын эрсдэлийн сангийн зардал эсхүл Бусад орлого

9.5.1.д.Авлагыг төлүүлж авч чадахгүй бол холбогдох журам, удирдлагын шийдвэрийг үндэслэн эрсдэлийн сангаас хаахад:

Дебет: Авлагын эрсдэлийн сан

Кредит: Авлагын холбогдох данс

9.5.1.е.Эрсдэлийн сангаас хасагдсан авлага төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгө эсхүл холбогдох данс

Кредит: Бусад орлого - Эрсдэлийн сангаас хаагдсан авлагын эргэн төлөлт

## **9.6.Салбар хоорондын тооцооны хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

9.6.1.Салбар хоорондын тооцоог төв, салбар хооронд хийгдсэн дүнгээр хэмжинэ. Тайлагналын өдрөөр төв болон салбар хоорондын авлага, өглөгийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тайлагнана.

## **9.7.Салбар хоорондын тооцооны дансны бичилт**

9.7.1.Салбар хоорондын тооцоо нь зөвхөн төвөөр дамжиж хийгдэнэ. Салбар хоорондын тооцоо нь бэлэн ба бэлэн бус хэлбэртэй байж болно. Салбар хоорондын тооцоогоор үүссэн өглөг, авлагыг салбар нэгж бүр дээр нэрийн данс нээж бүртгэнэ. Салбар хоорондын тооцооны данс дебет, кредит хоёр үлдэгдэлтэй байвал үлдэгдлүүдийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тайлагнана.

9.7.1.а.Харилцагчийн болон дотоодын төлбөрийг салбар хоорондын тооцоогоор шилжүүлэхэд:

Дебет: Харилцагчийн харилцах данс ба холбогдох данс  
Кредит: Салбар хоорондын тооцооны авлага

9.7.1.б.Төлбөрийг хүлээж авсан нэгж нь:

Дебет: Салбар хоорондын тооцооны өглөг  
Кредит: Харилцагчийн харилцах данс ба холбогдох данс

## **АРАВДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ**

10.1.Санхүүгийн бус хөрөнгө гэж үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт хөрөнгийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй хөрөнгийг хэлнэ.

10.2.Санхүүгийн бус хөрөнгөд урьдчилж төлсөн зардал, тооцоо, бараа материал, үнэ бүхий зүйлс, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, тайлант үеийн татварын авлага, хойшлогдсон татварын хөрөнгө, өмчлөх бусад хөрөнгө (хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө), үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө зэрэг хамаарна.

10.3.Татвар, НДШ-ийн авлагыг татвар, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнгээр бүртгэнэ. Тайлагналын өдрөөр татварын төрлөөр авлага, өглөгийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тайлагнана. Тайлант хугацааны татварын илүү төлөлт (авлага) болон хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжих талаар энэ журмын "Орлогын албан татвар" бүлгээс үзнэ үү.

## **10.4. Урьдчилж төлсөн зардал, тооцоо хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

10.4.1.Урьдчилгаа нь урьдчилж төлсөн зардал болон урьдчилж төлсөн тооцооноос бүрдэнэ. Урьдчилгааг төлсөн мөнгөн дүнгээр хэмжинэ.

## **10.5.Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны бичилт**

10.5.1.Хөрөнгийг худалдан авч, олж бэлтгэхтэй холбоотой урьдчилгаа төлбөр болон томилолтын зардлыг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэнэ. Хөрөнгийг

хүлээж авсан, томилолтын тооцоог хийсэн үед урьдчилгаа тооцоог хааж, холбогдох хөрөнгө эсхүл зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ:

10.5.1.а.Ажилтнууд албан үүрэг гүйцэтгэх, сургалт, семинарт хамрагдахаар гадаад, дотоодод томилолтоор явахад удирдлагын шийдвэрийн дагуу гарах зардлыг урьдчилан олгоход:

Дебет: Дараа тайлангийн тооцоо

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

10.5.1.б.Томилолтын тайлан, зардлын баримтыг үндэслэн тооцоо хийж, холбогдох зардлаар хаахад:

Дебет: Зардлын холбогдох данс

Кредит: Дараа тайлангийн тооцоо

Томилолтын тооцоогоор урьдчилгаанаас илүү, дутуу зарцуулсан бол зөрүүг нэмж олгох буюу буцааж авна.

10.5.1.в.Бараа, үйлчилгээг хүлээн аваагүй тохиолдолд төлбөрийг буцаахад:

Дебет: Урьдчилж төлсөн тооцоо

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

10.5.1.г.Бараа, үйлчилгээг хүлээж авсан үед урьдчилгаа тооцоог хааж, хүлээн авсан хөрөнгийн дүнгээр:

Дебет: Холбогдох хөрөнгө эсхүл зардал

Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

10.5.2.Хөрөнгийг худалдан авч, олж бэлтгэх урьдчилгаа төлсөн тооцоо үүссэн тохиолдолд бэлтгэн нийлүүлэгч тал үүргээ биелүүлэхгүй нөхцөл байдал үүсвэл урьдчилж төлсөн тооцоо дансны ангиллыг өөрчилж, авлагаар бүртгэнэ:

Дебет: Авлагын холбогдох данс

Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

10.5.3.Зардлыг урьдчилан төлсөн тохиолдолд урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэх ба хэрэгжсэн үед нь холбогдох тайлант хугацааны зардлаар бүртгэнэ:

10.5.3.а.Байгууллага, хүмүүстэй хийсэн гэрээгээр үйл ажиллагааны зардлыг урьдчилан төлбөл урьдчилж төлсөн зардлаар бүртгэхэд:

Дебет: Урьдчилж төлсөн зардал

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

10.5.3.б.Зардал хэрэгжсэн үед урьдчилж төлсөн зардлыг бууруулахад:

Дебет: Зардлын холбогдох данс

Кредит: Урьдчилж төлсөн зардал

## **10.6.Бараа материал, үнэ бүхий зүйлийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

10.6.1.Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа, хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө бараа материалд хамрагдана.

10.6.2. Бараа материалд бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал багтана.

10.6.3. Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжиж, бүртгэнэ. Цэвэр боломжит үнэ цэнэ гэж хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгох ба борлуулах, сольж арилжих, хуваарилахад шаардлагатай тооцоолсон өртөг, зардлыг хассан дүнг хэлнэ. Цэвэр боломжит үнэ цэнийн үнэлгээг тайлагналын өдрөөр гүйцэтгэнэ.

10.6.4. Бараа материал, үнэ бүхий зүйлийн зарцуулалтыг эхэлж авсныг эхэлж зарлагадах эсхүл дундаж өртгийн аргаар тооцно.

10.6.5. Гадаад валютаар худалдан авсан материал хангамжийн зүйлийг бүртгэлд тусгах өдрийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэнэ. Мөнгөн бус зүйлийн хувьд ханшийн зөрүүгээр тохируулга хийхгүй.

## **10.7. Бараа материал, үнэ бүхий зүйлийн дансны бичилт**

10.7.1. Материал, үнэ бүхий зүйлс худалдаж авахад:

Дебет: Материал, үнэ бүхий зүйл

Кредит: Мөнгөн хөрөнгө эсхүл тооцооны холбогдох данс

10.7.2. Материал, үнэ бүхий зүйлийн зарцуулалтын тайланг үндэслэн түүнийг зардалд бүртгэхэд:

Дебет: Зардлын холбогдох данс

Кредит: Материал, үнэ бүхий зүйл

10.7.3. Хэрэв материал, хангамжийн зүйлсийг ашиглалтад шууд тавьж олгосон бол шууд зардалд бүртгэхэд:

Дебет: Үйл ажиллагааны зардал – Материал хангамжийн зардал

Кредит: Мөнгөн хөрөнгө эсхүл тооцооны холбогдох данс

## **10.8. Өмчлөх бусад хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

10.8.1. Зээлдэгч гэрээний нөхцөлийг зөрчиж, барьцаа хөрөнгийг өмчлөх эрхийг ТЗЭ-д шилжүүлсэн буюу зээл, авлагыг барагдуулах зорилгоор ТЗЭ нь зээлдэгчтэй байгуулсан гэрээнд барьцаа болгон заасан хөрөнгийн эзэмших, өмчлөх, захиран зарцуулах эрхийг шилжүүлэн авсан бол өмчлөх бусад хөрөнгөөр бүртгэнэ.

10.8.2. Өмчлөх бусад хөрөнгийг холбогдох зээл, хуримтлуулсан хүүгийн авлагын нийт дүн ба (барьцаат хөрөнгийг борлуулаад орох орлогыг зээлийн дүнгээр хязгаарласан нөхцөлд) уг хөрөнгийн тухайн үеийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар нь анх үнэлж, бүртгэнэ.

10.8.3. Зээл, түүнд хамаарах авлагын (хүү ба шимтгэл) дүн нь өмчлөх бусад хөрөнгийн зах зээлийн үнээс их байгаа тохиолдолд өмчлөх бусад хөрөнгийг бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгээр бүртгэж, зээл, түүнд хамаарах авлагын дүнг мөн энэ хэмжээ хүртэл бууруулна. Эдгээрийн зөрүүг өмчлөх бусад хөрөнгийн зардалд бүртгэж, орлогын тайланд толилуулна.

10.8.4.ТЗЭ өмчлөх бусад хөрөнгийн төрөл, ангиллаас шалтгаалан хөрөнгийг данснаас хасах шалгуурыг хангасан эсэхийг шалгана. Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах, засварлах, хадгалах, хамгаалахтай холбогдон гарах урсгал зардлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

10.8.5.Өмчлөх бусад хөрөнгийг засварласны үр дүнд түүний хүчин чадал, чанар сайжирч, үнэ цэнэ нь материаллаг дүнгээр өсөж байвал холбогдох засварын зардлыг хөрөнгийн өртөгт шингээж бүртгэнэ.

10.8.6.Өмчлөх бусад хөрөнгийг борлуулахад үүсэх олз, гарзыг гарсан тайлант хугацаанд хүлээн зөвшөөрнө.

10.8.7.ТЗЭ нь хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгийг худалдан борлуулах, өөрөө ашиглах эсхүл эдийн засгийн өгөөж авах зорилгоор эзэмших эсэхээ хараахан шийдээгүй тохиолдолд өмчлөх хөрөнгийн харгалзах дансанд бүртгэнэ.

10.8.8.Үл хөдлөх хөрөнгийг (барилга байгууламж) ашиглахаар шийдвэрлэсэн бол өмчлөх бусад хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, ангиллыг өөрчилнө. Хэрэв өөрөө ашиглалгүйгээр бусдад түрээслүүлэх болон капиталын өгөөж хүртэх зорилгоор барилга байгууламжийг эзэмшилдээ үлдээхээр шийдвэрлэсэн бол өмчлөх бусад хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дансанд шилжүүлж, ангиллыг өөрчилнө.

10.8.9.Өмчлөх бусад хөрөнгө байдлаар олж эзэмшсэн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулахаар шийдвэрлэсэн бол уг хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө дансанд шилжүүлж, ангиллыг өөрчилнө. Хэрэв борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөд бүртгэсэн хөрөнгө нь холбогдох тодорхойлолтын шаардлагыг хангахгүй тохиолдолд уг хөрөнгийг өмчлөх бусад хөрөнгөнд буцаан бүртгэнэ.

10.8.10.Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралт буюу эрсдэлийн санг энэ холбогдох активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын дагуу хэмжиж, бүртгэнэ.

## **10.9.Өмчлөх бусад хөрөнгийн дансны бичилт**

10.9.1.Барьцаа хөрөнгийг эзэмшсэн тохиолдолд тэнцлийн гадуурх барьцаа хөрөнгө данснаас уг хөрөнгийг зарлагадаж, өмчлөх бусад хөрөнгөөр бүртгэхэд:

Дебет: Өмчлөх бусад хөрөнгө

Кредит: Холбогдох зээл, авлагын данс

10.9.2.Өмчлөх бусад хөрөнгөнд эрсдэлийн сан байгуулахад:

Дебет: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал

Кредит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан

10.9.3.Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах, засварлах, хадгалах, хамгаалахтай холбогдон гарах урсгал зардлыг бүртгэхэд:

Дебет: Өмчлөх бусад хөрөнгийн урсгал зардал

Кредит: Мөнгөн хөрөнгө эсхүл бусад холбогдох данс

10.9.4.Өмчлөх бусад хөрөнгийг засварлах зардлыг өртөгт шингээхэд:

Дебет: Өмчлөх бусад хөрөнгө  
Кредит: Мөнгөн хөрөнгө эсхүл бусад холбогдох данс

10.9.5.Өмчлөх бусад хөрөнгийг худалдахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Дебет: Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сан  
Дебет: Эрсдэлийн сангийн нөөц  
Кредит: Өмчлөх бусад хөрөнгө

10.9.6.Өмчлөх бусад хөрөнгийг олзтой худалдсан тохиолдолд дансны үнээс хэтэрсэн зөрүүг бусад орлого-хөрөнгө борлуулалтын олз дансанд бүртгэнэ. Өмчлөх бусад хөрөнгийг гарзтай худалдсан үед дансны үнийн хэтэрсэн зөрүүг бусад зардал-хөрөнгө борлуулалтын гарз дансанд бүртгэнэ.

10.9.7 Худалдсан өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн санг буцаахад:

Дебет: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан  
Кредит: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал эсхүл бусад орлого

10.9.8.Өмчлөх бусад хөрөнгийг борлуулах боломжгүй бол холбогдох журамд заасны дагуу удирдлагын шийдвэрээр данснаас хасахад:

Дебет: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан  
Кредит: Өмчлөх бусад хөрөнгө

## **АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДСЭН ХӨРӨНГӨ**

11.1.Үндсэн хөрөнгө гэж бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслэх эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа, нэг жилээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй, биет хөрөнгө юм.

11.2.Үндсэн хөрөнгийг нийтлэг шинж чанар, зориулалтаар нь барилга байгууламж, компьютер дагалдах хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө гэж ангилна.

### **11.3.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

11.3.1.Хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд худалдан борлуулах зориулалтгүй хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

11.3.2.Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь хөнгөлөлт ба үнийн бууралтыг хассан үнэ, импортын татвар ба буцаан үл олгогдох худалдан авалтын татвар, хөрөнгийг ашиглах боломжтой байршил болон нөхцөл байдалд авчрахтай шууд хамааралтай зардал, үндсэн хөрөнгийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах тооцоолсон зардал зэргээс бүрдэнэ.

11.3.3.Үндсэн хөрөнгийг өртгийн загвар ба дахин үнэлгээний загварын аль нэгээр бүртгэнэ. Өртгийн загвар нь хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнийн цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд

толилуулна. Дахин үнэлгээний загвар нь хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээс хуримтлагдсан элэгдэл, үнийн цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд толилуулна.

#### **11.4.Үндсэн хөрөнгийн элэгдэл, үнэ цэнийн бууралт**

11.4.1.Хөрөнгийн өгөөжийг хэрхэн хүртэхийг харгалзан үзсэний үндсэн дээр удирдлагын бодлого, шийдвэрээр үндсэн хөрөнгийг ашиглах зохистой хугацааг тогтоож, элэгдэл тооцох тохиромжтой аргыг сонгоно. Хөрөнгийн элэгдүүлэх дүнг тооцохдоо хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст үлдэх үнэ цэнийг хасаж тодорхойлно:

11.4.1.а.Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна;

11.4.1.б.Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгөнд элэгдэл байгуулахгүй;

11.4.1.в.Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг, ашиглалтын хугацаа, элэгдүүлэх арга өөрчлөгдвөл нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзээд гүйцээх горимоор бүртгэнэ;

11.4.1.г.Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах бүртгэлийн бодлого нь татварын хуулиар тогтоосон хувь хэмжээнээс зөрүүтэй бол зөрүүг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрөөр бүртгэж, тайлагнана.

11.4.2.Санхүүгийн тайлангийн өдрөөр үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тогтооно. Хэрэв үнэ цэнэ буурсан гэх нотолгоо байгаа бол тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолж, дансны үнэтэй харьцуулан, үнэ цэнийн бууралтыг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх дүн гэж хөрөнгийн буюу мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба ашиглалтын үнэ цэнийн аль ихийг хэлнэ. Хөрөнгийн дансны үнэ нөхөгдөх дүнгээс хэтэрсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Хэрэв үнэ цэнийн бууралтын алдагдал байхгүй гэх нотолгоо байгаа бол үнэ цэнийн бууралтыг буцааж болох ба буцаалт нь хуримтлагдсан үнэ цэнийн бууралтаас хэтрэхгүй.

#### **11.5.Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ**

11.5.1.Үндсэн хөрөнгийн тодорхой бүлэгт багтсан хөрөнгийг дахин үнэлж байгаа тохиолдолд тухайн бүлэгт багтсан үндсэн хөрөнгийг дахин үнэлнэ. Үндсэн хөрөнгийн бүлэг гэж хөрөнгийг ижил төстэй шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь бүлэглэхийг хэлнэ. Үндсэн хөрөнгийн дараах бүлгүүд байж болно. Үүнд: газар, барилга, тавилга эд хогшил, оффисын төхөөрөмж гэх мэт.

11.5.2.Дахин үнэлгээний үед хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтыг тусгасан бодит үнэ цэнийг илтгэх дүнгээр үнэлнэ. Энэ тохиолдолд тодорхой хугацааны давтамжтайгаар дахин үнэлгээг үргэлжлүүлэн хийх ба дахин үнэлгээг хийх үйл явц нь хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаална. Хөрөнгийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү үүсэж байвал зайлшгүй дахин үнэлгээг хийнэ. Зах зээлийн үнэ харьцангуй тогтвортой байдаг нөхцөлд 3-5 жил тутамд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ.

11.5.3.Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнээр үнэлэх боломжгүй тохиолдолд өртгийн загвараар бүртгэнэ.



## 11.6.Дансны бичилт

11.6.1.Үндсэн хөрөнгийг худалдан авахад өртгөөр нь бүртгэх ба хэд хэдэн үндсэн хөрөнгийг багцаар худалдан авсан бол харгалзах бодит үнэ цэнээр нь өртгийг хуваарилахад:

Дебет: Үндсэн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

11.6.2.Барилга, байгууламжийг өөрөө барьж байгуулж байгаа тохиолдолд холбогдох өртгийг дуусаагүй барилга дансанд хуримтлуулахад:

Дебет: Үндсэн хөрөнгө - Дуусаагүй барилга  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

11.6.3.Дуусаагүй барилгаа үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлэхэд:

Дебет: Үндсэн хөрөнгө - Барилга байгууламж  
Кредит: Үндсэн хөрөнгө - Дуусаагүй барилга

11.6.4.Зээлийн эх үүсвэрээр олж бэлтгэсэн хөрөнгийн өртгийг капиталжуулахад:

Дебет: Дуусаагүй барилга эсхүл Биет бус хөрөнгө  
Кредит: Хүүгийн зардал

11.6.5.Хэрэв хөрөнгийн солилцоо арилжааны шинж чанартай бол авсан хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд уг хөрөнгийг тухайн өдрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Харин авсан хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй тохиолдолд уг хөрөнгийг өгсөн хөрөнгийн дансны үнээр хэмжинэ. Мөн солилцооны ажил гүйлгээ нь арилжааны бус шинж чанартай бол авсан хөрөнгийг өгсөн хөрөнгийн дансны үнээр хэмжиж, бүртгэхэд:

Дебет: Үндсэн хөрөнгө (авсан хөрөнгө)  
Дебет: Хуримтлагдсан элэгдлийн данс  
Кредит: Үндсэн хөрөнгө (өгсөн хөрөнгө)

11.6.6.Үндсэн хөрөнгийн үнэ, холбогдох зардлыг урьдчилж төлсөн боловч үндсэн хөрөнгийг биетээр хүлээж аваагүй бол санхүүжилтийн дансанд бүртгэх ба хөрөнгийг хүлээн авахад уг дансыг хааж бүртгэхэд:

11.6.6.а.Хөрөнгийн төлбөрийг урьдчилж төлөхөд:

Дебет: Үндсэн хөрөнгийн санхүүжилт  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох дансд

11.6.6.б.Үндсэн хөрөнгийг хүлээж авахад:

Дебет: Үндсэн хөрөнгө  
Кредит: Үндсэн хөрөнгийн санхүүжилт

11.6.7.Санхүүгийн түрээсийн гэрээгээр хөрөнгө авсан нөхцөлд хөрөнгийг хүлээн авахаар гэрээнд заасан өдөр холбогдох үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Харин түрээсийн хугацаанд хөрөнгийг ашиглах эрхтэй хөрөнгөөр бүртгэж, тайлагнана.

11.6.7.а.Санхүүгийн түрээсийн гэрээгээр хөрөнгө авахад:

Дебет: Ашиглах эрхтэй хөрөнгө  
Кредит: Санхүүгийн түрээсийн өглөг

11.6.7.б.Түрээсийн төлбөрийг төлөх үед:  
Дебет: Санхүүгийн түрээсийн өглөг  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

11.6.7.в.Ашиглах эрхтэй хөрөнгөд элэгдэл тооцох үед:  
Дебет: Элэгдэл, хорогдлын зардал  
Кредит: Хуримтлагдсан хорогдол (ашиглах эрхтэй хөрөнгө)

11.6.8.Үндсэн хөрөнгийн ашиглалтын явцад гарсан зардал нь хөрөнгийн ерөнхий чанарыг сайжруулж, анх тогтоосон бүтээмжийг дээшлүүлж, ирээдүйд хүртэх өгөөжийг нэмэгдүүлж байвал ийм зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулж бүртгэнэ. Энэ шинжийг агуулаагүй бусад бүх засвар, үйлчилгээний урсгал зардлыг тайлант үеийн зардалд бүртгэнэ.

11.6.8.а.Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зардлыг капиталжуулахад:  
Дебет: Үндсэн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Мөнгөн хөрөнгө ба тооцооны холбогдох данс

11.6.8.б.Үндсэн хөрөнгөтэй холбоотой зардлыг тайлант үеийн зардлаар бүртгэхэд:  
Дебет: Засвар, үйлчилгээний урсгал зардал  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

11.6.9.Үндсэн хөрөнгийн элэгдэл, үнэ цэнийн бууралтыг бүртгэх үед дараах байдлаар бүртгэнэ:

11.6.9.а.Үндсэн хөрөнгийн элэгдлийг бүртгэхдээ:  
Дебет: Элэгдлийн зардал  
Кредит: Хуримтлагдсан элэгдлийн данс

11.6.9.б.Үнэ цэнийн бууралтын зардлыг бүртгэхэд:  
Дебет: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал  
Кредит: Хуримтлагдсан элэгдлийн данс

11.6.9.в.Хөрөнгийн үнэ цэнийн бууралт нь дахин үнэлгээний нэмэгдлээс хэтэрсэн бол хэтэрсэн зөрүүг бүртгэхэд:

Дебет: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал  
Кредит: Хуримтлагдсан элэгдлийн данс

11.6.10.Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн үнэлгээ өссөн тохиолдолд уг өсөлтийг өмчийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэнэ.

11.6.10.а.Хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлэн дахин тооцоход:

Дебет: Холбогдох үндсэн хөрөнгө  
Кредит: Холбогдох хуримтлагдсан элэгдэл  
Кредит: Дахин үнэлгээний нэмэгдэл

11.6.10.б.Дахин үнэлсэн хөрөнгийг шинэ хөрөнгөөр бүртгэхээр сонгосон бол эхлээд хуримтлагдсан элэгдлийн дансаа хааж, дараа нь үндсэн хөрөнгийн өсөлтийг бүртгэхэд:

Дебет: Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

Дебет: Холбогдох үндсэн хөрөнгө

Кредит: Дахин үнэлгээний нэмэгдэл

11.6.10.в.Өмнө нь дахин үнэлсэн хөрөнгийн хувьд дараагийн дахин үнэлгээгээр дансны үнэ буурвал холбогдох дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулах ба хэтэрсэн дүнг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардалд бүртгэхэд:

Дебет: Дахин үнэлгээний нэмэгдэл

Дебет: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал (хэтэрсэн дүнгээр)

Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

11.6.11.Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол бууралтыг үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардлаар бүртгэнэ.

11.6.11.а.Хуримтлагдсан элэгдлийг хөрөнгийн дансны үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлэн дахин тооцох үед:

Дебет: Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Дебет: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал

Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

11.6.11.б.Үндсэн хөрөнгийг шинээр бүртгэхээр сонгосон бол эхлээд хуримтлагдсан элэгдлийн дансаа хааж, үндсэн хөрөнгийн бууралтыг бүртгэхэд:

Дебет: Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

Дебет: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал

Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

11.6.11.в.Өмнө нь дахин үнэлсэн хөрөнгийн хувьд дараагийн дахин үнэлгээгээр дансны үнэ өсвөл өмнө хүлээн зөвшөөрсөн зардалтай тэнцэхүйц орлого хүлээн зөвшөөрөөд давсан дүнгээр хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Холбогдох үндсэн хөрөнгө

Кредит: Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын орлого

Кредит: Дахин үнэлгээний нэмэгдэл (хэтэрсэн зөрүүгээр)

11.6.12.Үндсэн хөрөнгийг данснаас хасах, шилжүүлэх, худалдан борлуулах үед үндсэн хөрөнгө, түүний хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын дансны үлдэгдлийг хааж бүртгэнэ.

11.6.12.а.Хэрэв үндсэн хөрөнгөөс эдийн засгийн өгөөж хүртэхгүй болсон буюу хөрөнгийн ашиглалтыг хугацаа дуусаж, данснаас хасахад:

Дебет: Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

11.6.12.б.Үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацаа дуусахаас өмнө данснаас хассан бол түүний өртгийг гарзаар бүртгэхэд:

Дебет: Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Дебет: Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз

Кредит: Үндсэн хөрөнгө

11.6.12.в. Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед хүлээн авсан мөнгөн дүн ба дансны үнийн зөрүүг олз, гарзаар бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Дебет эсхүл Кредит: Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз эсхүл олз

Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

11.6.13. Үндсэн хөрөнгийг салбар, нэгжүүдийн хооронд дотооддоо шилжүүлэх үед шилжүүлсэн хөрөнгийг дансны үнээр шинээр бүртгэх эсхүл анхны өртгөөр бүртгэж, хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг нь давхар бүртгэх эсэхийг бүртгэлийн бодлогоор тогтоож, тууштай мөрдөнө.

11.6.13.а. Үндсэн хөрөнгийг салбар, нэгжүүдийн хооронд дотооддоо шилжүүлэх үед үндсэн хөрөнгийг авч байгаа нэгж нь:

Дебет: Холбогдох үндсэн хөрөнгө

Кредит: Салбар хоорондын тооцоо

11.6.13.б. Үндсэн хөрөнгийг өгсөн нэгж нь:

Дебет: Салбар хоорондын тооцоо

Кредит: Холбогдох үндсэн хөрөнгө

## **АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ**

12.1. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь ТЗЭ-ийн үйл ажиллагаанд ашиглаагүй, түрээсийн орлогоор эсхүл хөрөнгийн үнийн өсөлтөөр эсхүл энэ хоёрын аль алианаар ашиг олохын тулд эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийг хэлнэ.

12.2. Борлуулах зориулалттай хөрөнгө гэж эргэлтийн бус хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглах замаар биш, харин борлуулах ажил гүйлгээгээр түүний дансны үнийг нөхөх эргэлтийн бус хөрөнгийг хэлнэ.

### **12.3. Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

12.3.1. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анхны удаад өртгөөр хэмжинэ. Түүнд шууд хамааралтай ажил гүйлгээний зардлыг хөрөнгийн өртөгт оруулна. Худалдан авсан хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн өртөгт худалдан авсан үнэ, бусад шууд холбоотой зардал багтана. Шууд холбоотой зардалд хуулийн үйлчилгээний төлбөр, хөрөнгийг шилжүүлэхэд төлөх татвар, бусад зардал хамаарна.

12.3.2. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнийн загвар ба өртгийн загварын аль нэгийг сонгож, бүртгэнэ. Сонгосон загвараа үйл ажиллагааны түрээсийн хөрөнгөөс бусад хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгөнд ашиглана. Өртгийн загвараар бүртгэхээр сонгосон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг энэ журмын "Үндсэн хөрөнгө" бүлэгт заасан өртгийн загварын дагуу бүртгэнэ.

12.3.3.Хөрөнгийг худалдааны хэвийн нөхцөлөөр одоогийн байдлаар нь худалдан борлуулах боломжтой бөгөөд хөрөнгийг худалдан авах магадлал өндөр байх үед борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Ийм хөрөнгө нь борлуулалтын хувьд хэвийн нөхцлөөр, нэн даруй борлогдох боломжтой бөгөөд хөрөнгийг борлуулах өндөр магадлалтай байна. Хөрөнгийг энэ ангилалд бүртгэснээс хойш нэг жилийн дотор худалдан борлуулсан байх ба хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн байна.

12.3.4.Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг дансны үнэ ба борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар хэмжиж, тайлагнана. Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнд элэгдэл тооцохгүй.

12.3.5.Зогсоосон үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө, өр төлбөрийг борлуулаагүй бол СТОУС 5-ын шалгуур хангагдсан нөхцөлд үүнийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө ба борлуулах өр төлбөрт тус тус бүртгэнэ.

12.3.6.ТЗЭ үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг хаах эсхүл худалдан борлуулахаар болсон бол зогсоосон үйл ажиллагаа гэж үзэх ба энэ нь:

12.3.6.а.Үйл ажиллагааны нэг гол төрөл буюу үйл ажиллагааны газар зүйн бүс нутгийг илэрхийлнэ,

12.3.6.б.Үйл ажиллагааны нэг гол төрөл буюу үйл ажиллагааны газар зүйн бүс нутгийг данснаас хасах нэгдсэн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг, эсхүл

12.3.6.в.Зөвхөн буцаан борлуулах зорилгоор олж эзэмшсэн охин компани байна.

## **12.4.Дансны бичилт**

12.4.1.Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг дараах байдлаар бүртгэнэ:

12.4.1.а.Хөрөнгийг худалдан авахад өртгөөр нь бүртгэхэд:

Дебет: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

12.4.1.б.Үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай ангилалд шилжүүлэн бүртгэхэд:

Үндсэн хөрөнгийг өртгийн загвараар бүртгэж байсан бол:

Дебет: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (өртгөөр)

Кредит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

Дебет: Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

Кредит: Үндсэн хөрөнгийн анхны өртөг

Үндсэн хөрөнгийг дахин үнэлгээний загвараар бүртгэж байсан бол:

Дебет: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Дебет: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Дебет: Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

Кредит: Үндсэн хөрөнгийн анхны өртөг

12.4.1.в.Бодит үнэ цэнийн загвараар бүртгэхээр сонгосон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тайлагналын өдрөөр бодит үнэ цэнээр үнэлж, үнэлгээний өөрчлөлтийн олз, гарзаар тохируулан бүртгэнэ.

Хөрөнгийг үнэлгээг нэмэгдүүлэхэд:

Дебет: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Кредит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтийн олз

Хөрөнгийг үнэлгээг бууруулахад:

Дебет: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтийн гарз

Кредит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

12.4.1.г.Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

12.4.2.Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн хувьд өмчлөх бусад хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн ангилалд шилжүүлж бүртгэсэн бол бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн ба дансны үнийн аль багаар хэмжиж, бүртгэнэ.

12.4.2.а.Хөрөнгийн дансны үнэ бага байх тохиолдолд:

Дебет: Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө

Кредит: Өмчлөх бусад хөрөнгө (Бусад санхүүгийн бус хөрөнгө)

12.4.2.б.Хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүн бага байх тохиолдолд:

Дебет: Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө

Дебет: Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан

Кредит: Өмчлөх бусад хөрөнгө (Бусад санхүүгийн бус хөрөнгө)

12.4.2.в.Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн дансны үнэ нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээс бага болсон тохиолдолд эдгээрийн зөрүүгээр хөрөнгийн үнэлгээг бууруулан бүртгэхэд:

Дебет: Хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтийн гарз

Кредит: Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

## **АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ БИЕТ БУС ХӨРӨНГӨ**

13.1.Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болох мөнгөн бус зүйлсийн хөрөнгө юм. Нэгээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглах, биет шинж чанаргүй программ хангамж, гүүдвил болон бусад биет бус хөрөнгүүд хамаарна.

13.2.Хөрөнгө нь дараах дараах шалгуурын аль нэгийг хангаж байвал тодорхойлж болох хөрөнгө гэж үзнэ:

13.2.1.Салган хувааж болох ба ТЗЭ тийм зорилготой эсэхээс үл хамааран холбогдох гэрээ, тодорхойлж болох хөрөнгө, өр төлбөрөөс бие даасан байдлаар

эсхүл хамтад нь борлуулах, шилжүүлэх, лицензээр эзэмшүүлэх, түрээслэх, солилцох боломжтой байх; эсхүл

13.2.2.Гэрээний болон бусад хуулийн эрхийг шилжүүлж болох буюу тухайн ТЗЭ-ээс эсхүл өөр бусад эрх, үүргээс салган тусгаарлаж болох эсэхээс үл хамааран тухайн гэрээний буюу бусад хуулийн эрхээс үүссэн байх.

### **13.3.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

13.3.1.Биет бус хөрөнгийг тухайн хөрөнгөд хамаарах хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь уг аж ахуйн нэгжид орох магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартай хэмжиж чадах шалгуурыг хангаж байвал хүлээн зөвшөөрнө.

13.3.2.Хэрэв тухайн хөрөнгө нь бусад хөрөнгийн хамтаар ирээдүйн эдийн засгийн үр өгөөж өгдөг тохиолдолд тухайн хөрөнгөнөөс хүртэх өгөөжийг тусад нь тооцох боломжтой бол тодорхойлж болох хөрөнгө гэж үзэж хөрөнгөөр бүртгэх ба харин боломжгүй бол бусад хөрөнгийн хамт бүртгэнэ.

13.3.3.Худалдаж авсан биет бус хөрөнгийг хөрөнгийг өртгөөр нь үнэлж, бүртгэнэ.

13.3.4.Бизнесийн нэгдэл болон хөрөнгийн солилцоогоор авсан биет бус хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжинэ.

13.3.5.ТЗЭ нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлэхийн тулд хөрөнгийг бий болгох үе шатыг судалгааны ба хөгжүүлэлтийн үе шат гэж ангилаад дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

13.3.5.а.Судалгааны зардлыг гарсан тухай бүрд нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

13.3.5.б.Хэрэв биет бус хөрөнгийг бий болгох судалгааны үе шатыг хөгжүүлэлтийн үе шатнаас ялгаж чадахгүй байгаа бол зарцуулсан зардлыг зөвхөн судалгааны үе шатанд гарсан гэж үзээд зардлаар хүлээн зөвшөөрнө.

13.3.5.в.Биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй хөгжүүлэлтийн зардлыг гарсан тухай бүрд зардлаар, харин шалгуурыг хангасан тохиолдолд биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

13.3.6.Дараах шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд хөгжүүлэлтээс бий болох биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө:

13.3.6.а.Хөгжүүлэлтийг бүрэн дуусгах техникийн үндэслэлтэй байх;

13.3.6.б.Биет бус хөрөнгийг бүрэн дуусгах ба түүнийг ашиглах эсхүл борлуулах зорилготой байх;

13.3.6.в.Ашиглах эсхүл борлуулах боломжтой байх;

13.3.6.г.Ирээдүйн магадлалт эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг хэрхэн бий болгох;

13.3.6.д.Хөгжүүлэлтийг бүрэн дуусгах ба тухайн биет бус хөрөнгийг ашиглах эсхүл борлуулах зохих техникийн, санхүүгийн болон бусад нөөц бэлэн боломжтой байх;

13.3.6.е.Хөгжүүлэлтийн явцад уг биет бус хөрөнгөнд хамаарах зарлагыг найдвартай хэмжих чадвар боломжтой байх.

13.3.7.Санхүүгийн түрээсээр хөрөнгө авсан бол түрээсэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар түрээсийн

хөрөнгийг хэмжинэ. Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах үр ашигт хүү нь түрээслэгчийн ашиглаж буй өсөн нэмэгдэх хүү байна. Санхүүгийн түрээсийн хугацаанд хөрөнгийг ашиглах эрхтэй хөрөнгөөр бүртгэж, тайлагнах ба үүнийг энэ журмын “Үндсэн хөрөнгө” бүлгээс үзнэ үү.

13.3.8.Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бол ашиглалтын хугацаанд тохиромжтой аргаар хорогдуулна. Хэрэв тохиромжтой аргыг тодорхойлоогүй бол шулуун шугамын аргаар хорогдуулна.

13.3.9.Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхойгүй бол хорогдуулахгүй, үнэ цэнийн бууралтыг үнэлж бүртгэнэ. НББОУС 36-д заасан үнэ цэнэ буурсан шинж тэмдэг байгаа эсэхээс үл хамааран ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгийн дансны үнийг нөхөгдөх дүнтэй нь харьцуулах замаар үнэ цэнийн бууралтыг жил бүр үнэлнэ.

13.3.10.Гэрээ болон бусад хууль эрхээс үүссэн биет бус хөрөнгийн ашиглагдах хугацаа нь тухайн гэрээний буюу бусад хуулийн эрхийн хугацаанаас хэтрэхгүй боловч хөрөнгийг ашиглахаар хүлээж буй хугацаанаас хамааран дээрх хугацаанаас арай богино байж болно. Хэрэв эрхийг дахин сунгаж болох хязгаартай хугацаатай олгодог бол мэдэгдэхүйц зардал гаргахгүйгээр дахин сунгах нотолгоо байгаа тохиолдолд биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаанд дахин сунгах хугацааг оруулна.

13.3.11.Биет бус хөрөнгийг ашигласнаар цэвэр мөнгөн орлого бий болгохоор хүлээгдэж буй хугацааг урьдчилан тодорхойлох боломжгүй бол тухайн биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойгүй гэж үзнэ.

13.3.12.Биет бус хөрөнгөнд хорогдуулга тооцоогүй үед ашиглалтын хугацааг тайлант жилийн төгсгөлд хянаж, тухайн хөрөнгийн тодорхойгүй ашиглагдах хугацааг хэвээр үлдээх шалтгаан байгаа эсэхийг тогтооно. Ийм шалтгаан байхгүй бол тодорхойгүй ашиглалтын хугацааг тодорхой хугацаагаар сольж, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзээд, бүртгэлд тусгана.

13.3.13.Хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд биет бус хөрөнгийг дахин үнэлгээний загвараар бүртгэж болно.

13.3.14.Биет бус хөрөнгийг олж бэлтгэх, санхүүгийн түрээсээр авах, бусад хөрөнгөөр солилцох, холбогдох дараа үеийн зардал, дахин үнэлгээний загвар, үнэ цэнийн бууралт, данснаас хасах зэргийг энэ журмын “Үндсэн хөрөнгө” бүлэгт заасны дагуу хэмжиж, бүртгэнэ.

#### **13.4.Дансны бичилт**

13.4.1.Биет бус хөрөнгийг худалдан авахад:

Дебет: Холбогдох биет бус хөрөнгө

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

13.4.2.Биет бус хөрөнгийн (элэгдэл) хорогдуулгыг бүртгэхэд:

Дебет: Биет бус хөрөнгийн хорогдуулгын зардал

Кредит: Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдуулга

13.4.3.Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэхэд:



Дебет: Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардал

Кредит: Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдуулга

13.4.4.Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалтыг бүртгэхэд:

Дебет: Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдуулга

Кредит: Бусад орлого - Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын орлого

13.4.5.Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусаж, данснаас хасахад:

Дебет: Холбогдох хуримтлагдсан хорогдуулга

Кредит: Холбогдох биет бус хөрөнгө

13.4.6.Хэрэв биет бус хөрөнгийг ашиглалтын хугацаа дуусаагүй бөгөөд хорогдуулах өртгийг хараахан бүрэн нөхөөгүй үед данснаас хасах бол хорогдуулаагүй үлдсэн өртгийн дүнг гарзаар бүртгэхэд:

Дебет: Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз

Кредит: Холбогдох биет бус хөрөнгө

13.4.7.Хэрэв биет бус хөрөнгийг бусдад худалдан борлуулж, данснаас хассан бол хөрөнгийн дансны үнэ ба борлуулсан үнийн зөрүүгээр олз, гарз үүснэ.

13.4.7.а.Биет бус хөрөнгийг олзтой борлуулсан бол:

Дебет: Мөнгөн хөрөнгө болон тооцооны холбогдох данс (хүлээн авсан цэвэр дүнгээр)

Кредит: Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (зөрүүгээр)

Кредит: Холбогдох биет бус хөрөнгө (дансны үнээр)

13.4.7.б.Биет бус хөрөнгийг гарзтай борлуулсан бол:

Дебет: Мөнгөн хөрөнгө болон тооцооны холбогдох данс (хүлээн авсан цэвэр дүнгээр)

Дебет: Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз (зөрүүгээр)

Кредит: Холбогдох биет бус хөрөнгө (дансны үнээр)

## **АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР**

14.1.Санхүүгийн өр төлбөр гэж эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагшлах урсгалаар төлөгдөхөөр хүлээгдэж буй өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд үүссэн ТЗЭ-ийн одоогийн үүрэг хариуцлагыг хэлнэ.

14.2.ТЗЭ-ийн санхүүгийн өр төлбөрт итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, бусад эх үүсвэр, дериватив санхүүгийн өр төлбөр, бусад санхүүгийн өр төлбөр, хоёрдогч өглөг, өр төлбөрөөр толилуулах давуу эрхийн хувьцаа хамрагдана.

### **14.3.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

14.3.1.Одоогийн үүргийг барагдуулснаар эдийн засгийн өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлалтай бөгөөд төлөх дүнг найдвартайгаар хэмжиж чадах өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

14.3.2.ТЗЭ нь санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг тал болсон үед санхүүгийн байдлын тайландаа санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

14.3.3.Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөрийг Монголбанкнаас зарласан албан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн, төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар хүлээн зөвшөөрнө.

14.3.4.Санхүүгийн өр төлбөрийн хүүг өдөр тутам хуримтлуулж, бүртгэнэ.

## **АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР**

15.1.Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр гэж байгууллага, иргэдээс үр шим амласан болон бусад нөхцөлтэй гэрээгээр байршуулсан эх үүсвэр, хуримтлуулан тооцсон үр шим хамаарах ба итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэрийг хугацаагаар ангилж харуулна.

### **15.2.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

15.2.1.Итгэлцлийн үйл ажиллагааны гэрээ, хэлцлийн дагуу харилцагч эх үүсвэрийг байршуулж, санхүүгийн хөрөнгийг буцааж өгөх үүрэг хүлээсэн үед итгэлцлийн үйл ажиллагаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

15.2.2.Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлнэ. Бодит үнэ цэнэ нь гэрээний дагуу байршуулсан эх үүсвэрийн дүнтэй тэнцүү байна.

15.2.3.Санхүүгийн тайланд итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр үнэлж, тайлагнана. Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн хорогдуулсан өртөг нь анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүн дээр тайлант хугацаанд нэмэгдсэн итгэлцлийн үйлчилгээний орлого, итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд тооцсон үр шимийн өглөгийг нэмж, тайлант хугацаанд хийсэн зарлагын гүйлгээ, холбогдох шимтгэлийг хасаж тодорхойлогдоно.

15.2.4.Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн үр шимийг гэрээнд заасан хувиар тооцоолж, хуримтлуулан бүртгэнэ.

### **15.3.Дансны бичилт**

15.3.1.Итгэлцлээр хөрөнгө татан төвлөрүүлж, орлогын гүйлгээ хийхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр

15.3.2.Итгэлцлээр байршуулсан хөрөнгийн үлдэгдэлд үр шим тооцож, хуримтлуулахад:

Дебет: Итгэлцлийн үйлчилгээний үр шимийн зардал

Кредит: Хуримтлуулж тооцсон үр шимийн өглөг

15.3.3.Харилцагч итгэлцлээр байршуулсан хөрөнгөө буцаан татаж, зарлагын гүйлгээ хийхэд:

Дебет: Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

15.3.4.Харилцагчийн итгэлцлээр байршуулсан хөрөнгөөс үйлчилгээний шимтгэл суутгасан бол:

Дебет: Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр

Кредит: Итгэлцлийн үйлчилгээний шимтгэлийн орлого

15.3.5.Харилцагч итгэлцлээр хөрөнгө байршуулахад үйлчилгээний шимтгэл тооцоход:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Итгэлцлийн үйлчилгээний шимтгэлийн орлого

## **АРВАН ЗУРГААДУГААР БҮЛЭГ БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР**

16.1.Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр нь дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, тэдний байршуулсан харилцах, хадгаламж, уг эх үүсвэрт хуримтлуулан тооцсон хүүгийн өглөгөөс бүрдэнэ. Харин дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлд дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээлсэн эх үүсвэр хамрагдана.

### **16.2.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

16.2.1.Холбогдох заавар, журам, гэрээ, хэлцлийн дагуу бусад банк, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлж, санхүүгийн хөрөнгийг буцааж өгөх үүрэг хүлээсэн үед эх үүсвэрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

16.2.2.Бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр хэмжинэ.

16.2.3.Санхүүгийн тайланд бусад банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэрийг хорогдуулсан өртгөөр үнэлж, тайлагнана. Эх үүсвэрийн хорогдуулсан өртгийг зээлийн анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөр ба хойшлогдсон зардлын үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасаж тодорхойлно. Үр ашигт хүүгийн түвшинг тооцохдоо тухайн санхүүгийн хэрэгслийн гэрээний бүх нөхцөлийг харгалзан үзэж, мөнгөн гүйлгээг үнэлнэ. Энэ тооцоололд үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон гэрээний талуудын хооронд төлөгдөх бүх хураамж, шимтгэл, бусад бүх урамшуулал, хямдруулалтыг багтаана.

16.2.4.Санхүүгийн хэрэгслийн үр ашигт хүүгийн аргаар хорогдуулах шимтгэлийг хойшлуулан бүртгэх бол үзүүлсэн үйлчилгээнд хамаарах шимтгэл, тодорхой үйл ажиллагаатай холбогдуулан авах төлбөр, хураамжийг тайлант үеийн ашиг, алдагдлаар бүртгэнэ.

16.2.5.Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, тэдгээрт төлсөн хүүгийн зардлыг гэрээнд заасан нөхцөл, хувь хэмжээгээр тооцоолж, хуримтлуулан бүртгэнэ.

16.2.6.Гадаад валютаар байршуулсан харилцах, хадгаламж, авсан зээлийг Монголбанкны албан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн, төгрөг, гадаад валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар хүлээн зөвшөөрнө.

16.2.7.Татан төвлөрүүлсэн эх үүсвэр (итгэлцэл, зээл, хоёрдогч өглөг болон бусад эх үүсвэр)-ийг зах зээлийн хүүгийн түвшинд эсхүл зах зээлийн нөхцөлөөс мэдэгдэхүйц ялгаатай хүүтэйгээр авсан эсэхийг үнэлнэ. Татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг зах зээлийн хүүгийн түвшинд олж авсан эсэхийг шинжилж, үнэлэхдээ зэрэгцүүлэгдэх ажил гүйлгээ (ижил валют, дуусгавар хугацаа, барьцаатай) болон тухайн санхүүгийн хэрэгслийг анх гаргаж байх үеийн зах зээлийн нөхцөлд үндэслэнэ.

### **16.3.Дансны бичилт**

16.3.1.Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахад гэрээний дүнгээр эх үүсвэрийн дансанд бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэр

16.3.2.Зээлийн эх үүсвэрт багтсан шууд холбоотой материаллаг дүнтэй зардлыг бүртгэхэд:

Дебет: Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

16.3.3.Хойшлогдсон зардлыг зээлийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хорогдуулахад:

Дебет: Зээлийн хүүгийн зардал

Кредит: Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр

16.3.4.Зээлийн хүүг хуримтлуулж бүртгэхэд:

Дебет: Зээлийн хүүгийн зардал

Кредит: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг

16.3.5.Хүү төлөгдөх тохиолдолд:

Дебет: Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

16.3.6.Зээлийг буцааж төлөхөд:

Дебет: Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэр

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

16.3.7.Хэрэв хаагдсан эх үүсвэрийн дансанд хамаарах хойшлогдсон зардлын данс нь үлдэгдэлтэй бол үүнийг хүүгийн зардлын дансанд хаана.

### **АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЭХ ҮҮСВЭР**

17.1.Бусад эх үүсвэрт харилцагчид, банк, санхүүгийн байгууллагаас бусад зээлдүүлэгчдээс тодорхой зориулалт, нөхцөлтэй байршуулсан эх үүсвэр болон төлбөр тооцооны бусад хэрэгслийн эх үүсвэр болгон ашиглахаар байршуулсан зээлдүүлэгчээс авсан төслийн зээлийн санхүүжилт, гаргасан өрийн бичиг, үнэт цаас

баталгаа, батлан даалтын барьцаа, хөрвөх эрхтэй зээлийн өр төлбөр болох хэсэг хамрагдана.

## **17.2.Төслийн зээлийн санхүүжилтийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

17.2.1.Төслийн зээлийн эх үүсвэрт дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас хэрэгжүүлэх тодорхой зориулалт, хүү, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр мөнгөн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх төслийн зээлийн эх үүсвэр хамрагдана.

17.2.2.Холбогдох заавар, журам, гэрээ, хэлцлийн дагуу бусад эх үүсвэрийг байршуулж, түүнийг эргүүлэн төлөх үүрэг хүлээсэн үед тусгай зориулалттай бусад эх үүсвэрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

17.2.3.Төслийн зээлийн эх үүсвэрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Төслийн зээлийн эх үүсвэрт төлөх хүүг гэрээнд заасан хувь хэмжээгээр, өдөр бүр хуримтлуулан тооцож тухайн тайлант хугацааны зардалд бүртгэнэ. Гэхдээ үр ашигт хүүгийн түвшин нь гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн түвшнээс ялгаатай байж болох тул сар бүр үр ашигт хүүгийн аргыг ашиглан хүүгийн зардлыг тооцоолж, шаардлагатай тохиолдолд холбогдох тохируулгыг хийнэ.

17.2.4.Гадаад валютаарх эх үүсвэрийг Монголбанкнаас зарласан албан ханшаар тооцож төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэх ба ханшийн хэлбэлзлээс үүсэх зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар бүртгэнэ.

## **17.3.Төслийн зээлийн санхүүжилтийн дансны бичилт**

17.3.1.Төслийн зээлийн санхүүжилт авахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Төслийн зээлийн санхүүжилт

17.3.2.Төслийн зээлийн хүүг хуримтлуулж тооцох үед:

Дебет: Төслийн зээлийн санхүүжилтийн хүүгийн зардал

Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн холбогдох данс

17.3.3. Хүүг төлөх үед:

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийн холбогдох данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

17.3.4.Төслийн зээлийн санхүүжилтийг гэрээний дагуу барагдуулах үед:

Дебет: Төслийн зээлийн санхүүжилт

Кредит: Мөнгөн хөрөнгийн данс

## **17.4.Бонд, өрийн бичгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

17.4.1.Бонд, өрийн бичигт хүүтэй бөгөөд дуусгавар болох хугацаа заасан, хугацааны эцэст эргүүлэн төлөх үүрэг хүлээсэн эх үүсвэр хамрагдана.

17.4.2.Өрийн бичгийг анхны удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээс шууд холбогдох зардлыг хассан дүнгээр үнэлнэ. Санхүүгийн өр төлбөрийн хувьд (гаргасан бонд ба бусад үнэт цаас) ажил гүйлгээний өртгийг анх хүлээн зөвшөөрсөн

дүнгээс хасна. Энэ нь уг үнэт цаасыг гаргаад татан төвлөрүүлсэн цэвэр мөнгөн дүнгээр илэрхийлэгдэнэ.

17.4.3.Өрийн бичгийг хорогдуулсан өртгөөр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна. Хорогдуулсан өртгийг тодорхойлохдоо анхны үнээс үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулалтыг хасах буюу хямдруулалтын хорогдуулалтыг нэмнэ.

### **17.5.Бонд, өрийн бичгийн дансны бичилт**

17.5.1.ТЗЭ нь бонд, өрийн бичиг гаргасан бол үнэт цаасны нэрлэсэн үнээр холбогдох үнэт цаасны дансанд бүртгэх ба нэрлэсэн үнэ, бодит үнийн зөрүүгээр урамшуулал, хямдруулалтын дансанд бүртгэнэ:

Урамшуулалтай бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Хорогдуулаагүй урамшуулал

Кредит: Бонд, өрийн бичгийн өглөг

Хямдруулалттай бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Дебет: Хорогдуулаагүй хямдруулалт

Кредит: Бонд, өрийн бичгийн өглөг

17.5.2.Өрийн бичиг, бондын хүүг хуримтлуулахад:

Дебет: Үнэт цаасны хүүгийн зардал

Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

17.5.3.Хуримтлуулсан хүүг төлөхөд:

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

17.5.4.Хэрэв өрийн бичиг, бондыг анх урамшуулалтай гаргасан бол урамшууллыг хорогдуулах дүнгээр хүүгийн зардлыг бууруулахад:

Дебет: Хорогдуулаагүй урамшуулал

Кредит: Үнэт цаасны хүүгийн зардал

17.5.5.Хэрэв өрийн бичиг, бондыг анх хямдруулалттай гаргасан бол хямдруулалтыг хорогдуулах дүнгээр хүүгийн зардлыг нэмэгдүүлэхэд:

Дебет: Үнэт цаасны хүүгийн зардал

Кредит: Хорогдуулаагүй хямдруулалт

17.5.6.Өрийн бичиг, бондын хугацаа дуусаж, төлбөрийг барагдуулахад:

Дебет: Өрийн бичиг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

17.5.7.Өрийн бичиг, бондын нэрлэсэн хугацаа дуусахаас өмнө эргүүлэн худалдан авсан бол өрийн бичгийн дансны үлдэгдэл ба төлсөн мөнгөний дүнгийн зөрүүгээр олз, гарз үүсэх тохиолдолд:

Үндсэн дүнгээр:

Дебет: Өрийн бичиг

Дебет эсхүл Кредит: Бонд, өрийн бичиг барагдуулсны олз, гарз  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Урамшуулалтай бол:

Дебет: Хорогдуулаагүй урамшуулал  
Кредит: Үнэт цаасны хүүгийн зардал/Бонд, өрийн бичиг  
барагдуулсны олз, гарз

Хямдруулалттай бол:

Дебет: Үнэт цаасны хүүгийн зардал/Бонд, өрийн бичиг  
барагдуулсны олз, гарз  
Кредит: Хорогдуулаагүй хямдруулалт

## **17.6.Түрээсийн өглөгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

17.6.1.Түрээсийн өр төлбөрийг санхүүгийн тайланд “Бусад эх үүсвэр”-ээр харуулах ба үүнд банк, санхүүгийн байгууллагатай хийсэн санхүүгийн түрээсийн хэлцэл болон ТЗЭ-ийн үйл ажиллагааны үр дүнд байгуулсан түрээсийн хэлцлийн өглөг багтана.

17.6.2.Түрээсийн гэрээ хүчин төгөлдөр болж, түрээсийн хөрөнгийг хүлээн авснаар түрээсийн өглөгийг хүлээн зөвшөөрнө.

17.6.3.Түрээсийн өглөгийг түрээсэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар хэмжинэ.

17.6.4.Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах үр ашигт хүү нь түрээсийн гэрээнд заасан буюу эсхүл түрээслэгчийн ашиглаж буй өсөн нэмэгдэх хүү эсхүл зах зээлийн дундаж хүү байна. Түрээсийн хамгийн бага төлбөрийг санхүүгийн зардал ба төлөгдөөгүй өр төлбөрийг бууруулж хуваарилна. Тайлант хугацааны өр төлбөрийн үлдэгдлээс хүүгийн үечилсэн тогтмол түвшнийгээр тооцоолж, санхүүгийн зардлыг түрээсийн хугацаанд хуваарилна.

17.6.5.Ашиглах эрхтэй хөрөнгийг НББОУС 38 Биет бус хөрөнгө-ийн дагуу бүртгэж, элэгдэл хорогдлыг тооцоолно. Хэрэв түрээсийн хугацааны эцэст түрээсийн хөрөнгийг өмчлөх эрх түрээслэгчид шилжих нь тодорхой бус тохиолдолд хөрөнгийг түрээсийн хугацаа ба ашиглалтын хугацааны аль богино хугацаанд элэгдүүлнэ. Түрээсийн хөрөнгийн элэгдүүлэх өртгийг уг хөрөнгийг ашиглахаар таамаглаж буй хугацаанд системтэйгээр хуваарилна.

17.6.6.Борлуулаад буцаан түрээслэх ажил гүйлгээ нь хөрөнгөө шилжүүлсэн тал буцаагаад тухайн хөрөнгөө түрээслэхийг хэлнэ. Уг ажил гүйлгээ нь суурь хөрөнгийн борлуулалт эсэхийг тодорхойлохдоо СТОУС 15-ыг дагаж мөрдөнө.Хэрэв уг ажил гүйлгээг борлуулалт гэж үзвэл:

17.6.6.а.Түрээслэгч нь хөрөнгө ашиглах эрхийг хэмжихдээ түрээслэгчид үлдсэн хөрөнгө ашиглах эрхэд хамаарах хөрөнгийн өмнөх дансны үнэтэй хувь тэнцүүлэн хэмжинэ. Харин хөрөнгө шилжүүлсний олз, гарзыг хүлээн зөвшөөрнө.

17.6.6.б.Хөрөнгийн борлуулалтыг бодит үнэ цэнээр хэмжээгүй эсхүл түрээсийн төлбөр нь зах зээлийн үнээр илэрхийлэгдээгүй бол хөрөнгийг худалдсан тал (түрээслэгч) тохируулга хийнэ.

17.6.6.в. Уг ажил гүйлгээг борлуулалт биш гэж үзвэл хөрөнгийг худалдсан тал хөрөнгийн бүртгэлийг үргэлжлүүлэн хөтлөх бөгөөд төлөгдсөн хөрөнгийг санхүүгийн өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

### **17.7. Түрээсийн өглөгийн дансны бичилт**

17.7.1. Түрээсийн гэрээгээр хөрөнгө авахад:

Дебет: Үндсэн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Түрээсийн өглөг

17.7.2. Түрээсийн гэрээний хүүгийн зардлыг хуримтлуулахад:

Дебет: Хүүгийн зардал

Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

17.7.3. Түрээслүүлэгчид түрээсийн төлбөр шилжүүлэхэд:

Дебет: Түрээсийн өглөг

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

## **АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР**

18.1. Бусад санхүүгийн өр төлбөр гэж үйл ажиллагааны хувьд туслах чанартай бөгөөд нийт өр төлбөрийн дүнд бага хувь хэмжээтэй, санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж буй өр төлбөр буюу ихэнхдээ бусад этгээдэд мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээр хүлээсэн гэрээний үүргийг ойлгоно. Санхүүгийн хөрөнгийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг НББОУС 32.11-д заасан бөгөөд нийтлэг тохиолдол, нөхцөл байдлыг энэ зааврын дагуу өр төлбөрийн ангиллыг тогтоох боломжгүй тохиолдолд уг стандартыг ашиглана.

18.2. Бусад санхүүгийн өр төлбөрт хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг, бусдад өгөх өглөг, салбар хоорондын тооцоо, мөнгөн гуйвуулгын өглөг, цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох өглөг, ногдол ашгийн өглөг, мөнгөөр төлөгдөх хувьцааны опшин, хөрвөх өр төлбөр хамрагдана.

18.3. Мөнгөн гуйвуулгын өглөгт бусдын мөнгөн хөрөнгийг банкн дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагааг буюу хүлээн авагчид олгогдоогүй байгаа мөнгөн төлбөрийн үүргийг бүртгэнэ.

18.4. Цахим мөнгө гаргах-төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох өглөг гэж Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий, Монголбанкны зөвшөөрөлтэй гаргасан бэлэн бус төлбөрийн хэрэгслийг ойлгоно.

18.5. Ногдол ашгийн өглөг гэж ногдол ашиг олгохоор зарласны дараа хувьцаа эзэмшигчдэд олгохоор хуваарилж, бүртгэсэн ногдол ашгийг ойлгоно.

18.6. Санхүүгийн хэрэгсэл нь өр төлбөр ба өмчийн бүрэлдэхүүн хэсгийн алиныг агуулж байвал нийлмэл санхүүгийн хэрэгсэл болох ба хувьцаанд хөрвөх үнэт цаас, хувьцаанд хөрвөх эх үүсвэр зэрэг хамаарна. Хэрэв өр төлбөрийг өөрийн хөрөнгөд хөрвүүлэх нөхцөлийн улмаас өр төлбөрийн үнэ цэнэ өөрчлөгдөж байгаа бол хөрвөх өр төлбөрийн дүнг өр төлбөр ба өөрийн хөрөнгийн хэсэг гэж салгаж, бүртгэнэ.



18.7.Өр төлбөрийн хэсгийг өр төлбөрийн зах зээлийн хүүгийн хувийг ашиглан хүү болон үндсэн өрийн дүнг дискаунтчилж, тооцоолно.

### **18.8.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

18.8.1.Өр төлбөрийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлнэ. Санхүүгийн өр төлбөрийн хувьд ажил гүйлгээний зардлыг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хасна.

18.8.2.Өр төлбөрийг барагдуулахаар таамаглаж буй ирээдүйн мөнгөн гүйлгээг дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үед өр төлбөр үүсгэж хүлээн авсан хөрөнгийн дүнгээр эсхүл уг өр төлбөрийг барагдуулахад төлөх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүнгээр өр төлбөрийг үнэлнэ.

18.8.3.Бусад санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хорогдуулсан өртгөөр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна. Хүүтэй өр төлбөрийн хувьд хорогдуулсан өртгийг банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн хорогдуулсан өртгийн адил тооцоолох ба харин хүүгүй өр төлбөрийн хувьд хорогдуулсан өртөг нь анх хүлээн зөвшөөрсөн төлөгдөөгүй өр төлбөрийн дүнтэй тэнцүү байна.

### **18.9.Дансны бичилт**

18.9.1.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөгийг энэ журмын “Бусад эх үүсвэр” бүлэгт зааснаар бүртгэх ба салбар хоорондын тооцооны бүртгэлийг энэ журмын “Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө” бүлэгт заасан тул бусдад өгөх өглөг, цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох өглөг, ногдол ашгийн өглөгийн бүртгэлийг энэ бүлэгт харуулав.

#### **18.9.2.Бусдад өгөх өглөг**

18.4.2.а.Бараа, үйлчилгээг зээлээр худалдан авахад:

Дебет: Хөрөнгийн холбогдох данс

Кредит: Бусдад өгөх өглөг

18.4.2.б.Зардал хуримтлуулж өглөгт бүртгэхэд:

Дебет: Зардлын холбогдох данс

Кредит: Бусдад өгөх өглөг

18.4.2.в.Бараа, үйлчилгээний үнэ болон хуримтлуулсан өглөгийг төлөх үед:

Дебет: Бусдад өгөх өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

#### **18.9.3.Мөнгөн гуйвуулгын өглөг**

18.9.3.а.Гуйвуулгаар ирсэн мөнгийг бүртгэж авахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Мөнгөн гуйвуулгын өглөг

18.9.3.б.Гуйвуулгын мөнгийг олгоход:

Дебет: Мөнгөн гуйвуулгын өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

18.9.3.в. Үйлчилгээний шимтгэлийг бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний шимтгэлийн орлого

#### **18.9.4.Цахим мөнгө гаргах-төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох өглөг**

18.9.4.а. Харилцагч цахим хэтэвчиндээ мөнгөн хөрөнгө байршуулахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох өглөг

18.9.4.б. Харилцагч цахим хэтэвчнээсээ төлбөр тооцоо гүйцэтгэхэд:

Дебет: Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

18.9.4.в. Үйлчилгээний шимтгэлийг бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээний шимтгэлийн орлого

#### **18.9.5.Ногдол ашгийн өглөг**

18.9.5.а. Ногдол ашиг зарласан үед ногдол ашгийн өглөгийг хүлээн зөвшөөрч, бүртгэхэд:

Дебет: Хуримтлагдсан ашиг

Кредит: Ногдол ашгийн өглөг

18.9.5.б. Ногдол ашгийг мөнгөөр олгоход:

Дебет: Ногдол ашгийн өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

#### **18.9.6.Хөрвөх өр төлбөр**

18.9.6.а. Хөрвөх өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Дебет: Хөрвөх өр төлбөрийн хямдруулалт (өр төлбөр болох хэсэг)

Кредит: Хөрвөх өр төлбөр (өр төлбөр болох хэсэг)

Кредит: Хөрвөх өр төлбөрийн өмчийн хэсэг

18.9.6.б. Тайлант хугацааны эцэст хүү төлөгдөхөд:

Дебет: Хүүгийн зардал

Кредит: Хөрвөх өр төлбөрийн хямдруулалт (өр төлбөр болох хэсэг)

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

18.9.6.в.Өмчийн хэсгийг хувьцаа гэж үзэх бөгөөд уг өрийг хувьцаанд хөрвүүлэхэд:

Дебет: Хөрвөх өр төлбөрийн өмчийн хэсэг  
Дебет: Хөрвөх өр төлбөр (өр төлбөр болох хэсэг)  
Кредит: Хувь нийлүүлсэн хөрөнгө/Нэмж төлөгдсөн капитал

18.9.6.г.Хэрэв уг өрийг хувьцаанд хөрвүүлээгүй бол:

Дебет: Хөрвөх өр төлбөрийн өмчийн хэсэг  
Дебет: Хөрвөх өр төлбөр (өр төлбөр болох хэсэг)  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Өөрийн хөрөнгийн холбогдох данс

## **АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХОЁРДОГЧ ӨГЛӨГ**

19.1.Хоёрдогч өглөгийн эх үүсвэр гэж өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй, гуравдагч этгээдээс авсан, захиран зарцуулалт нь хязгаарлагдмал мөнгөн хөрөнгийг хэлнэ.

19.2.ТЗЭ-ийг татан буулгах үед бусад өр төлбөрийг барагдуулсны дараа төлж барагдуулах өр төлбөр тул хоёрдогч өглөг нь өөрийн хөрөнгийн зохистой харьцаанд тооцогдож, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн тодорхойлолтыг хангана. Хоёрдогч өглөгийг санхүүгийн тайланд тусдаа мөрөөр харуулна. Зарим төрлийн хоёрдогч өр төлбөрийн хувьд хөрвөх нөхцөл заасан тохиолдолд өр төлбөрийн хугацааны эцэст эсхүл төлбөр барагдуулах өдөр энгийн хувьцаанд хөрвүүлж болно.

### **19.3.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

19.3.1.Хоёрдогч өглөгийг бусад эх үүсвэрийн нэгэн адил анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр хэмжиж, дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжиж, санхүүгийн тайланд толилуулна. Мөнгөөр төлөгдөх хувьцаанд суурилсан төлбөр бүхий ажил гүйлгээгээр үйлчилгээг үзүүлсэн даруйд өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Өр төлбөрийг барагдуулах хүртэл тайлант хугацаа бүрийн эцэст болон төлбөр барагдуулах өдрөөр өр төлбөрийг бодит үнэ цэнээр үнэлж, үнэлгээнд гарсан өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ.

19.3.2.Захиран зарцуулах эрхийг хязгаарласан, үйл ажиллагааны эцсийн үр дүнд хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулах болзолтой эх үүсвэрийг тусад нь салгаж хоёрдогч өглөгийн дансанд бүртгэнэ. Хоёрдогч өглөгийг бусад эх үүсвэртэй адилхан бүртгэнэ. Хоёрдогч өглөгийг хугацааны эцэст нь өөрийн хөрөнгөнд хөрвүүлэх нөхцөлтэй гаргана.

### **19.4.Дансны бичилт**

19.4.1.Хоёрдогч өглөг нь НББОУС 32-ын дагуу өр төлбөр бус харин өөрийн хөрөнгийн тодорхойлолтыг хангаж болно. Ийм тохиолдолд үүнийг өөрийн хөрөнгөнд бүртгэнэ.

19.4.1.а.Өр төлбөрийг хоёрдогч өглөг рүү шилжүүлэхэд:

Дебет: Эх үүсвэр, өр төлбөрийн холбогдох данс  
Кредит: Хоёрдогч өглөг

19.4.1.б.Хоёрдогч өглөгийг мөнгөөр барагдуулсан бол:

Дебет: Хоёрдогч өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгө

19.4.1.в.Хоёрдогч өглөгийг өөрийн эх үүсвэрээр буюу хувьцаагаар барагдуулахад:

Дебет: Хоёрдогч өглөг

Кредит: Энгийн хувьцаа

Кредит: Нэмж төлөгдсөн капитал

## **ХОРЬДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР**

20.1.Санхүүгийн бус өр төлбөрт цалингийн өглөг, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, тайлант үеийн орлогын албан татварын өглөг, бусад татварын өглөг, хойшлогдсон татварын өглөг, хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөц, зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүргийн нөөц, хойшлогдсон орлого, урьдчилж орсон орлого, борлуулах зорилгоор эзэмшиж буй өр төлбөр, тэтгэвэр, тэтгэмжийн сан (өр төлбөр), түрээсийн хойшлогдсон орлого хамрагдана.

20.2.Хойшлогдсон орлого гэж СТОУС-ын шаардлагын дагуу хүлээн зөвшөөрөлтийг нь хойшлуулсан бөгөөд хараахан орлого гэж тооцоогүй өр төлбөрийг хэлнэ.

20.3.СТОУС 9-д зааснаар санхүүгийн баталгааны гэрээ гэж өрийн хэрэгслийн анхны буюу өөрчлөгдсөн нөхцөлийн дагуу зээлдэгч нь төлбөрөө хугацаандаа барагдуулаагүйн улмаас үүссэн гарзыг эзэмшигчдэд нөхөн төлөх зорилгоор тодорхой төлбөрийг барагдуулахыг уг хэрэгслийг гаргагчаас шаардаж буй гэрээ бөгөөд тайлангийн өдрөөр санхүүгийн баталгаанд харгалзах нөөцийн дүнг тухайн баталгаатай холбоотой хойшлогдсон шимтгэлийн орлогын дүнтэй харьцуулна. Хэрэв хойшлогдсон орлого нь бага гарвал өр төлбөрийн дүнг шаардлагатай нөөцийн хэмжээ хүртэл нэмэгдүүлнэ. Хэрэв нөөц нь хойшлогдсон орлогын дүнгээс бага байвал нэмж журналын бичилт хийх шаардлагагүй.

20.4.Зогсоосон үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийг худалдан борлуулахтай зэрэгцэн өр төлбөрийг барагдуулж байгаа тохиолдолд СТОУС 5-ын дагуу уг өр төлбөрийг борлуулах зорилготой өр төлбөрөөр бүртгэж, тайлагнана.

### **20.5.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

20.5.1.ТЗЭ нь гэрээ, хэлцэлд зааснаар эсхүл хуулийн дагуу үүрэг хүлээсэн үед холбогдох өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

20.5.2.Өр төлбөрийг төлөх эсхүл төлөгдсөн дүнгээр хэмжиж бүртгэнэ.

20.5.3.Гадаад валютаар илэрхийлэгдсэн бусад өр төлбөрийг Монголбанкнаас зарласан ханшаар тооцож, төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэх ба ханшийн зөрүүнээс үүссэн өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардалд бүртгэнэ. Мөнгөн бус зүйлсийн өр төлбөрт ханшийн зөрүүний тохируулга хийхгүй.

## **20.6.Дансны бичилт**

20.6.1.Ажилтны цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой өр төлбөрийн бүртгэлийг энэ журмын “Ажилтны тэтгэмж” бүлэгт, тайлант үеийн болон хойшлогдсон орлогын албан татварын бүртгэлийг энэ журмын “Орлогын албан татвар” бүлэгт, аливаа нөөц (өр төлбөр)-ийн бүртгэлийн энэ журмын “Нөөц ба болзошгүй өр төлбөр” бүлэгт, мөнгөөр төлөгдөх хувьцааны опшины бүртгэлийг энэ журмын “Өөрийн хөрөнгө” бүлэгт тус тус заасан тул хойшлогдсон орлого, урьдчилж орсон орлого, борлуулах зорилготой өр төлбөр, хөрвөх өр төлбөрийн бүртгэлийг энэ бүлэгт харуулав.

### **20.6.2.Хойшлогдсон орлого**

20.6.2.а.Орлогыг хойшлуулан бүртгэхэд:

Дебет: Холбогдох хөрөнгө, өр төлбөрийн данс

Кредит: Хойшлогдсон орлого

20.6.2.б.Хойшлогдсон орлогыг хэрэгжүүлэн бүртгэхэд:

Дебет: Хойшлогдсон орлого

Кредит: Холбогдох орлогын данс

### **20.6.3.Урьдчилж орсон орлого**

20.6.3.а.Харилцагч, зээлдэгчдээс хүүгийн болон бусад орлого урьдчилж төлөгдөхөд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс эсхүл

Кредит: Урьдчилж орсон орлого

20.6.3.б.Урьдчилж төлөгдсөн орлогыг тайлант хугацаанд хуваарилахад:

Дебет: Урьдчилж орсон орлого

Кредит: Холбогдох орлогын данс

### **20.6.4.Борлуулах зорилготой өр төлбөр**

20.6.4.а.Өр төлбөрийг хөрөнгийн хамтаар шилжүүлэхээр тусгаарлан бүртгэхэд:

Дебет: Холбогдох өр төлбөрийн данс

Кредит: Борлуулах зорилготой өр төлбөр

20.6.4.б.Борлуулах зорилготой өр төлбөрийг шилжүүлснээр мөнгө орж ирэхэд:

Дебет: Бусдад өгөх өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

## **ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ**

21.1.Ажилтны тэтгэмж нь ажил эрхлэлт болон ажлаас халагдсантай холбогдуулан ТЗЭ-ээс олгож буй бүх төрлийн төлбөр, урамшуулал юм. Үүнд цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, шагнал урамшуулал, бусад олговор хамрагдана.

21.2.Тэтгэвэр, тэтгэмжийн сангийн өр төлбөр гэж улсын тэтгэврийн сангаас (хуулийн дагуу цалингаас заавал суутгах шимтгэл) гадна тэтгэвэр, тэтгэмж олгох

зорилгоор хувийн тэтгэврийн сангаар дамжуулан ажилтнууддаа тэтгэвэр, түүнтэй адил төстэй тэтгэмж олгохоор холбогдох хууль, тогтоомж, журам эсхүл гэрээний дагуу хүлээсэн үүргийг ойлгоно.

### **21.3.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

21.3.1.Ажилтны богино хугацаат тэтгэмж нь ажилтны байгууллагадаа ажилласан тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор бүрэн барагдуулахаар хүлээгдэж буй тэтгэмж юм. Ажилтны богино хугацаат тэтгэмжид цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ээлжийн амралтын цалин, өвчтэй хугацааны тэтгэмж, цалинтай чөлөө (хуримтлагдах ба үл хуримтлагдах), шагнал, урамшуулал багтана.

21.3.2.ТЗЭ нь ажилтны гүйцэтгэсэн ажил эсхүл ажилласан цагт үндэслэн богино хугацааны тэтгэмжийг дискаунтчилаагүй төлөх дүнгээр хэмжиж, бүртгэнэ.

21.3.3.Ажилтнуудад олгох урт хугацаат тэтгэмж нь ажилтнуудад олгохоор бүртгэсэн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор барагдуулахгүй тэтгэмжийг ойлгоно. Ажилтны урт хугацааны тэтгэмжид ажил эрхлэлтийн дараах тэтгэмж (тэтгэвэр, тэтгэмжийн сан) болон бусад урт хугацаат тэтгэмж хамрагдана.

21.3.4.Улсын тэтгэвэр, тэтгэмжийн сан буюу Нийгмийн даатгалын сангаас тогтоосон шимтгэлийн сантай холбогдуулан урт хугацаат өр төлбөр үүсгэн бүртгэхгүй.

21.3.5.Хувийн тэтгэвэр, тэтгэмжийн сангийн өр төлбөр нь тогтоосон шимтгэлийн сан ба тогтоосон тэтгэмжийн сантай холбоотойгоор үүсэх бөгөөд хүлээх үүрэг нь уг санд хуримтлуулахаар зөвшөөрсөн шимтгэлийн дүнгээр хязгаарлагдана.

21.3.6.Тогтоосон шимтгэлийн санг дискаунтчилаагүй төлөх дүнгээр хэмжиж, зардал, өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө. Гэхдээ тэтгэвэр, тэтгэмжийн сангийн шимтгэлийг 12 сараас урт хугацаанд төлөхөөр бол эрсдэл багатай бондын зах зээлийн өгөөж эсхүл зах зээл идэвхгүй тохиолдолд Засгийн газрын бондын өгөөжийн хувийг ашиглан дискаунтчилна.

21.3.7.Ажилтан тогтоосон шимтгэлийн санд шимтгэл төлөх үүрэг хүлээх ба үүнийг өр төлбөрөөр бүртгэнэ. Төлсөн шимтгэл нь тайлант хугацааны шимтгэлийн дүнгээс хэтэрсэн тохиолдолд уг зөрүүг өр төлбөр бус харин хөрөнгөөр (урьдчилж төлсөн зардал) бүртгэх ба ирээдүйд төлөгдөх шимтгэлийг бууруулах буюу буцаан авна.

21.3.8.Тогтоосон тэтгэмжийн сангийн хувьд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр буюу хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Төлбөрийн үүрэг болон зардлыг хэмжихэд актуар төсөөлөл хийх бөгөөд актуар олз, гарз бүртгэнэ. Энэ нь санхүүжилтгүй, санхүүжилттэй эсхүл хагас санхүүжилттэй байж болно. Сангийн өр төлбөрийг дискаунтчилсан дүнгээр, сангийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжинэ.

21.3.9.Тогтоосон тэтгэмжийн өр төлбөрөөр бүртгэсэн дүн нь тогтоосон тэтгэмжийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ дээр хүлээн зөвшөөрөгдөөгүй актуар олзыг нэмж, актуар гарзыг хасаж, ажилтнуудтай холбоотой хүлээн зөвшөөрөгдөөгүй зардал, үүссэн өр төлбөрийг барагдуулах зорилготой тайлант хугацааны эцсээрх төлөвлөгөөт хөрөнгийн бодит үнэ цэнийг хасаж тодорхойлогдоно. Тогтоосон

тэтгэмжийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ нь төлөвлөгдсөн сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хасаагүй нийт өр төлбөрийн дүнгээр тодорхойлогдоно.

#### **21.4.Дансны бичилт**

21.4.1.Ажилтны цалин хөлс, нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэлийн бүртгэлийг энэ журмын “Зардал” бүлгээс үзнэ үү.

21.4.2.Ажилтны богино хугацааны тэтгэмжийг дараах байдлаар бүртгэнэ:

21.4.2.а.Ажилтнуудад төлөхөөр тооцоолсон тэтгэмж, шагнал, урамшууллын дүнгээр зардал, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Зардлын холбогдох данс

Кредит: Цалингийн өглөг эсхүл Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн өглөг

21.4.2.б.Ажилтнуудад тэтгэмж, шагнал, урамшууллыг олгохоос өмнө хууль тогтоомжийн дагуу холбогдох татвар, шимтгэлийг суутгасан бол:

Дебет: Цалингийн өглөг эсхүл Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн өглөг

Кредит: Холбогдох татвар, шимтгэлийн өглөгийн данс

21.4.2.в.Ажилтнуудад тэтгэмж, шагнал, урамшуулал олгоход:

Дебет: Цалингийн өглөг эсхүл Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн өглөг

Кредит: Холбогдох мөнгөн хөрөнгийн данс

21.4.3.Хэрэв ажилтнуудад олгох шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмжийг хувьцаа, түүнтэй адилтгах өмчийн хэрэгслээр төлж барагдуулах бол хувьцаанд суурилсан төлбөрөөр бүртгэнэ. Хувьцаанд суурилсан төлбөрийн бүртгэлийг энэ журмын “Санхүүгийн бус өр төлбөр” бүлгээс үзнэ үү.

21.4.4.Ажилтны урт хугацааны тэтгэмжийг дараах байдлаар бүртгэнэ:

21.4.4.а.Ажилтнуудад олгохоор хүлээгдэж буй тэтгэвэр, тэтгэмж, шагнал, урамшууллын төлбөрийн дүнгээр зардлыг хуримтлуулан өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Зардлын холбогдох данс - Тэтгэмж, нийгмийн халамж / Ажилтнуудад олгосон нөхөн олговор, хөнгөлөлт (“Цалин хөлс, нэмэгдэл”-ийн данс)

Кредит: Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн өглөг

21.4.4.б.Ирээдүйн төлбөрийн дискаунтчилсан дүнгээс хүүгийн зардал хүлээн зөвшөөрч бүртгэхэд:

Дебет: Хүүгийн зардал

Кредит: Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн өглөг

21.4.4.в.Урт хугацааны тэтгэмжийн сангаас ажилтанд тэтгэмж олгоход:

Дебет: Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжийн өглөг

Кредит: Холбогдох мөнгөн хөрөнгийн данс

21.4.5.Хувийн тэтгэврийн сангийн өр төлбөртэй холбоотой ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

21.4.5.а.Ажилтны ажилласан жил, гүйцэтгэсэн ажил, олгосон цалингийн дүнд үндэслэн тэтгэврийн санг байгуулах болон сангийн өр төлбөрийг нэмэгдүүлэхэд:

Дебет: Ажилтнуудтай холбоотой зардал

Кредит: Хувийн тэтгэврийн сангийн өр төлбөр

21.4.5.б.Тэтгэврийн сангийн хөрөнгө буюу төлөвлөгөөт хөрөнгийг тусгаарлан бүртгэхэд:

Дебет: Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө

Кредит: Холбогдох хөрөнгийн данс

Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгийг харгалзах өр төлбөрт нэгтгэн цэвэр дүнг гарган, хувийн тэтгэврийн сангийн цэвэр өр төлбөрөөр санхүүгийн тайланд толилуулна.

21.4.5.в.Тэтгэврийн сангийн өр төлбөрийг хүүгийн зардлаар бууруулахад:

Дебет: Хүүгийн зардал

Кредит: Хувийн тэтгэврийн сангийн өр төлбөр

21.4.5.г.Тэтгэврийн сангийн хөрөнгийг хүүгийн орлогоор нэмэгдүүлэхэд:

Дебет: Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө

Кредит: Хүүгийн орлого

Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө, өр төлбөрт хамаарах хүүгийн орлого, зардлыг нэгтгэж, цэвэр дүн гарган тэтгэврийн сангийн үнэлгээнд ашиглан, санхүүгийн тайланд толилуулна.

21.4.5.д.Актуарчийн тооцоололд үндэслэн гаргасан тэтгэврийн сангийн цэвэр өр төлбөрийн зөрүүг актуар олз, гарзаар өөрийн хөрөнгийн дансанд бүртгэнэ:

Хувийн тэтгэвэрийн сангийн цэвэр өр төлбөрийг нэмэгдүүлэхэд:

Дебет: Актуар гарз – Бусад өөрийн хөрөнгө

Кредит: Хувийн тэтгэврийн сангийн өр төлбөр

Хувийн тэтгэвэрийн сангийн цэвэр өр төлбөрийг бууруулахад:

Дебет: Хувийн тэтгэврийн сангийн өр төлбөр

Кредит: Актуар олз – Бусад өөрийн хөрөнгө

## **ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ**

22.1.Засгийн газрын буцалтгүй тусламж гэдэг нь өнгөрсөн болон ирээдүйн хугацаанд дагаж мөрдөх тодорхой нөхцөлтэйгөөр ТЗЭ-д нөөц хэлбэрээр шилжүүлсэн Засгийн газрын туслалцааг хэлнэ. Буцалтгүй тусламжийн хоёр хэлбэр байна:

22.1.1.Хөрөнгийн буцалтгүй тусламж нь шалгуур хангаж буй ТЗЭ урт хугацаат хөрөнгө худалдан авах, барьж байгуулах, бусад хэлбэрээр олж эзэмших үндсэн нөхцөл бүхий буцалтгүй тусламж юм.

22.1.2.Орлогын буцалтгүй тусламж нь хөрөнгийн буцалтгүй тусламжаас бусад хэлбэрийн буцалтгүй тусламж юм.



## **22.2.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

22.2.1.Засгийн газрын буцалтгүй тусламжийн холбогдох нөхцөлийг ТЗЭ хангасан бөгөөд уг тусламжийг хүлээн авах хангалттай, ул үндэслэлтэй нотолгоо бүрдсэн үед буцалтгүй тусламжийг хүлээн зөвшөөрнө.

22.2.2.Буцалтгүй тусламжийг анх удаа хүлээн зөвшөөрөх үед бодит үнэ цэнийн зөрүүг хойшлогдсон тусламжийн орлогод бүртгэх ба холбогдох нөхцөл биелсэн эсхүл зарцуулалт хийсэн үед орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Тусламжийн орлогыг хуваарилахдаа үр ашигт хүүгийн арга, шулуун шугамын аргын алийг нь ч ашиглаж болно.

22.2.3.Хойшлогдсон тусламжийн орлого гэж дараагийн тайлант хугацаанд хэрэгжих төсөлтэй холбогдуулан хойшлуулан бүртгээд, зарцуулсан тайлант хугацаанд нь орлогод хүлээн зөвшөөрч, бүртгэх орлогыг хэлнэ.

22.2.3.а.Засгийн газар болон бусад зээлдэгчдээс авсан, зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлд багтсан тусламжийн орлогыг буцалтгүй тусламжийн шалгуурыг биелүүлсэн тохиолдолд хойшлуулан бүртгэж, зээлийн хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрнө;

22.2.3.б.Хөрөнгөөр өгсөн буцалтгүй тусламжийн хувьд хойшлогдсон тусламжийн орлого нь уг эргэлтийн бус хөрөнгийг олж бэлтгэхтэй холбоотой ба үүнийг уг биет буюу биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаанд хойшлуулан бүртгэнэ.

22.2.4.Дараах нөхцөл хангагдсан тохиолдолд зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн эх үүсвэр гэж үзнэ:

22.2.4.а.Засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагаас олгож буй харьцангуй бага хүүтэйгээр олгож буй зээлийн эх үүсвэр;

22.2.4.б.Эх үүсвэрийг зээлдүүлэгчдийн тогтоосон харилцагчдад тусгай нөхцөлөөр хүргэх буюу өөрөөр хэлбэл зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн эх үүсвэрийг тодорхой салбар эсхүл харилцагчдад (жижиг дунд аж ахуйн нэгж, бага орлоготой иргэд гэх мэт) зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр зээлдүүлж байгаа;

22.2.4.в.Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн эх үүсвэрээр зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр харилцагч зээлдэгчдэд олгож буй зээлийг санхүүжүүлж байгаа бол (тусгай зах зээл);

22.2.4.г.Эх үүсвэр байршуулж буй талтай хийсэн гэрээнд түүний ашиглалтын талаар тодорхой заалтууд орсон байх (өөрөөр хэлбэл, тодорхой харилцагч эсхүл секторт, тогтсон хүүтэйгээр зээлдүүлэх, олгох зээлийн хүүгийн түвшин болон ерөнхий нөхцөл нь хөнгөлөлттэй байх гэх мэт);

22.2.4.д.Зээлийн зарцуулалтыг хянаж, гэрээний заалтууд биелэгдэж байгаа эсэх талаар зээлдүүлэгчдэд мэдээлнэ.

22.2.5.Тусгай зориулалттай буцалтгүй тусламж нь зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлд хамааралгүй буцалтгүй тусламж бөгөөд ашгийн бус төслийг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газар, дотоодын болон олон улсын бусад байгууллагаас эх үүсвэр авсан тохиолдолд уг эх үүсвэрийг урьдчилан тодорхойлж, эдгээр байгууллагатай тохиролцсон зориулалтын дагуу зарцуулах тул үүнийг тусгай зориулалттай гэж үзнэ. Тусгай зориулалттай эх үүсвэрийг аваад зориулалтын дагуу зарцуулах хүртэл өр төлбөр (хойшлогдсон тусламжийн орлого)-өөр бүртгэнэ. Хойшлогдсон тусламжаар бүртгэсэн эх үүсвэрийг тухайн төслийн хүрээнд гарсан зардалтай уялдуулан тайлант хугацаануудад хуваарилж, орлогод бүртгэх буюу

өөрөөр хэлбэл төслийн хүрээнд гарсан зардлын дүнгээр тусламжийн орлогыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

22.2.6.Хөрөнгөтэй холбоотой тусламж авсан ТЗЭ нь эргэлтийн бус хөрөнгө худалдан авах буюу олж бэлтгэх ба үүний үр дүнд хойшлогдсон тусламжийн орлогыг бүртгэж, үүнийгээ холбогдох биет ба биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдолтой зэрэгцэн орлогод шилжүүлэн хүлээн зөвшөөрнө. НББОУС 20-д зааснаар хөрөнгөтэй холбоотой Засгийн газрын буцалтгүй тусламжийг санхүүгийн тайланд хойшлогдсон орлогоор эсхүл хөрөнгийн үлдэгдэл дүнг тусламжийн дүнгээр бууруулах замаар тус тус харуулж болно. Эхний аргыг сонгосон тохиолдолд тусламжийг хойшлогдсон тусламжийн орлогод бүртгэж, хөрөнгийн ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилан орлогод хүлээн зөвшөөрөх бол харин хоёрдахь аргын дагуу хөрөнгийн дансны үлдэгдлийг бууруулан бүртгэнэ. Хоёр дахь аргын үед элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаанд тусламжийг элэгдлийн зардлын дүнгээр бууруулан бүртгэнэ.

### **22.3.Хөнгөлөлттэй зээлийн дансны бичилт**

22.3.1.Засгийн газар болон бусад зээлдэгчдээс авсан зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ ба авсан мөнгөний зөрүүгээр буцалтгүй тусламжийг хэмжиж, бүртгэнэ.

22.3.2.Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн олзыг хойшлуулан бүртгэхэд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Бусад эх үүсвэр

Кредит: Хойшлогдсон тусламжийн орлого

22.3.3.Тайлант хугацааны эцэст хүүгийн зардлыг бүртгэхэд:

Дебет: Хүүгийн зардал

Кредит: Бусад эх үүсвэр

22.3.4.Хойшлогдсон тусламжийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар хуваарилах ба ингэснээр тайлант хугацааны цэвэр ашиг, алдагдалд үзүүлэх үр нөлөөлөл байхгүй болно. Харин шулуун шугамын аргаар хуваарилах тохиолдолд тусламжийн орлого ба хүүгийн зардал зөрүүтэй гарч, тайлант хугацааны ашигт нөлөөлнө:

Дебет: Хойшлогдсон тусламжийн орлого

Кредит: Тусламжийн орлого

22.3.5.Хэрэв зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээлийн эх үүсвэрийг хувьцаа эзэмшигчдээс татан төвлөрүүлж байгаа тохиолдолд анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн орлогыг бусад өөрийн хөрөнгийн дансанд өмчийн хуваарилалт байдлаар бүртгэхэд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Кредит: Бусад эх үүсвэр

Кредит: Өмчийн бусад хэсэг – Бусад

### **22.4.Үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх буцалтгүй тусламжийн дансны бичилт**

22.4.1.Буцалтгүй тусламжийг тогтсон зориулалтаар гэрээнд заасны дагуу зарцуулах ба зарцуулагдаагүй үлдэгдлийг буцааж өгөхдөө дараах байдлаар бүртгэнэ:

22.4.1.а.Тусламжийн эх үүсвэрийг авахад:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө  
Кредит: Хойшлогдсон тусламжийн орлого

22.4.1.б.Эх үүсвэрийг зарцуулахад:

Дебет: Бусад зардал (хандив тусламж ба бусад)  
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

22.4.1.в.Тусламжийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэхэд:

Дебет: Хойшлогдсон тусламжийн орлого  
Кредит: Тусламжийн орлого

22.4.1.г.Тусламжийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцааж өгөхөд:

Дебет: Тусламжийн орлого  
Кредит: Хойшлогдсон тусламжийн орлого

22.4.2.Өөрийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх хэлбэрээр (мэргэжлийн тодорхой үйлчилгээ, тусгай төсөл гэх мэт) эх үүсвэр авсан бол тусламжийг орлогын буцалтгүй тусламж гэж үзэх ба орлогыг анхны удаад хойшлуулан бүртгээд, дараа дараагийн тайлант хугацаанд зарлага гарсан даруйд орлогоор хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд толилуулна.

22.4.2.а.Эх үүсвэрийг авахад:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө  
Кредит: Хойшлогдсон тусламжийн орлого

22.4.2.б.Эх үүсвэрийг зарцуулах үед холбогдох зардалтай уялдуулан тусламжийн орлогыг хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Хойшлогдсон тусламжийн орлого  
Кредит: Тусламжийн орлого

## **22.5.Эргэн төлөгдөх нөхцөлгүй буцалтгүй тусламжийн дансны бичилт**

22.5.1.ТЗЭ хөрөнгө олж бэлтгэхтэй холбоотойгоор авсан тусламжийг холбогдох биет ба биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаанд хойшлуулан бүртгэж, холбогдох хөрөнгийг элэгдүүлэх буюу хорогдуулахтай зэрэгцэн орлогод шилжүүлэн хүлээн зөвшөөрнө.

22.5.1.а.Буцалтгүй тусламж авахад (хөрөнгө худалдан авахаас өмнө):

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө  
Кредит: Хойшлогдсон тусламжийн орлого

22.5.1.б.Эх үүсвэрийг зарцуулахад:

Дебет: Биет ба биет бус хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

22.5.1.в.Хөрөнгийн элэгдэл, хорогдлыг тооцохтой зэрэгцэн хойшлогдсон тусламжийн орлогыг хэрэгжүүлнэ. Энэ бичилтийн үр дүнд хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусахад үндсэн хөрөнгө ба хойшлогдсон тусламжийн орлогын дансны үлдэгдэлгүй болно:

Дебет: Хойшлогдсон тусламжийн орлого  
Кредит: Тусламжийн орлого

## **ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР**

23.1.Нөөц нь төлөх цаг хугацаа болон дүн тодорхой бус өр төлбөр юм.

23.2.Болзошгүй өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн, төлөх дүн мэдэгдэхгүй байгаа эсхүл төлөх магадлал багатай үүрэг юм.

### **23.3.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

23.3.1.ТЗЭ нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулиар хүлээсэн болон гэрээний бус одоогийн үүрэгтэй, дүнг нь найдвартай тооцох боломжтой бөгөөд уг үүргийг барагдуулахад хөрөнгө зарцуулах магадлалтай үед нөөцийг хүлээн зөвшөөрнө.

23.3.2.Хэрэв дээрх нөхцөл хангагдахгүй бол нөөц хүлээн зөвшөөрөхгүй, болзошгүй өр төлбөр гэж тодруулах бөгөөд болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгахдаа дараах зүйлсийг харгалзана:

23.3.2.а.Бүх болзошгүй өр төлбөрийг тэнцлийн гадуур бүртгэж, тайлагнана;

23.3.2.б.Бусдад хохирол учруулсны улмаас шүүхэд дуудагдаж байгаатай холбоотойгоор гарч болзошгүй зардлын дүнг тодруулах ба мөнгөн гүйлгээг тооцоолох боломжтой боловч төлөх магадлалгүй бол нөөцийг хүлээн зөвшөөрч, бүртгэхгүй, харин болзошгүй өр төлбөр гэж үзнэ;

23.3.2.в.Янз бүрийн зорилгоор баталгаа гаргасан тохиолдолд тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр буй баталгааг болзошгүй өр төлбөр гэж үзнэ. Баталгаатай холбогдуулан ТЗЭ-ид төлбөрийн нэхэмжлэл ирэхгүй боловч төлбөр төлж болзошгүй эрсдэл үүснэ.;

23.3.2.г.Зээлд хамаарах үүргийг мөн болзошгүй өр төлбөр гэж үзнэ. Харилцагчидтайгаа зээл олгох гэрээ байгуулсан боловч уг гэрээний дагуу хараахан зээл олгоогүй тохиолдолд хүлээсэн үүргийн дагуу мөнгийг шилжүүлэхэд бэлэн байна.

23.3.3.ТЗЭ ямар нэг байдлаар алдагдалтай гэрээ байгуулсан бол тус гэрээний дагуу үүссэн одоогийн үүрэг хариуцлагыг нөөцөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Алдагдалтай гэрээ нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд гарах зайлсхийх боломжгүй зардал нь гэрээний дагуу хүртэх эдийн засгийн өгөөжөөс давах нөхцөлтэй хийгдсэн гэрээг хэлнэ. Уг гэрээнд заасан зайлсхийх боломжгүй зардалд гэрээг цуцлах хамгийн бага цэвэр зардал буюу энэ нь тус гэрээг биелүүлэхэд үүсэх зардлаас бага байх бөгөөд үүнд гэрээг биелүүлэхгүй байснаар бий болсон нөхөн олговор, торгууль багтана.

23.3.4.Хэрэв ТЗЭ-ийн тасралтгүй үйл ажиллагаа алдагдсан буюу ТЗЭ-д бүтцийн өөрчлөлт хийгдсэн бол түүнээс үүсэх шууд зарлагыг агуулсан бүтцийн өөрчлөлтийн нөөц байгуулж, ашиглана.

23.3.5.Хуульч болон бусад шинжээчид шүүхийн шийдвэрээр төлбөр барагдуулах магадлалтай гэж таамагласан бол хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд зориулсан нөөцийг байгуулж, ашиглана.

23.3.6.Зээлтэй холбоотой хүлээсэн үүрэгт байгуулсан нөөц гэж санхүүгийн хүндрэлд орсон зээлдэгчийн зээлийн нөхцөлийг хөнгөвчлөхийн тулд гаргасан санхүүгийн баталгаа, бусад хүлээсэн үүрэгтэй холбоотой үүсэх зардалд зориулсан

өр төлбөрийг ойлгоно. Зээлд хамаарах үүрэг үүссэн тайлагналын өдрөөр уг үүрэгтэй холбоотой зээлийн эрсдэл үүсдэггүй тул НББОУС 37 ба СТОУС 9-д заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдсан нөхцөлд зээлд хамаарах үүрэгт зориулсан нөөцийг дараах хоёр шалгуур зэрэг хангасан үед хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

23.3.6.а.Гэрээний нөхцөлийн дагуу эх үүсвэрийг зарцуулах магадлал тайлагналын өдөр өндөр байгаа (жишээлбэл, нээсэн зээлийн шугамыг ашиглаж зээл олгох, санхүүгийн баталгааны гэрээний дагуу төлбөр хийгдэх)

23.3.6.б.Тайлагналын өдрөөр үнэ цэнэ буурсан буюу гэрээний дагуу зээлдэгч(эрх эзэмшигч)-д урьдчилан олгосон хөрөнгөө бүрэн нөхөж авах боломжгүй гэх бодитой нотолгоо байгаа.

23.3.7.Нөөцөөр хүлээн зөвшөөрсөн дүн нь тайлангийн өдрөөр уг одоогийн үүргийг барагдуулахад шаардлагатай зарлагын хамгийн сайн тооцоолол байна. Хамгийн сайн тооцооллыг хийхийн тулд олон үйл явдал, нөхцөлд байнга тохиолддог эрсдэл, тодорхойгүй байдлыг харгалзаж үзэхийн зэрэгцээ мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ материаллаг нөлөөтэй бол үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад шаардагдах хүлээгдэж буй зардлын өнөөгийн үнэ цэнийг тооцно.

23.3.8.Нөөцийн дүнг тайлангийн өдрөөр нягтлах бөгөөд хамгийн сайн тооцооллыг тусгаж, тохируулна.

#### **23.4.Дансны бичилт**

23.4.1.Нөөцийг байгуулах болон нэмэгдүүлэхэд:

Дебет: Зардлын холбогдох данс

Кредит: Нөөцийн холбогдох данс

23.4.2.Нөөцийг тодорхой зарлагад зориулж ашиглах буюу анх нөөц гэж хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн тэр зорилгоор ашиглана. Нөөцийг зориулалтын дагуу зарцуулахад:

Дебет: Нөөцийн холбогдох данс

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

23.4.3.Үүргийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий хөрөнгийг зарцуулах магадлал бага бол нөөцийн дүнг буцаана. Нөөцийн буцаалтыг бүртгэхэд:

Дебет: Нөөцийн холбогдох данс

Кредит: Зардлын холбогдох данс эсхүл бусад орлого

### **ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ**

24.1.Хөрөнгөөс нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг өмч (өөрийн хөрөнгө) гэнэ.

24.2.Өмч нь хувь нийлүүлсэн хөрөнгө, нэмж төлөгдсөн капитал, халаасны хувьцаа, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, хуримтлагдсан ашиг, алдагдал, бусад өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.

### 24.3.Хувь нийлүүлсэн хөрөнгө

24.3.1.Хувьцаа эзэмшигчид ТЗЭ-ийн дүрэмд заасны дагуу хөрөнгө оруулна. ТЗЭ-г нээлттэй хэлбэрээр зохион байгуулсан тохиолдолд үнэт цаас гаргаж нийтэд санал болгох, худалдах ажиллагаа нь Монгол Улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль, холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдэх ба нягтлан бодох бүртгэлийг СТОУС, Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомж болон энэхүү зааврын дагуу гүйцэтгэнэ. Хувьцаа нь ТЗЭ-ийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байна.

24.3.2.Хувьцаа нь энгийн хувьцаа ба давуу эрхийн хувьцаа гэсэн хоёр төрөлтэй байна.

24.3.3.Давуу эрхийн хувьцаа нь бусад төрлийн хувьцаа, ялангуяа энгийн хувьцаатай холбоотой зарим нэг давуу эрхийг агуулсан хувьцаа юм. Давуу эрхийн хувьцааны нөхцөлөөс шалтгаалан өмч, эсхүл өр төлбөрөөр бүртгэж, тайлагнана.

24.3.4.ТЗЭ нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг буцаах үүрэг хүлээхгүй ба ногдол ашгийг төлөхөөс татгалзах эрхтэй тохиолдолд энэхүү давуу эрхтэй хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилна. Хэрэв давуу эрхийн хувьцааг эргүүлэн төлөх буюу ногдол ашгийг заавал төлөх үүрэгтэй бол тухайн хувьцааг санхүүгийн өр төлбөр гэж үзнэ. Эдгээр шалгуур нь бусад санхүүгийн хэрэгсэл буюу тухайлбал хоёрдогч өглөгт мөн хамаарна.

24.3.5.ТЗЭ-ийн удирдлагын эрх бүхий субъектийн шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийг үндэслэн хувьцаагаа нэмэгдүүлэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Энгийн хувьцаа эсхүл Давуу эрхийн хувьцаа

24.3.6.Давуу эрхийн хувьцааны хувьд өрийн ба өмчийн хэрэгслийг ангилахдаа гэрээний нөхцөлийг нэг бүрчлэн харгалзан үзнэ.

24.3.6.а.Давуу эрхийн хувьцааг өмч (өөрийн хөрөнгө) гэж тодорхойлсон тохиолдолд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (худалдсан үнээр)

Кредит: Давуу эрхийн хувьцаа-өөрийн хөрөнгө (нэрлэсэн үнээр)

Кредит: Нэмж төлөгдсөн капитал (зөрүүгээр)

24.3.6.б.Давуу эрхийн хувьцааг өр төлбөр гэж тодорхойлсон тохиолдолд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (худалдсан үнээр)

Кредит: Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр) [худалдсан үнээр буюу бодит үнэ цэнээр]

24.3.6.в.Зарим тохиолдолд өр төлбөрөөр бүртгэсэн давуу эрхийн хувьцаанд өмчийн буюу энгийн хувьцаанд хөрвүүлэх шинж агуулагдсан байдаг. Энэ тохиолдолд давуу эрхийн хувьцааг өр төлбөр, өөрийн хөрөнгөнд салгаж бүртгэн, тайлагнана.

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

Кредит: Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)

Кредит: Давуу эрхийн хувьцаа (өөрийн хөрөнгө)

## **24.4.Нэмж төлөгдсөн капитал**

24.4.1.Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн дүнг бүртгэдэг, хувьцааны урамшууллыг илэрхийлсэн данс юм. Энэ нь халаасны хувьцаа, хувьцаа эргэлтээс гаргалттай холбоотой зарим ажил гүйлгээгээр өсөж, буурна. Хувьцааг нэрлэсэн үнээс илүү үнээр гаргахад:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (худалдсан үнээр)

Кредит: Энгийн хувьцаа (нэрлэсэн үнээр)

Кредит: Нэмж төлөгдсөн капитал (үнийн зөрүүгээр)

## **24.5.Халаасны хувьцаа**

24.5.1.Өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авсан бол халаасны хувьцаа гэж үзэх ба халаасны хувьцааны дүнгээр өөрийн хөрөнгө буурна:

24.5.1.а.ТЗЭ өөрийн өмчийн хэрэгслийг худалдан авах, худалдах, шинээр гаргах, эргэлтээс гаргах зэрэг тохиолдолд ямар нэгэн орлого, зардал бүртгэхгүй.

24.5.1.б.Өөрийн өмчийн хэрэгслээ худалдан авах, худалдахтай холбоотой төлсөн буюу төлөгдсөн мөнгийг өөрийн хөрөнгөнд бүртгэнэ.

24.5.1.в.Хувьцааны арилжаатай холбоотой зардлыг бүртгэхдээ өөрийн хөрөнгийг бууруулж, халаасны хувьцааг худалдан авахтай шууд холбоотой зардлыг өөрийн хөрөнгөнд бүртгэн, өмчийн өөрчлөлтийн тайланд харуулна.

24.5.2.Халаасны хувьцааг өртгийн ба нэрлэсэн үнийн аргаар бүртгэнэ.

24.5.3.Нэрлэсэн үнийн аргын үед халаасны хувьцааг хувьцааны нэрлэсэн үнээр бүртгэнэ:

24.5.3.а.Хувьцаагаа эргүүлэн худалдан авахад:

Дебет: Халаасны хувьцаа (нэрлэсэн үнээр)

Дебет эсхүл Кредит: Нэмж төлөгдсөн капитал (үнийн зөрүүгээр)

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (төлсөн дүнгээр)

24.5.3.б.Хэрэв халаасны хувьцааг эргүүлэн худалдаж, эргэлтэнд гаргасан бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (авсан дүнгээр)

Дебет эсхүл Кредит: Нэмж төлөгдсөн капитал (үнийн зөрүүгээр)

Кредит: Халаасны хувьцаа (нэрлэсэн үнээр)

24.5.4.Халаасны хувьцааг бүртгэх өртгийн аргын үед халаасны хувьцааг худалдан авсан өртгөөр үнэлж бүртгэнэ:

24.5.4.а. Хувьцаагаа эргүүлэн худалдан авахад:

Дебет: Халаасны хувьцаа (өртгөөр)

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (өртгөөр)

24.5.4.б. Хэрэв халаасны хувьцааг эргүүлэн худалдаж, эргэлтэнд гаргасан бол:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс (авсан дүнгээр)

Дебет эсхүл Кредит: Нэмж төлөгдсөн капитал (зөрүүгээр)

Кредит: Халаасны хувьцаа (өртгөөр)

24.5.5.Халаасны хувьцаатай холбоотой ажил гүйлгээг бүртгэх үед нэмж төлөгдсөн капитал дансны үлдэгдэл хүрэлцэхгүй тохиолдолд нэмж төлөгдсөн

капитал дансыг хаасны дараа уг нэмж төлөгдсөн капитал дансны дебет талд бичигдэх дүнг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэнэ.

#### **24.6.Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл**

24.6.1.Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийг дахин үнэлгээний загвараар бүртгэсэн тохиолдолд хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэнэ.

24.6.2.Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн бүртгэлийг энэ журмын “Үндсэн хөрөнгө” бүлгээс үзнэ үү.

#### **24.7.Хуримтлагдсан ашиг, алдагдал**

24.7.1.Хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлэх эсхүл бууруулах дараах тохиолдол байна:

Хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлэх буюу уг дансны кредитэд бүртгэх үзүүлэлт:

- а. Тайлант үеийн цэвэр ашиг
- б. Өмнөх үеийн залруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт
- в. Дахин үнэлгээний бууралт (хэрэгжсэн хэсэг)
- г. Өөрийн хөрөнгийн сан, нөөцийн дансыг хаах буцаалт

Хуримтлагдсан ашгийг бууруулах буюу уг дансны дебетэд бүртгэх үзүүлэлт:

- а. Тайлант үеийн цэвэр алдагдал
- б. Өмнөх үеийн залруулга ба нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт
- в. Ногдол ашиг хуваарилалт
- г. Халаасны хувьцааны гүйлгээ

24.7.2.Тайлант хугацааны эцэст орлого, зардлын дансдын хаалтын гүйлгээг хийж, тайлант үеийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлох ба уг дансны үлдэгдлийг хуримтлагдсан ашиг дансанд хаана.

24.7.2.а.Орлогын дансдыг хаахад:

Дебет: Орлогын дансууд

Кредит: Тайлант үеийн ашиг/алдагдал

24.7.2.б.Зардлын дансдыг хаахад:

Дебет: Тайлант үеийн ашиг/алдагдал

Кредит: Зардлын дансууд

24.7.2.в.Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдлыг тодорхойлоход:

Тайлант хугацаанд ашигтай ажилласан бол цэвэр ашгийн дүнгээр хаалтын бичилт хийнэ:

Дебет: Тайлант үеийн ашиг

Кредит: Хуримтлагдсан ашиг

24.7.2.г.Тайлант хугацаанд алдагдалтай ажилласан бол цэвэр алдагдлын дүнгээр хаалтын бичилт хийнэ:

Дебет: Хуримтлагдсан ашиг

Кредит: Тайлант үеийн алдагдал

24.7.3.Тайлант жилийн ашгийн хуваарилалтыг дараах байдлаар бүртгэнэ:

24.7.3.а.Ногдол ашиг хуваарилахаар зарлахад:



Дебет: Өмнөх жилийн хуримтлагдсан ашиг

Кредит: Ногдол ашгийн өглөг

24.7.3.б.Ногдол ашгийг олгоход:

Дебет: Ногдол ашгийн өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

24.7.3.в.Тайлант хугацааны цэвэр ашгаас нөөцийн сан, бусад тусгай зориулалтын санд хөрөнгө хуваарилахаар шийдвэрлэсэн бол:

Дебет: Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг

Кредит: Сангийн холбогдох данс

## **ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ**

25.1.Өмчийн бусад хэсэг (бусад өөрийн хөрөнгө) нь нөөцийн сан, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц, эрсдэлийн сангийн нөөц, нийгмийн хөгжлийн сан, хувьцаанд хөрвөх үнэт цаас, хувьцаанд хөрвөх эх үүсвэр, бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны дахин үнэлгээний сан, хейжийн хэрэгслийн дахин үнэлгээний сан зэргээс бүрдэнэ.

### **25.1.Тусгай зориулалттай сан**

25.1.1.ТЗЭ нь харилцагч, үйлчлүүлэгчтэй холбоотой үүсэх зардалд зарцуулах зорилгоор хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичигт шаардсаны дагуу тусгай зориулалттай сан байгуулж болно. Мөн тусгай зориулалттай санг хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдийн шийдвэрээр хуримтлагдсан ашгаас байгуулж болно.

25.1.2.Тусгай зориулалттай сангаас ногдол ашиг хуваарилахгүй. Түүнчлэн хуримтлагдсан ашиг хүрэлцэхгүй эсхүл алдагдлыг хуримтлуулсан тохиолдолд тусгай зориулалттай сан байгуулж болохгүй. Тусгай зориулалттай санг хуримтлагдсан ашгаас байгуулах тул зардал хүлээн зөвшөөрөхгүй.

25.1.2.а.Тусгай зориулалттай санг байгуулахад:

Дебет: Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг

Кредит: Сангийн холбогдох данс

25.1.2.б.Тусгай зориулалтын сангаас зориулалтын дагуу хөрөнгө зарцуулахад:

Дебет: Сангийн холбогдох данс

Кредит: Холбогдох хөрөнгийн данс

25.1.2.в.Тусгай зориулалтын санг буцаахад:

Дебет: Сангийн холбогдох данс

Кредит: Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг

25.1.3.Санхүүгийн хөрөнгөнд холбогдох активын ангиллын журмаар тооцоолсон эрсдэлийн сангийн дүн нь СТОУС-ын дагуу байгуулах эрсдэлийн сангаас өндөр гарвал эдгээрийн зөрүүг эрсдэлийн сангийн нөөцөд бүртгэнэ. Эрсдэлийн сангийн нөөцийн бүртгэлийг энэ журмын “Зээл” бүлгээс үзнэ үү.

25.1.3.а.Эрсдэлийн сангийн нөөцийг хуримтлагдсан ашгаас байгуулахад:

Дебет: Хуримтлагдсан ашиг  
Кредит: Эрсдэлийн сангийн нөөц

25.1.3.б.Эрсдэлийн сангийн нөөцийг бууруулах эсхүл буцаах үед:

Дебет: Эрсдэлийн сангийн нөөц  
Кредит: Хуримтлагдсан ашиг

25.1.4.Нийгмийн хөгжлийн санг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу олгохоор хүлээсэн ТЗЭ-ийн үүрэг эсхүл үүсмэл үүргийг ойлгоно. Нийгмийн хөгжлийн санг удирдлагын тушаал, шийдвэрээр эсхүл тухайн тайлант хугацаанд хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний болон гэрээний бус үүргийн дагуу хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

25.1.4.а.Нийгмийн хөгжлийн санг удирдлагын шийдвэрээр жил бүр байгуулна. Нийгмийн хөгжлийн санг тайлант хуримтлагдсан ашгаас хуваарилан байгуулж, өөрийн хөрөнгийн дансанд бүртгэж болно:

Дебет: Хуримтлагдсан ашиг  
Кредит: Нийгмийн хөгжлийн сан (Өөрийн хөрөнгө)

25.1.4.б.Нийгмийн хөгжлийн сангаас зориулалтын дагуу хөрөнгө зарцуулахад:

Дебет: Нийгмийн хөгжлийн сан  
Кредит: Холбогдох хөрөнгийн данс

25.1.4.в.Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан өөрийн хөрөнгийн санг буцаахад:

Дебет: Нийгмийн хөгжлийн сан (өөрийн хөрөнгө)  
Кредит: Хуримтлагдсан ашиг

## **25.2.Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц**

25.2.1.Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц нь ТЗЭ-ийн бүртгэлийн валют нь толилуулгын валютаас зөрүүтэй үед санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүг харуулна.

## **25.3.Нийлмэл санхүүгийн хэрэгсэл**

25.3.1.Санхүүгийн хэрэгсэл нь өр төлбөр ба өмчийн бүрэлдэхүүн хэсгийн аль алиныг агуулж байвал нийлмэл санхүүгийн хэрэгсэл болно. Тухайлбал, хувьцаанд хөрвөх үнэт цаас, хувьцаанд хөрвөх эх үүсвэр. Нийлмэл санхүүгийн хэрэгслийг өр төлбөр ба өөрийн хөрөнгөөр салгаж, бүртгэнэ. Хөрвөх өр төлбөрийн бүртгэлийг энэ журмын “Санхүүгийн өр төлбөр” бүлэгт заасныг үзнэ үү.

## **25.4.Хувьцаанд суурилсан төлбөр**

25.4.1.ТЗЭ нь ажилтнууддаа хувьцаа, түүнтэй адилтгах өмчийн хэрэгслээр эсхүл түүнд суурилсан мөнгөн төлбөрөөр шагнал, урамшуулал олгох, гуравдагч этгээдэд төлбөр тооцоо барагдуулахыг хувьцаанд суурилсан төлбөр гэнэ.

25.4.2.Хувьцаанд суурилсан төлбөр нь өмчөөр барагдуулах, мөнгөөр барагдуулах, мөнгөөр эсхүл өмчийн хэрэгсэл гарган барагдуулах сонголт олгож байгаа холимог төлбөр гурван төрөлтэй байна.

25.4.3.Хувьцаанд суурилсан төлбөрийг бүртгэхдээ СТОУС 2-д заасан шинжилгээг гүйцэтгэнэ.

25.4.4.Өмчөөр барагдуулах төлбөр гэж ТЗЭ хувьцааны төлбөрт бараа, ажил, үйлчилгээ авсан эсхүл бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа үнийг нь мөнгөөр бус хувьцаагаар төлөхийг хэлнэ. Хүлээн авсан бараа, ажил, үйлчилгээний бодит үнэ цэнэ, хэрэв үүнийг найдвартай тодорхойлох боломжгүй бол олгох өмчийн хэрэгслийн бодит үнэ цэнийн тухайн тайлант хугацаанд хуваарилагдсан хэсгийн дүнгээр өөрийн хөрөнгийг бүртгэнэ. Ажилтнуудтай холбоотой хувьцаанд суурилсан төлбөрийн хувьд холбогдох зардлын дансыг ашиглана. Гуравдагч талын хувьд хөрөнгө худалдан авахын тулд хувьцаа гаргасан бол хөрөнгийн дансанд (тухайлбал, үндсэн хөрөнгө) бүртгэнэ. Бэлтгэн нийлүүлэгч үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд зардалд бүртгэнэ:

Дебет: Зардлын холбогдох данс эсхүл Хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Өмчийн бусад хэсэг (өөрийн хөрөнгө) - Хувьцааны опшин

25.4.5.Мөнгөөр барагдуулах төлбөр гэж хүлээн авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг хувьцааны үнэнд суурилан тогтоох боловч эцэстээ мөнгөөр төлөхийг хэлнэ.

25.4.5.а.Мөнгөөр барагдуулах төлбөрийн хувьд өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Зардлын холбогдох данс эсхүл Хөрөнгийн холбогдох данс  
Кредит: Мөнгөөр төлөгдөх хувьцааны опшин

25.4.5.б.Мөнгөөр төлөгдөх хувьцааны опшины өр төлбөрийг тайлагналын хугацааны эцэст бодит үнэ цэнээр үнэлж, уг үнэлгээгээр үүссэн зөрүүг тухайн тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Өр төлбөрийн үнэлгээг нэмэгдүүлэхэд:

Дебет: Үнэлгээний өөрчлөлтийн гарз  
Кредит: Мөнгөөр төлөгдөх хувьцааны опшин

Өр төлбөрийн үнэлгээг бууруулахад:

Дебет: Мөнгөөр төлөгдөх хувьцааны опшин  
Кредит: Үнэлгээний өөрчлөлтийн олз

25.4.5.в.Төлбөрийг мөнгөөр барагдуулахад:

Дебет: Мөнгөөр төлөгдөх хувьцааны опшин  
Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

25.4.6.Хувьцаанд суурилан төлбөрийг өмчөөр эсхүл мөнгөөр барагдуулах сонголттой нөхцөлд үүнийг мөнгөөр барагдуулах хувьцаанд суурилсан төлбөрийн нэгэн адил бүртгэх ба өр төлбөр үүсгэн, бүртгэнэ.

## **25.5.Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний сан**

25.5.1.Санхүүгийн хэрэгслийн үнэлгээг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх үед бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлсэн үнэт цаасны дахин үнэлгээний сан, хейжийн үнэлгээний өөрчлөлтийг бүртгэх үед хейжийн

хэрэгслийн дахин үнэлгээний сан дансыг ашиглах ба эдгээрийн бүртгэлийг энэ журмын “Хөрөнгө оруулалт”, “Дериватив” бүлгүүдээс үзнэ үү.

## **ХОРИН ЗУРГААДУГААР БҮЛЭГ ОРЛОГО**

26.1. Орлогод орлого болон олз багтана.

26.1.1. Орлого гэж өмч эзэмшигчдээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий хөрөнгийн орлогын гүйлгээ буюу сайжруулалт, эсхүл өр төлбөрийн бууралт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм.

26.1.2. Олз гэж үйл ажиллагааны явцад үүсэж болох, орлогын тодорхойлолтод нийцэх бусад зүйлсийг ойлгоно. Тухайлбал, олзонд эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах үеийн олз, хэрэгжсэн ба хэрэгжээгүй олз (гадаад валютын, үнэт цаасны үнэлгээний ба арилжааны гэх мэт) багтана.

26.1.3. Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлөө авч буй төлбөр юм.

### **26.2. Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

26.2.1. Хөрөнгийн өсөлт эсхүл өр төлбөрийн бууралттай холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн нэмэгдэлт үүссэн бөгөөд түүнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд орлогын тайланд орлогыг хүлээн зөвшөөрнө.

26.2.2. Орлогыг хүлээн авсан мөнгө эсхүл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

26.2.3. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшинг ашиглан тооцож, үнэлнэ. Гэрээний дагуу нэмэлт төлбөр, хойшлогдсон орлого, зардал гараагүй нөхцөлд хүүгийн орлогыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ. Хямдруулалт, урамшуулал, хойшлуулсан орлого, зардлыг холбогдох санхүүгийн хэрэгслийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хуваарилж, бүртгэнэ.

### **26.3. Дансны бичилт**

26.3.1. Орлогод хүүгийн орлого, арилжааны орлого, үнэлгээний өөрчлөлтийн олз, хураамж, шимтгэлийн орлого, бусад орлого, олз хамрагдана.

26.3.2. Хүүгийн орлогыг өдөр бүр тооцоолж, хуримтлуулахад:

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага  
Кредит: Хүүгийн орлого

26.3.3. Гадаад валют, үнэт цаас гэх мэт санхүүгийн хэрэгслийг худалдан борлуулахад худалдсан өдрийн дансны үлдэгдэл ба борлуулсан үнийн зөрүүг арилжааны орлого, зардалд бүртгэнэ. Арилжааны орлого, зардлын бүртгэлийг энэ журмын санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн холбогдох бүлгүүдэд тусгасан.

26.3.4. Гадаад валютын ханш өөрчлөгдөх тухай бүрд гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд тохируулга хийх ба үүссэн зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгийг худалдаж, өр төлбөрийг барагдуулах үед ханшийн зөрүүний хэрэгжээгүй орлого, зардлыг хэрэгжсэн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

26.3.4.а.Хөрөнгийн хувьд гадаад валютын ханш өсөхөд:

Дебет: Гадаад валютаар илэрхийлэгдэх хөрөнгө

Кредит: Гадаад валютын ханшийн зөрүүний олз

26.3.4.б.Өр төлбөрийн хувьд гадаад валютын ханш буурахад:

Дебет: Гадаад валютаар илэрхийлэгдэх өр төлбөр

Кредит: Гадаад валютын ханшийн зөрүүний олз

26.3.5.Бодит үнэ цэнээр үнэлж, толилуулах хөрөнгө, өр төлбөрийн үнэлгээний өсөлт, бууралтыг үнэлгээний өөрчлөлтийн олз, гарзаар бүртгэнэ. Үнэлгээний өөрчлөлтийн олз, гарзыг хооронд нь хааж, цэвэр дүнгээр санхүүгийн тайланд орлого эсхүл зардлаар толилуулна.

26.3.5.а.Хөрөнгийн хувьд бодит үнэ цэнэ өсөхөд:

Дебет: Холбогдох хөрөнгийн данс

Кредит: Үнэлгээний өөрчлөлтийн олз

26.3.5.б.Өр төлбөрийн хувьд бодит үнэ цэнэ буурахад:

Дебет: Холбогдох өр төлбөрийн данс

Кредит: Үнэлгээний өөрчлөлтийн олз

26.3.6.Санхүүгийн үйлчилгээний шимтгэлийн орлогын бүртгэл нь түүний зориулалт, холбогдох санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн суурь зэргээс шалтгаалан тодорхойлогдоно. Санхүүгийн үйлчилгээний шимтгэл нь уг ажил үйлчилгээний онцлог шинж, мөн чанарыг агуулахгүй байх тохиолдол гарч болно. Иймээс санхүүгийн хэрэгслийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон шимтгэл, үйлчилгээний шимтгэл, тодорхой үйлчилгээ үзүүлсний төлөө авсан хураамж зэргийг ялгаатай авч үзнэ.

26.3.7.Дараах шимтгэлийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна:

26.3.7.а.Санхүүгийн хөрөнгийг анх гаргах, эсхүл худалдан авахтай холбоотойгоор төлөгдсөн шимтгэл: Ийм шимтгэлд зээлдэгчийн санхүүгийн байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа хөрөнгө, үнэт цаасны хэлцлийг үнэлж, бүртгэх, санхүүгийн хэрэгслийн нөхцөлийг харилцан тохиролцох, холбогдох баримтыг бүрдүүлж, боловсруулах, арилжааг хаах зэрэг үйл ажиллагаанд хамаарах хураамж багтана. Ийм шимтгэл болон холбогдох арилжааны зардал нь санхүүгийн хэрэгслийг бий болгох үйл ажиллагаанд хамаарах ба үүнийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна;

26.3.7.б.Зээлд хамаарах үүрэг хүлээсэн үед зээл олгохтой холбогдуулан төлөгдсөн шимтгэл: Зээлийн тусгай хэлцэл байгуулж, үүнтэй холбоотой зээлд хамаарах үүрэг нь болзошгүй үүрэгтэй холбоотойгоор төлөгдсөн шимтгэлийг холбогдох арилжааны зардлын хамт санхүүгийн хэрэгслийг бий болгох үйл ажиллагаанд хамаатай гэж үзэх ба эдгээрийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна. Хэрэв ТЗЭ зээл олгоогүй байхад уг үүргийн хугацаа дууссан бол хугацаа дууссан өдрөөр шимтгэлийг орлогод бүртгэнэ;

26.3.7.в.Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөрийг гаргах үед төлөгдсөн шимтгэл: Ийм шимтгэл нь санхүүгийн хэрэгслийг бий болгох үйл

ажиллагаанд хамаарах орлого юм. Үүнийг холбогдох арилжааны зардлын хамт санхүүгийн хэрэгслийг анх удаад хүлээн зөвшөөрөх үеийн дансны дүнд оруулан тооцох ба эдгээрийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна.

26.3.8.Үйлчилгээний дараах шимтгэлийг тайлант үеийн орлогоор бүртгэнэ:

26.3.8.а.Зээлийн үйлчилгээний шимтгэл: Зээлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх үед төлөгдсөн шимтгэлийг үйлчилгээг үзүүлсэн даруйд орлогоор бүртгэнэ;

26.3.8.б.Зээл олгоход хамаарах болзошгүй үүргийн шимтгэл: Зээлийн тусгай хэлцэл байгуулж, үүнтэй холбоотой зээлд хамаарах үүрэг нь болзошгүй үүрэгтэй холбоотойгоор төлөгдсөн шимтгэлийг болзошгүй үүрэг хүлээх хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрч, бүртгэнэ;

26.3.8.в.Хөрөнгө оруулалтын удирдлагын шимтгэл: Хөрөнгө оруулалтыг удирдахтай холбоотойгоор төлөгдсөн шимтгэлийг үйлчилгээ үзүүлсний дараа орлогоор бүртгэнэ.

26.3.9.Холбогдох үйлдлийг хэрэгжүүлж, гүйцэтгэсний дараа шимтгэлийг орлогоор бүртгэнэ:

26.3.9.а.Харилцагчид хувьцаа хуваарилах шимтгэл: Хувьцааг хуваарилсны дараа уг шимтгэлийг орлогоор бүртгэнэ;

26.3.9.б.Зээлдэгч, хөрөнгө оруулагчдын хооронд зээлийн хэлцэл хийхтэй холбоотой төлбөр тооцооны шимтгэл: Зээлийн хэлцэл хийгдсэний дараа уг шимтгэлийг орлогоор бүртгэнэ. Зээлдэгчийн хувьд шимтгэлийг дээрхтэй адил ангилж, бүртгэнэ. Өөрөөр хэлбэл ТЗЭ зээлдэгч болсон тохиолдолд дээр заасны дагуу шимтгэлийг хойшлуулах эсэх болон ямар сууриар хойшлуулахыг тогтооно. Зарим нөхцөлд төлсөн төлбөр (зээл олгох болон бусад санхүүгийн хөрөнгийг гаргахад төлсөн) болон авсан шимтгэлийг (санхүүгийн өр төлбөрийг татан төвлөрүүлэхэд төлөгдсөн) санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэд оруулж тооцохгүй. Энэ нь хүүгүй эсхүл зах зээлийн хүүгээс ялгаатай хүүтэй зээл олгоход тохиолддог. Татан төвлөрүүлсэн зээлийн болон бусад эх үүсвэртэй холбоотойгоор дээрх нөхцөл байдал үүсэж болно. Энэ тохиолдолд бодит үнэ цэнэ нь төлсөн буюу авсан мөнгөн дүнтэй тэнцэхгүй бөгөөд тусгай нөхцөл хангагдаагүй тохиолдолд санхүүгийн хэрэгслийг анх удаад хүлээн зөвшөөрөх үед орлого, зардал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

26.3.10.Бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлснээр хураамж, шимтгэлийн орлогыг бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс эсхүл харилцагчийн харилцах, хадгаламжийн данс

Кредит: Холбогдох хураамж, шимтгэлийн орлого

26.3.11.Бусад орлого, олзонд хөрөнгө данснаас хассаны олз, борлуулсан буюу дамжуулан түрээсэлсэн хөрөнгийн олз, хөрөнгийн дахин үнэлгээний олз (үнэ цэнийн бууралтын буцаалт), түрээсийн орлого, торгуулийн орлого, алдангийн орлого, ногдол ашгийн орлого, тэнцлийн гадуурх данснаас орсон орлого, хөрөнгийг зах зээлийн түвшнээс өндөр хувь хэмжээгээр анх удаад хүлээн зөвшөөрсний орлого, өр төлбөрийг зах зээлийн түвшнээс бага хувь хэмжээгээр анх удаад хүлээн зөвшөөрсний орлого, хандив, тусламжийн орлого хамрагдана.

26.3.11.а.ТЗЭ нь хөрөнгөө үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн гэрээний дагуу түрээсийн төлбөрийг хуримтлуулан тооцоолж, орлогоор бүртгэхэд:

Дебет: Үйл ажиллагааны түрээсийн авлага

Кредит: Хөрөнгийн түрээсийн орлого

26.3.11.б. Үндсэн хөрөнгө борлуулсны олзыг бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн дансны эсхүл бусад харилцагчийн харилцах данс буюу бусад тооцооны данс

Кредит: Үндсэн хөрөнгө борлуулсны олз

26.3.11.в. Бусад орлогыг бүртгэхэд:

Дебет: Мөнгөн хөрөнгийн данс эсхүл бусад тооцооны данс

Кредит: Бусад орлого

## **ХОРИН ДОЛООДУГААР БҮЛЭГ ЗАРДАЛ**

27.1.Зардалд зардал болон гарз багтана.

27.1.1.Зардал гэж өмч эзэмшигчдэд олгосон хуваарилалттай холбоотойгоос бусад байдлаар өмчийг багасгах үр дүн бүхий хөрөнгийн зарлагын гүйлгээ буюу хорогдон багасалт, эсхүл өр төлбөрийн үүсэлт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөжийн бууралт юм.

27.1.2.Гарз гэж ТЗЭ-ийн үйл ажиллагааны явцад үүсэж болох, зардлын тодорхойлолтод нийцэх бусад зүйлсийг ойлгоно.

27.1.3.Хүүгийн зардал нь ТЗЭ-ийн үйл ажиллагааны эх үүсвэрт ашиглах зорилгоор бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлбөр буюу өртөг байна.

### **27.2.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт**

27.2.1.Хөрөнгийн бууралт эсхүл өр төлбөрийн өсөлттэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн багасалт үүссэн бөгөөд түүнийг найдвартайгаар хэмжиж чадах тохиолдолд орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө.

27.2.2.Зардлыг төлсөн мөнгө эсхүл үүссэн өглөгийн бодит үнэ цэнээр үнэлнэ.

27.2.3.Хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшнээр тооцож үнэлнэ. Татан төвлөрүүлсэн эх үүсвэртэй холбоотой нэмэлт урамшуулал, хямдруулалт, хойшлогдсон орлого болон зардал гараагүй нөхцөлд хүүгийн зардлыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ.

### **27.3.Дансны бичилт**

27.3.1.Зардалд хүүгийн зардал, эрсдэлийн сангийн зардал, арилжааны зардал, үнэлгээний өөрчлөлтийн гарз, үйл ажиллагааны бусад зардал хамрагдана.

27.3.2.Хүүгийн зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгийн төрлөөр ангилж бүртгэхэд:

27.3.2.а.Хүүг хуримтлуулан тооцоход:

Дебет: Хүүгийн зардал

Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн холбогдох өглөг

27.3.2.б.Хүүг хуримтлуулалгүй, шууд төлсөн бол:

Дебет: Хүүгийн холбогдох зардал

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

27.3.2.в.Хүүгийн зардлыг буцаахад:

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн холбогдох өглөг

Кредит: Хүүгийн зардлын буцаалт

27.3.3.Хураамж, шимтгэл бүхий санхүүгийн өр төлбөрийн хувьд уг хураамж, шимтгэлийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүг тодорхойлон бүртгэх эсэхийг тогтооно. Хэрэв хураамж, шимтгэлийг үр ашигт хүүд оруулан тооцсон бол үүнийг хүүгийн зардалд бүртгэнэ.

27.3.4.Хөрөнгийн үнэ цэнэ буурч, эрсдэлийн сан байгуулахад холбогдох эрсдэлийн зардлыг хүлээн зөвшөөрнө. Эрсдэлийн сангийн зардлын бүртгэлийг энэ журмын харгалзах хөрөнгийн бүлэгт тусгасан.

27.3.5.Гадаад валют, үнэт цаас гэх мэт санхүүгийн хэрэгслийг худалдан борлуулахад худалдсан өдрийн дансны үлдэгдэл ба борлуулсан үнийн зөрүүг арилжааны орлого, зардалд бүртгэнэ. Арилжааны орлого, зардлын бүртгэлийг энэ журмын санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн холбогдох бүлгүүдэд тусгасан.

27.3.6.Гадаад валютын ханш өөрчлөгдөх тухай бүрд гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд тохируулга хийх ба үүссэн зөрүүг гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзаар бүртгэнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгийг худалдаж, өр төлбөрийг барагдуулах үед ханшийн зөрүүний хэрэгжээгүй олз, гарзыг хэрэгжсэн олз, гарзад шилжүүлэн бүртгэнэ.

27.3.6.а.Хөрөнгийн хувьд гадаад валютын ханш буурахад:

Дебет: Гадаад валютын ханшийн зөрүүний гарз

Кредит: Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө

27.3.6.б.Өр төлбөр, өөрийн хөрөнгийн хувьд гадаад валютын ханш өсөхөд:

Дебет: Гадаад валютын ханшийн зөрүүний гарз

Кредит: Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр төлбөр

27.3.7.Бодит үнэ цэнээр үнэлж, толилуулах хөрөнгө, өр төлбөрийн үнэлгээний өсөлт, бууралтыг үнэлгээний өөрчлөлтийн олз, гарзаар бүртгэнэ. Үнэлгээний өөрчлөлтийн олз, гарзыг хооронд нь хааж, цэвэр дүнгээр санхүүгийн тайланд орлого эсхүл зардлаар толилуулна.

27.3.7.а.Хөрөнгийн хувьд бодит үнэ цэнэ буурахад:

Дебет: Үнэлгээний өөрчлөлтийн гарз

Кредит: Холбогдох хөрөнгийн данс

27.3.7.б.Өр төлбөрийн хувьд бодит үнэ цэнэ өсөхөд:

Дебет: Үнэлгээний өөрчлөлтийн гарз

Кредит: Холбогдох өр төлбөрийн данс

27.3.8.Үйл ажиллагааны бусад зардалд үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа цалин хөлс, татвар, шимтгэл гэх мэт удирдлага, борлуулалтын зардал багтана. Үйл ажиллагааны бусад зардлыг төрөл тус бүрээр ангилж, бүртгэнэ.

27.3.8.а.Гарсан зардлыг шууд мөнгөөр төлөхөд:

Дебет: Холбогдох зардлын данс



Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

27.3.8.б.Зээлээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх үед мөнгөөр төлөгдөөгүй боловч хугацаанд ногдох зардлыг хуримтлуулж бүртгэхэд:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Холбогдох өглөгийн данс

27.3.8.в.Зээлээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний үнэ буюу хуримтлуулж бүртгэсэн зардлыг мөнгөөр төлөхөд:

Дебет: Холбогдох өглөгийн данс

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

27.3.8.г.Үйл ажиллагаанд хэрэглэгдэх хангамжийн зүйлс, маягтыг худалдан авч, ашиглалтад шууд тавьж олгоход:

Дебет: Материал хангамжийн зардал

Кредит: Мөнгөн хөрөнгө болон тооцооны холбогдох данс

27.3.8.д.Богино хугацаат түрээс болон суурь хөрөнгийн үнэлгээ бага түрээсийн үед гэрээний дагуу түрээсийн төлбөр төлөхөд:

Дебет: Түрээсийн зардал

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

27.3.8.е.Зардлыг урьдчилан төлөхөд:

Дебет: Урьдчилж төлсөн зардал

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

27.3.8.ё.Урьдчилж төлсөн зардлыг жинхэнэ хэрэгжилтийн сууриар зардалд хуваарилахад:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Урьдчилж төлсөн зардал

27.3.9.Цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой ажил гүйлгээ гарах үе дараах байдлаар бүртгэнэ:

27.3.9.а.Цалин олговрыг тооцооны хүснэгт, бусад баримтыг үндэслэн олгохоор тооцсон дүнгээр:

Дебет: Цалингийн зардал

Кредит: Цалингийн өглөг

27.3.9.б.Даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн дүнгээр:

Дебет: Цалингийн өглөг

Кредит: НДШ-ийн өглөг

27.3.9.в.Цалингаас суутгах ХХОАТ-ын дүнгээр:

Дебет: Цалингийн өглөг

Кредит: Суутган тооцсон татварын өглөг (ХХОАТ-ын өглөг)

27.3.9.г.Эдгээр болон бусад суутгалуудыг хассаны дараа гарт олгох дүнгээр:

Дебет: Цалингийн өглөг

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

27.3.9.д.Хувь хүний орлогын татварыг харьяа татварын байгууллагад шилжүүлэхэд:

Дебет: Суутган тооцсон татварын өглөг

Кредит: Холбогдох харилцах данс

27.3.9.е.Цалин хөлс, нэмэгдэл, хөнгөлөлтөөс тооцсон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүртгэхэд:

Дебет: НД ба ЭМДШ-ийн зардал

Кредит: ЭМНД ба ЭМДШ-ийн өглөг

27.3.9.ё.Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг харьяа нийгмийн даатгалын байгууллагад төлөхөд:

Дебет: НД ба ЭМДШ-ийн өглөг

Кредит: НД ба ЭМДШ-ийн холбогдох харилцах данс

27.3.9.ж.Ажилчдад тогтмол болон цаг үеийн хөнгөлөлт олгох үед олгохоор тооцсон дүнгээр:

Дебет: Хөнгөлөлтийн зардал

Кредит: Цалингийн өглөг

27.3.10.Тэтгэврийн сангийн бүртгэлийг энэ журмын “Ажилтны тэтгэмж” бүлэгт оруулсан. ТЗЭ ажилтнууддаа бусад төрлийн тэтгэмж олгох үед нийгмийн хөгжлийн сан байгуулж, ашиглаж болох ба нийгмийн хөгжлийн сангийн бүртгэлийг энэ журмын “Өөрийн хөрөнгө” бүлэгт оруулсан.

27.3.11.Бусад зардал, гарзад хөрөнгө данснаас хассаны гарз, хөрөнгийн дахин үнэлгээний гарз (үнэ цэнийн бууралтын зардал), зочин төлөөлөгч, баяр ёслолын зардал, хандив, торгууль, хөрөнгийг зах зээлийн түвшнээс доогуур хувиар анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн зардал, өр төлбөрийг зах зээлийн түвшнээс дээгүүр хувиар анх удаа хүлээн зөвшөөрөх үеийн зардал, зээлд хамаарах үүрэг ба хуулийн байгууллагаар шийдэгдэж байгаа зүйлсэд байгуулсан нөөцийн зардал хамрагдана.

27.3.11.а. Хууль тогтоомж зөрчсөний улмаас торгууль төлөхөд:

Дебет: Торгуулийн зардал

Кредит: Холбогдох харилцах данс

27.3.11.б. Үндсэн хөрөнгийг данснаас хасахад:

Дебет: Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө данснаас хассаны гарз

Кредит: Үндсэн хөрөнгө

27.3.12.Бусад төрлийн зардал, гарзын бүртгэлийг энэ журмын холбогдох бусад бүлэгт дэлгэрэнгүй оруулсан. Зээлд хамаарах үүрэг болон бусад зарга маргаанд байгуулсан нөөцийн бүртгэлийг энэ журмын “Нөөц ба болзошгүй өр төлбөр” бүлэгт оруулсан.

## **ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР**

28.1.Нягтлан бодох бүртгэлийн ашиг, алдагдал (татварын өмнөх ашиг, алдагдал) гэж санхүүгийн бүртгэлээр тооцоолж гаргасан, тайлант үеийн татварын зардлыг хасахын өмнөх ашиг, алдагдлыг хэлнэ.

28.2.Татвар ногдуулах орлого (татварын алдагдал) гэж Монгол улсын татварын хуулийн дагуу тооцож, тухайн дүнгээс тайлант үед төлөх орлогын албан татварыг тооцох орлогыг хэлнэ.

### 28.3.Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт

28.3.1.Татварын түр зөрүү гэдэг нь татварын хөрөнгө, өр төлбөрийн дансны үлдэгдэл ба татварын суурийн хоорондох зөрүүг хэлнэ. Түр зөрүүний нөлөөг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн дансанд бүртгэнэ. Түр зөрүү нь татвар ногдох түр зөрүү ба хасагдах зөрүү гэсэн хоёр хэлбэртэй.

28.3.2.Татварын түр зөрүү дараах тохиолдолд үүснэ:

- Санхүүгийн тайлагнал ба татварын зорилгоор хөрөнгийн элэгдлийн арга, зарчим, хугацаа өөр байх;
- Нөөц байгуулсан зардлыг татварын зорилгоор татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй байх;
- Хөрөнгийн үнэ цэнийн бууралт, хөрөнгийг данснаас хассанаас үүсэх зардлыг татварын зорилгоор татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй байх;
- Мөнгөн зүйлсийн үлдэгдэлд валютын ханшийн тэгшитгэл хийснээс үүсэх валютын ханшийн хэрэгжээгүй олз, гарз;
- Татварын хуулиар тогтоосон хязгаарлалтыг давсан урсгал засварын зардал;
- Татварын албаар баталгаажуулсан татварын тайлангаарх алдагдлыг дараагийн үед шилжүүлэн тооцох;
- Санхүүгийн хэрэгслийн бодит үнийн өөрчлөлт;
- СТОУС-ын дагуу хийх залруулгууд.

28.3.3.Татвар ногдох түр зөрүү нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах орлогыг нэмэгдүүлэх нөлөө үүсгэх түр зөрүү юм. Татвар ногдох түр зөрүү үүссэн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөрийг заавал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

28.3.4.Хасагдах түр зөрүү нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах орлогыг бууруулах нөлөө үүсгэх түр зөрүү юм. Хасагдах түр зөрүүг ирээдүйд нөхөх боломжтой үед хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

28.3.5.Хойшлогдсон татварын хөрөнгө ирээдүйд нөхөгдөх боломжтой эсэхийг үнэлэхдээ ирээдүйд татвар ногдуулах хангалттай хэмжээний орлого (хасагдах түр зөрүүний ирээдүй үеийн буцаалтыг оролцуулалгүйгээр) олох эсэх буюу ирээдүйн тайлант үед олох хүлээгдэж буй татвар ногдуулах орлогын төсөөлөлд үндэслэнэ. Дараагийн тайлант үеүдэд алдагдалтай ажиллах магадлалтай байгаа нөхцөлд хасагдах түр зөрүү нөхөгдөхгүй тул хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрч, бүртгэхгүй.

28.3.6.Татвар ногдох ба хасагдах түр зөрүүг үүсэх нөхцөл байдал нь:

	<i>Хөрөнгийн хувьд</i>	<i>Өр төлбөрийн хувьд</i>
Дансны үнэ > Татварын суурь	Татвар ногдох түр зөрүү үүснэ	Хасагдах түр зөрүү үүснэ
Дансны үнэ < Татварын суурь	Хасагдах түр зөрүү үүснэ	Татвар ногдох түр зөрүү үүснэ

28.3.7.Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагдана.

28.3.8.Тайлант хугацаанд хамаарах орлогын албан татварын өглөгийг тайлант хугацааны эцсээр хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр татварын эрх бүхий байгууллагад төлөх эсхүл хүлээн авах дүнгээр хэмжинэ.

28.3.9.Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээг ашиглан тооцоолно.

$$\text{Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр} = \text{Татвар ногдох эсхүл хасагдах түр зөрүү} \times \text{Татварын хувь хэмжээ}$$

28.3.10.Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн эцсийн үлдэгдэл ба эхний үлдэгдлийн зөрүүгээр хойшлогдсон татварын зардал, орлогыг тооцоолж, хэмжинэ.

28.3.11.Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны өсөлт, хойшлогдсон татварын өр төлбөрийн дансны бууралтыг хойшлогдсон татварын орлогод бүртгэнэ. Харин хойшлогдсон татварын хөрөнгийн дансны бууралт, хойшлогдсон татварын өр төлбөрийн дансны өсөлтийг хойшлогдсон татварын зардалд бүртгэнэ.

#### **28.4.Дансны бичилт**

28.4.1.Тайлант үеийн татварыг дараах байдлаар бүтгэнэ:

28.4.1.а.Орлогын албан татварыг урьдчилж төлөхөд:

Дебет: Татварын авлага

Кредит: Мөнгөн хөрөнгийн холбогдох данс

28.4.1.б.Хууль тогтоомжид заасан татварын хувь хэмжээгээр тооцоолсон тайлант хугацаанд хамаарах татварыг ААНОАТ-ын өглөгт бүртгэхэд:

Дебет: Тайлант үеийн орлогын татварын зардал

Кредит: Тайлант үеийн орлогын албан татварын өглөг

28.4.1.в.Татварын хөрөнгө, өр төлбөрийг хааж, цэвэр дүнг гаргахад:

Дебет: Тайлант үеийн орлогын албан татварын өглөг

Кредит: Татварын авлага

28.4.2.Хойшлогдсон татварыг дараах байдлаар бүтгэнэ:

28.4.2.а.Татвар ногдох түр зөрүү үүсвэл хойшлогдсон татварын өглөг хүлээн зөвшөөрч, бүртгэхэд:

Дебет: Хойшлогдсон татварын зардал

Кредит: Хойшлогдсон татварын өглөг

28.4.2.б.Хойшлогдсон татварын өглөгийг буцаахад:

Дебет: Хойшлогдсон татварын өглөг

Кредит: Хойшлогдсон татварын зардал (орлого)

28.4.2.в.Ирээдүйд нөхөгдөх боломжтой хасагдах түр зөрүү үүсгэхэд:

Дебет: Хойшлогдсон татварын хөрөнгө

Кредит: Хойшлогдсон татварын зардал (орлого)

28.4.2.г.Хойшлогдсон татварын хөрөнгийг буцаахад:

Дебет: Хойшлогдсон татварын зардал (орлого)

Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

28.4.2.д.Дараа жилүүдэд шилжүүлэх татварын тайлангаарх алдагдлын хувьд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөхөд:

Дебет: Хойшлогдсон татварын хөрөнгө

Кредит: Хойшлогдсон татварын зардал (орлого)

28.4.2.е.Татварын тайлангаарх алдагдлыг дараа жилүүдэд шилжүүлэхэд:

Дебет: Хойшлогдсон татварын зардал

Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

28.4.2.ё.Дараа жилүүдэд шилжүүлэлгүй үлдсэн татварын тайлангаарх алдагдлыг буцаахад:

Дебет: Хойшлогдсон татварын зардал

Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

## **ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС**

29.1.Тэнцлийн гадуурх данс нь зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг, болзошгүй үүрэг, барьцаа хөрөнгө, тэнцлээс хассан хөрөнгө, дериватив санхүүгийн хэрэгсэл, барьцаанд тавьсан хөрөнгө зэрэг үйл ажиллагааг бүртгэх дансд юм.

### **29.2.Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг**

29.2.1.Зээлд хамаарах үүргийг гэрээнд заасан болзошгүй өр төлбөрийн үнийн дүнгээр бүртгэнэ. Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой хүлээх үүрэгт харилцагчийн нэрийн өмнөөс гаргасан баталгаа, батлан даалт, нээсэн зээлийн шугам зэрэг бусдын өмнөөс хүлээж болзошгүй ТЗЭ-ийн үйлчилгээтэй холбоотой бүх үүрэг багтана.

29.2.2.Харилцагчийн болон өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын төлбөр хүлээн авагчдад гаргасан цаашид хүлээж болзошгүй үүрэг нь батлан даалт болох ба баталгаа нь харилцагч гуравдагч талд хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүсвэл харилцагчийн өмнөөс төлбөрийг барагдуулах үүрэг хүлээсэн буцаан дуудахгүй бөгөөд зээлтэй адил эрсдэл агуулдаг.

29.2.3.ТЗЭ-ээс холбогдох журмын дагуу гаргасан батлан даалтыг үндэслэн тэнцлийн гадуур бүртгэж, батлан даалтын хугацаа дуусаж, төлбөр төлөгдөх үед зарлагадна. Батлан даалт гаргуулагч нь төлбөрийг хугацаандаа төлөөгүй нөхцөлд харилцагчийн өмнөөс төлбөрийг барагдуулж, тухайн харилцагчтай зээлийн гэрээ байгуулна.

29.2.4.Баталгааг тэнцлийн дотор зээлийн багцад тусгах бөгөөд үүнтэй зэрэгцэн тэнцлийн гадуурх дүнг зарлагадна. ТЗЭ-ийн барагдуулсан баталгааны төлбөр нь харилцагчийн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал буюу үнэ цэнийн бууралтыг илэрхийлдэг учраас зээлийн дансны үнэ нь урьдчилан тооцсон эргэн төлөгдөх дүнтэй тэнцүү байдаг. Эрсдэлийн сантай холбоотой хийх үнэлгээг энэ журмын “Зээл” бүлгээс үзнэ үү.

29.2.5.Зээлийн шугам нь зээл олгохоор хүлээсэн үүргийн хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд зээлийн дүнг бүтнээр нь эсхүл хэсэгчлэн авах хүсэлт гаргах эрхтэй хүсэлтээр зээл авах боломжийг олгоно.

29.2.6.Харилцагчид зээлийн шугам нээсэн тухай бүрд үүнийг тэнцлийн гадуурх зээлд хамаарах үүрэг дансанд бүртгэнэ. Хэрэв харилцагч зөвшөөрсөн хязгаарын тодорхой хэсгийг авах хүсэлт гаргавал тухайн хэсгийг зээлээр хүлээн зөвшөөрч, бүртгэх бөгөөд зээлийн шугамын зөвшөөрсөн дүнгийн ашиглагдаагүй үлдсэн хэсгийг тэнцлийн гадуурх дансанд үлдээнэ. Эдгээр ажил гүйлгээг бүртгэхэд зээлийн шугам дансыг ашиглана.

29.2.7.Мөнгөн хөрөнгийн болон хөрвөх чадвараа тооцохдоо зээлийн шугамын дагуу гарахаар хүлээгдэж буй дүнг тодорхойлно. Өөрийн хөрвөх чадвараа зохистой тогтоохын тулд зээлийн шугамыг хэрхэн ашиглах талаар харилцагчаас холбогдох мэдээлэл авна.

29.2.9.Зээл олгох буюу зээлийн шугам нээх гэрээний нөхцөлийг зөрчсөн гэрээний хувьд авах арга хэмжээг тодорхойлох ба харилцагч ямар нэгэн зөрчил гаргасан нөхцөлд гэрээг цуцлах эрхтэй.

29.2.10.ТЗЭ нь зээл, зээлийн багцаа бусдад худалдсан боловч зээлтэй холбоотой тодорхой эрсдэл үүсэж, гэрээний дагуу үүрэг хүлээсэн бол үүссэн болзошгүй үүргийг “Шилжүүлсэн зээлтэй холбоотой хүлээж болзошгүй үүрэг” дансанд бүртгэнэ.

29.2.11.Тэнцлийн гадуурх дансны жагсаалтад ороогүй бусад үүрэг эсхүл харилцагчийн өмнө хүлээсэн бусад үүрэг багтана. Мөн НББОУС 37-ийн дагуу болзошгүй өр төлбөрийн тодорхойлолтыг хангах болзошгүй өр төлбөрийг бүртгэнэ. Төлбөр төлөгдөх магадлал нь 50 хувиас бага (өөрөөр хэлбэл, төлбөр төлөгдөх магадлал багатай) болохыг удирдлага үнэлж тогтоосон нөхцөлд энэхүү хүлээсэн үүргийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөхгүй, харин төлөгдөх боломжтой болсноор эрсдэлд өртөх дүнг (болзошгүй төлбөрийн хамгийн их дүн) “Бусад болзошгүй үүрэг” дансанд бүртгэж, тодруулна.

### **29.3.Барьцаа хөрөнгө**

29.3.1.Барьцаа хөрөнгө гэж зээл, зээлтэй адилтгах хөрөнгөтэй холбогдуулан эргүүлэн авах нөхцөлтэйгөөр харилцагчаас барьцаа болгон өгсөн хөрөнгийг ойлгоно. Барьцаа хөрөнгөнд санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө багтана. Барьцаа хөрөнгийг зээл олгосон өдрийн зах зээлийн үнээр бүртгэнэ.

29.3.2.Барьцаа болгон хүлээн авсан хөрөнгийг тэнцлийн гадуур бүртгэнэ. Зээлдэгч зээл, авлагынхаа төлбөл зохих нийт дүнг хугацаанд нь төлсөн тохиолдолд барьцаанд авсан хөрөнгийг уг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна. Зээлдэгч төлбөрөө хугацаанд нь барагдуулж чадаагүй бөгөөд шүүхээс зээлийн үлдэгдэл төлбөрийг хаахын тулд барьцаанд авсан хөрөнгийг эзэмших эрхийг ТЗЭ өөртөө шилжүүлэн авахыг зөвшөөрсөн тохиолдолд тухайн хөрөнгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна. Уг хөрөнгийг өмчлөх бусад хөрөнгийн дансанд (“Бусад санхүүгийн хөрөнгө” эсхүл “Бусад санхүүгийн бус хөрөнгө”) бүртгэх бөгөөд санхүүгийн байдлын тайланд толилуулна.

29.3.3.Барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл нь зээлийн багц болон бусад санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлд өртөх магадлалыг үнэлэхэд чухал бөгөөд СТОУС-ын дагуу зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцоолоход ашиглагдана. Түүнчлэн СТОУС 7-ын дагуу хийх тодруулгад барьцаа хөрөнгийн талаар дэлгэрэнгүй, шинэчлэгдсэн мэдээллийг оруулна. Дэлгэрэнгүй тодруулгыг энэ зааврын “Санхүүгийн эрсдэл болон өөрийн хөрөнгийн удирдлага, бусад тодруулга” бүлгээс үзнэ үү.

29.3.4.Үнэт цаасны үнэ цэнийн өөрчлөлтийг харгалзан үзсэний үндсэн дээр үнэт цаасыг барьцаа болгон авч болно. Үнэт цаасны үнэлгээг нэг сараас ихгүй хугацаагаар дахин хийнэ. Хэрэв өмчлөл нь ТЗЭ-ийн мэдэлд шилжин ирээгүй байгаа бол харилцагч гэрээг зөрчсөн даруйд өмчлөх эрхийг эзэмших арга хэмжээ авна.

29.3.5.Авто тээврийн хэрэгсэл зэрэг хөдлөх хөрөнгийн үнэ цэнэ нь цаг хугацаа өнгөрөхийн хирээр буурч байдаг бөгөөд хөдлөх хөрөнгийг барьцаа болгон хүлээн авахдаа уг үнэ цэнийн бууралтыг харгалзан үзэж, бүртгэнэ. Хэрэв өмчлөх эрх нь ТЗЭ-д шилжин ирээгүй байгаа бол харилцагч гэрээг зөрчсөн даруйд өмчлөх эрхийг эзэмших хуульд заасан арга хэмжээг авна. Хөрөнгийн үнэ цэнэ болон нөхцөл байдлын талаарх шинжээчийн үнэлгээг жилд нэгээс доошгүй удаа хийнэ.

29.3.6.Үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах боломжтой үнээр үнэлнэ. Хэрэв хөрөнгийн зах зээл идэвхигүй бөгөөд үнэ цэнийг нь бүртгэхэд хүндрэлтэй байгаа тохиолдолд бодит үнээс доогуур үнэлгээгээр бүртгэж болно. Хэрэв өмчлөх эрх нь ТЗЭ-д шилжин ирээгүй байгаа бол харилцагч гэрээг зөрчсөн даруйд өмчлөх эрхийг эзэмших арга хэмжээг авна. Төлбөрөө төлөхгүй байгаа харилцагчийн хөрөнгийг битүүмжлэх болон хөрөнгийг хураан хяналтдаа авч, худалдан борлуулах эрхийг баталгаажуулахад шаардагдах хугацааг харгалзан үзнэ. Хөрөнгийн үнэ цэнэ болон нөхцөл байдлын талаарх шинжээчийн үнэлгээг байнга буюу жилд нэгээс доошгүй удаа хийнэ.

29.3.7.ТЗЭ ийм төрлийн барьцаа хөрөнгийн бичиг баримт нь эх хувилбараар байгаа эсэх, гэрээг зөрчих, төлбөрөө төлж чадахгүй байх нөхцөл байдал үүсэхэд төлбөрийг барагдуулах хөрөнгөтэй буюу хариуцлагатай батлан даагч эсэхийг голчлон анхаарна. ТЗЭ-ийн зүгээс батлан даалт, баталгааг төлүүлэх тохиолдлуудыг тодорхойлж, гэрээ зөрчигдөх буюу төлбөр төлөгдөхгүй нөхцөл байдал үүсэхэд төлбөр төлүүлэх тодорхой арга зам болон түүнийг гүйцэтгэх эрх зүйн чадамжийг судалж, бий болгоно.

29.3.8.Зээлийн гэрээ зөрчигдөх буюу төлбөр төлөхгүй тохиолдолд бусад барьцааг бэлэн мөнгөнд хурдан хөрвөх шинж чанарыг харгалзан хөрөнгийг барьцаанд авна. ТЗЭ гэрээ зөрчигдөх буюу төлбөр төлөгдөхгүй нөхцөл байдал үүсэхэд төлбөрөө төлүүлэх тодорхой арга зам болон түүнийг гүйцэтгэх эрх зүйн чадамжийг бий болгоно.

## **29.4.Тэнцлээс хассан хөрөнгө**

29.4.1.Холбогдох хууль, журмын дагуу эргэн төлөгдөхгүй гэж үзсэн ТЗЭ-ийн албан ёсны шийдвэрт үндэслэн санхүүгийн тэнцлээс хассан хөрөнгө юм. Хассан хөрөнгийг тэнцлээс хассан дүнгээр нь бүртгэнэ.

29.4.2. Үнэт цаасны үнэ цэнийн бууралтаас шалтгаалан холбогдох эрсдэлийн сангаар нь хаасан бол үүнийг тэнцлийн гадуурх “Үнэт цаасны эрсдэлийн сангаар хаасан үнэт цаас” дансанд бүртгэнэ.

29.4.3. Үнэт цаасны (өмнө нь тэнцлээс хассан) үнэ цэнэ нь дараагийн тайлант үед материаллаг дүнгээр эргэж өссөн, тухайн хөрөнгийн эргэн төлөгдөх байдал өссөн зэргийг илтгэх нөхцөл байдал (гэрээний нөгөө талын эрсдэл буурсан гэх мэт)-д нөхөгдөх дүнг дахин тооцож, үнэлж болно. Энэ тохиолдолд тэдгээр хөрөнгө нь бүхлээрээ буюу хэсэгчлэн нөхөгдөх боломжтой гэж дүгнэсэн бол тэдгээрийн нөхөгдөх дүнг санхүүгийн тайланд эргүүлэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Ийм тохиолдолд харгалзах хөрөнгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадах бөгөөд түүнийг нөхөгдөх дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд хөрөнгө оруулалт дансанд бүртгэнэ. Үнэт цаасыг бүртгэх дэлгэрэнгүй тайлбарыг энэ журмын “Хөрөнгө оруулалт” бүлгээс үзнэ үү.

29.4.4. Зээлийн үлдэгдэл төлбөрийг төлүүлэх арга хэмжээ үргэлжлүүлэн авах талаар тодорхой тусгана (Шүүхэд нэхэмжлэл гаргах, өр барагдуулах байгууллагад хандах). Зээлийн төлбөрийг барагдуулахад шаардагдах зардал ямар байхыг тогтоож, цаашид өр авлагыг барагдуулах чиглэлээр авах арга хэмжээг эрчимжүүлэн, гаргасан шийдвэр, авч хэрэгжүүлж буй арга хэмжээг баримтжуулна.

29.4.5. Тодорхой нэг зээлийг эргэн төлөгдөхгүй гэж тооцон нийт зээлийн дүнд эрсдэлийн сан байгуулсан бол эргэн төлөгдөх магадлалыг харгалзан холбогдох хууль, журмын дагуу тухайн зээлийг эрсдэлийн сангаар хаах шийдвэр гаргаж болно. Хэрвээ зээлийг тэнцлээс хасах шийдвэр гаргасан бол санхүүгийн байдлын тайлангийн холбогдох зээлийн дүн, түүнд харгалзах эрсдэлийн санг зарлагадан, улмаар зээлийн үлдэгдэл төлбөрийн дүнг тэнцлийн гадуурх зээлийн эрсдэлийн сангаар хаасан зээл дансанд бүртгэнэ.

29.4.6. Хэрэв тэнцлээс хассан зээлийн төлбөр дараагийн тайлант үед эргэн төлөгдвөл түүнийг ашиг, алдагдлын дансанд орлого болгон бүртгэх бөгөөд эргэн төлөгдсөн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

29.4.7. Бусад хөрөнгийн хувьд үнэ цэнийг буурахад хүргэсэн нөхцөл байдал өөрчлөгдсөн бол зээлийн эргэн төлөгдөх байдлыг дахин үнэлнэ. Удирдлагын зүгээс уг хөрөнгө бүхэлдээ эсхүл хэсэгчлэн эргэн төлөгдөх боломжтой гэдэг дүгнэлтэд хүрвэл төлөгдөх дүнг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэх шийдвэр гаргаж, өмнө тэнцлээс хассан дүнг буцаана. Холбогдох зээлийг тэнцлийн гадуурх данснаас хасаж, нөхөгдөх дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд зээлийн холбогдох дансанд бүртгэнэ. Зээлийг нягтлан бодох бүртгэлд тусгах дэлгэрэнгүй тайлбарыг энэ журмын “Зээл” бүлгээс үзнэ үү.

29.4.8. Онцгой тохиолдолд өмчлөх бусад хөрөнгө бүхлээрээ нөхөгдөхгүй байж болно. Өмчлөх бусад хөрөнгө нь борлогдохгүй, эргэн төлөх боломжгүй болсон үнэт цаас эсхүл худалдан авах хүн олдохгүй, ТЗЭ өөр зориулалтаар ашиглах боломжгүй бөгөөд ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж авчирдаггүй барилга, байшин байж болно. Ийм тохиолдолд удирдлагын шийдвэрээр өмчлөх бусад хөрөнгийг харгалзах эрсдэлийн сангаар нь хааж, холбогдох дүнг тэнцлийн гадуурх өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангаар хассан хөрөнгө дансанд бүртгэж, хөрөнгийг худалдах арга хэмжээг үргэлжлүүлэн авна.



29.4.9.Тэнцлээс хассан хөрөнгийг зах зээлд буцаан борлуулах боломжтой болж удирдлага тодорхой хэмжээний төлбөр хүлээн авахаар байвал тэнцлийн гадуурх данснаас зарлагдаж, түүнийг санхүүгийн байдлын тайланд нөхөгдөхөөр тооцсон дүнгээр нь хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

29.4.10.Авлагын тодорхой дүн нь нөхөгдөх магадлал бага гэж удирдлага үнэлж, түүнийг тэнцлийн гадуур бүртгэхээр шийдвэр гаргасан бол авлагыг харгалзах эрсдэлийн сангаар нь тэнцлээс хасаж, тэнцлийн гадуурх авлагын эрсдэлийн сангаар хаасан авлага дансанд бүртгэж, авлага төлүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.

29.4.11.Бусад хөрөнгийн хувьд үнэ цэнийг буурахад хүргэсэн нөхцөл байдал арилсан бол удирдлага авлагын эргэн төлөгдөх байдлыг дахин үнэлж удирдлагын зүгээс тэдгээр хөрөнгүүд нь бүхэлдээ буюу хэсэгчлэн эргэн төлөгдөх боломжтой гэж үзвэл төлөгдөх дүнг тэнцэлд бүртгэх шийдвэр гаргаж, өмнө тэнцлээс хассаныг буцаана. Энэ нөхцөлд холбогдох хөрөнгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагдаж, эргэн төлөгдөх дүнгээр нь санхүүгийн байдлын тайлан дах бусад санхүүгийн хөрөнгө дансанд бүртгэнэ. Авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгах дэлгэрэнгүй тайлбарыг энэ журмын “Бусад санхүүгийн хөрөнгө” бүлгээс үзнэ үү.

29.4.12.Зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийн аль нэг нь зээлийн гэрээнд заасан хугацаанаас хойш 90 хоногийн дотор төлөгдөөгүй бол 91 дэх хоногоос эхлэн хүүг хуримтлуулан тооцохыг зогсоож өмнө нь хуримтлуулсан хүүг буцаана. Буцаасан хүүгийн дүнгээр хуримтлуулж тооцохыг зогсоосон хүү дансанд бүртгэх бөгөөд зээлийн үндсэн төлбөр болон хүүг төлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авна. Хуримтлуулж тооцохыг зогсоосон хүүг зээлдэгч нэг бүрийн нэрийн дансдаар задлан бүртгэх бөгөөд зээл болон хүүг нэгэн зэрэг төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Хэрэв зээлийн хүү төлөгдсөн бол төлөгдсөн дүнгээр тэнцлийн гадуурх данснаас зарлагдаж, санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

## **29.5.Дериватив санхүүгийн хэрэгсэл**

29.5.1.Биет хэлбэрээр шилжүүлэхгүй нөхцөлтэй гэрээ гэж хүүгийн түвшин, валютын ханш, үнэт цаасны үнэ болон бусад индексийн өөрчлөлтөөс шалтгаалан суурь хөрөнгийг биетээр шилжүүлэлгүй, мөнгөн хөрөнгө хүлээн авах буюу төлөх үүргийг хэлнэ. Ийм төрлийн арилжааг спот арилжаа (гэрээ хийснээс хойш 3 хүртэлх ажлын өдөрт багтаан хэрэгжихээр хүлээгдэж буй арилжаа) ба хугацаа заасан форвард арилжаа (гэрээ хийснээс хойш 3-аас дээш ажлын өдөрт хэрэгжихээр хүлээгдэж буй арилжаа) гэж 2 ангилна.

29.5.2.Дериватив санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой гэрээ, хэлцэлд оролцож байгаа бол хэлцэл хүчин төгөлдөр болсноор хэлцлээр үүссэн авлага (эрх), өглөг (үүрэг) -ийг хэлцлийн дуусах хугацаа хүртэл тэнцлийн гадуур холбогдох дансанд бүртгэнэ.

29.5.3.Деривативын авлага, өглөгийг нэрлэсэн дүнгээр нь ажил гүйлгээ тус бүрт тэнцлийн гадуурх дансанд бүртгэнэ.

29.5.4.Хөрөнгийг худалдах болон худалдан авах дериватив хэлцэл хийсэн өдөр тухайн гүйлгээнээс үүссэн авлага, өглөгийг тэнцлийн гадуурх дансанд

бүртгэнэ. Хэлцлийн хугацаа дуусаж, хэлцэл хэрэгжих эсхүл позиц хаагдахад эдгээр авлага, өглөгийг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

## **29.6.Барьцаанд тавьсан хөрөнгө**

29.6.1.Банк, эрх бүхий этгээдээс авсан санхүүжилтийн эх үүсвэрийн барьцаанд тавьсан хөрөнгийг бүртгэнэ. Барьцаанд тавьсан хөрөнгийг төрлөөр (үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас гэх мэт) нь бүлэглэж, барьцаанд тавьсан хөрөнгийн холбогдох дансанд бүртгэнэ.

29.6.2.Эдгээр хөрөнгийг харгалзах хөрөнгийн төрлөөс хамааран тэдгээрийн бодит үнэ эсхүл хорогдуулсан өртгөөр бүртгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд (гадаад валютаар илэрхийлэгдсэн үнэ цаас, борлуулахад бэлэн үнэт цаас болон арилжааны үнэ цаас, дахин үнэлгээний загварыг ашигласан үндсэн хөрөнгө гэх мэт) дахин үнэлнэ.

29.6.3.Хөрөнгийн аль нэг хэсгийг гэрээний дагуу барьцаа болгон өгөх бүрд уг барьцааны дүнг барьцаанд тавьсан хөрөнгө гэж тэнцлийн гадуурх дансанд бүртгэнэ. Барьцааны гэрээний хугацаа нь дууссаны дараа барьцаанд тавьсан хөрөнгийн дүнг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

## **29.7.Тэнцлийн гадуурх бусад дансууд**

29.7.1.Харилцагчийн өмнөөс удирдаж буй хөрөнгийг энэ дансанд бүртгэнэ. Хөрөнгийг бусад этгээдийн өмнөөс удирдаж байгаа үед тухайн хөрөнгийг хадгалан хамгаалж, удирдах чадвар, тусгай зөвшөөрөл зэргийг үндэслэнэ. ТЗЭ зээл олгоод, зээлийг өөр компанид шилжүүлсэн (факторинг) байж болно.ТЗЭ өөрийн удирдаж буй тухайн хөрөнгийн үр дүнг харилцагчид жилд нэгээс доошгүй удаа тайлагнана.

29.7.2.Зээлийг гуравдагч талд борлуулсан боловч зээлийн гэрээ зөрчигдөх буюу төлбөр төлөгдөхгүй нөхцөлд тухайн зээлийг эрсдэлийг шилжүүлж худалдсан гэж ойлгоно. Худалдсан зээлийн багцаас төлбөр гаргуулах гэх мэт зарим эрсдэлийг авч үлдсэнээс бусад тохиолдолд зээлийг энэ дансанд бүртгэх бөгөөд тэнцлийн дотуурх данснаас хасна. Ингэхдээ үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан эсэхийг тогтоосон шинжилгээг үндэслэнэ. Эдгээр гүйлгээтэй холбогдох төлбөр, хураамж, шимтгэлийг гарах бүрд үүссэн орлого, зардлыг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

29.7.3.Үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа тамга, тэмдэг, дардас, лац зэрэг дугаарлагдсан чухал шаардлагатай тэмдгүүдийг тэнцлийн гадуур хэрэглэж буй тэмдгүүд дансанд бүртгэнэ.

29.7.4.Тамга, тэмдгүүд нь тодорхой үнэтэй бөгөөд үүнийг бараа материалаар бүртгэсэн байж болно. Тэмдгүүдийг төрөл болон эзэмшигч тус бүрээр нэрийн данс нээж, тоо ширхгээр загварыг тэмдэглэн бүртгэнэ.

29.7.5.Тэмдгүүд ажил хэргийн шаардлага хангахаа болих, ТЗЭ татан буугдах, алга болох үед тэнцлийн дансанд гүйлгээ хийгдэхэд нэрийн данснаас зарлагдаж, шалтгааныг тодорхой бичнэ.

29.7.6.ТЗЭ харилцагч байгууллага, иргэдэд цахим карт гаргахад зориулсан цахим бэлдцийг тэнцлийн гадуур цахим карт дансанд картын төрлөөр нэрийн данс

нээж, тоо ширхгээр бүртгэнэ. Цахим картыг харилцагч байгууллага, иргэдэд гаргасан нөхцөлд цахим карт данснаас зарлагадана.

|

----oOo----

“Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын нэгдүгээр хавсралт

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГА БЭЛТГЭХ АРГАЧЛАЛ**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ЗҮЙЛ**

1.1.ТЗЭ нь нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэхэд энэ аргачлалыг дагаж мөрдөнө.

1.2.Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлэх ба тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна.

1.3.ТЗЭ-ийн удирдлага нь нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан, бусад мэдээ баримтыг тогтсон загварын дагуу үнэн зөв бэлтгэж, заасан хугацаанд багтаан гаргах үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээнэ.

1.4.Санхүүгийн тайланг оны эхнээс өссөн дүнгээр улирал бүр бэлтгэж, улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

1.5.Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу банк нь Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд холбогдох санхүүгийн тайлагналыг сегментчилэн бэлтгэж, Хороонд ирүүлнэ.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА**

2.1.Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн зорилго нь хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэр гаргахад хэрэглэгчдэд ач холбогдолтой тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тухай мэдээллээр хангах явдал юм.

2.2.Санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна:

- 2.2.1.Санхүүгийн байдлын тайлан;
- 2.2.2.Орлогын дэлгэрэнгүй тайлан;
- 2.2.3.Өмчийн өөрчлөлтийн тайлан;
- 2.2.4.Мөнгөн гүйлгээний тайлан;
- 2.2.5.Санхүүгийн тайлангийн тодруулга.

2.3.Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгах мэдээлэл нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлсэн, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэх боломжтой байх, шалгах боломжтой байх зэрэг чанарын шинжүүдийг хангана.

2.4.ТЗЭ-ийн санхүүгийн тайлан бэлтгэхэд дараах ерөнхий зарчмыг баримтална:

- 2.4.1.санхүүгийн тайланг аккрузал суурьт нийцүүлэн бэлтгэнэ.

2.4.2.санхүүгийн тайланд санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, нэмэлт тайлбар, тодруулгыг үнэн зөв толилуулна.

2.4.3.байгууллагыг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй байх сууриар бэлтгэнэ.

2.4.4.санхүүгийн тайлан дахь толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгална.

2.4.5.санхүүгийн тайланд материаллаг зүйлсийг тусад нь толилуулна. Материаллаг бус дүнтэй зүйлсийг шинж чанар буюу үүргийнх нь дагуу ижил зүйлсийн дүнтэй нэгтгэн толилуулна.

2.4.6.байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох тайлангийн маягтын дагуу өмнөх үеийн мэдээлэлтэй зэрэгцүүлсэн байдлаар толилуулна.

2.4.7.Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартаар шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд аж ахуйн нэгж нь хөрөнгө ба өр төлбөр, эсхүл орлого ба зардлыг хооронд хааж, цэвэр дүнг гаргахгүй.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

3.1.ТЗЭ нь өөрийн үндсэн үйл ажиллагааны шинж чанарт үндэслэн хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд ангилан, тодорхой хугацаагаар тасалбар болгон үлдэгдлийг тайлагналын өдрөөр тасалбар болгон толилуулна.

3.2.Санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө ба өр төлбөрийг шинж чанар, хөрвөх чадвараар толилуулна.

3.3.Санхүүгийн байдлын тайланг СТ-1 загварын дагуу бэлтгэнэ.

3.4.Санхүүгийн байдлын зүйлсийг тайлант жилийн эхнээс өссөн дүнгээр гаргах ба санхүүгийн тайлангийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

3.5.Санхүүгийн байдлын тайланд хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр толилуулна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

4.1.Орлогын дэлгэрэнгүй тайлан нь тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүнг хэмжих бөгөөд орлого, зардлыг аккруэл сууриар бүртгэж, толилуулна.

4.2.Орлогын дэлгэрэнгүй тайланг СТ-2 загварын дагуу бэлтгэнэ. Орлогын дэлгэрэнгүй тайланг толилуулахдаа тайлант үеийг өмнөх үетэй ижил хугацаагаар тасалбар болгон харуулна.

4.3.Орлого, зардлыг үндсэн төрлөөр ангилан орлогын дэлгэрэнгүй тайлан бэлтгэж, тодруулна.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

5.1.Өмчийн өөрчлөлтийн тайланд өмчид гарсан аливаа өөрчлөлтийг толилуулна.

5.2. Өмчийн өөрчлөлтийн тайланд хувьцаа эзэмшигчидтэй хийсэн өмчийн ажил гүйлгээ, тэдгээрийг эзэмшигчдэд хуваарилсан байдал, тайлант хугацааны эхэн болон эцэс дэх өмчийн ангилал тус бүрийн дансны үнэ, нэмж төлөгдсөн капитал, сангуудын тохируулга, өөрчлөлтийг тусад нь харуулна.

5.3. Өмчийн өөрчлөлтийн тайланг СТ-3 загвараар бэлтгэнэ.

5.4. Өмчийн өөрчлөлтийн тайланд өмчид гарсан аливаа өөрчлөлтийн хэмжээг хоёр жилээр толилуулна.

5.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгыг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг залруулах байдлаар тохируулж, залруулагдсан эхний үлдэгдлийг тодорхойлно.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

6.1. Мөнгөн гүйлгээний тайлан нь үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ, бүх цэвэр мөнгөн гүйлгээ гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

6.2. Мөнгөн гүйлгээний тайланг СТ-4 загвараар бэлтгэнэ.

6.3. Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд хоёр жилээр зэрэгцүүлэн дараах байдлаар харуулна. Үүнд:

- (а) Мөнгөн хөрөнгийг бүрдүүлсэн эх үүсвэрийг мөнгөн орлого, мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг мөнгөн зарлага гэсэн хэсэгт үзүүлнэ;
- (б) Үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр нийт цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно;
- (в) Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдлийг хасаж, тодорхойлсон мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайлангийн “Бүх цэвэр мөнгөн гүйлгээ” гэсэн дүнтэй тэнцүү байна.

6.3. Мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэхэд шууд аргыг хэрэглэнэ.

### **6.4. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**

6.4.1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн ТЗЭ-ийн зээлийг буцаан төлөх, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны хүчин чадлыг хэвээр хадгалах, ногдол ашиг төлөх, санхүүжилтийн гадаад эх үүсвэрээс мөнгө авахгүйгээр шинэ хөрөнгө оруулалтыг хийх хангалттай хэмжээний мөнгөн гүйлгээг үйл ажиллагаагаар үүсгэн бий болгох эсэхийг илэрхийлдэг гол үзүүлэлт юм.

6.4.2. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь аж ахуйн нэгжийн орлого олох үндсэн үйл ажиллагаанаас үүсэн бий болдог.

### **6.5. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**

6.5.1. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь ирээдүйд олох орлого ба мөнгөн гүйлгээ бий болгох нөөцийн хувьд зарцуулсан дүнг илэрхийлнэ.

6.5.2.Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ нь урт хугацаанд ашиглагдах хөрөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгөнд ороогүй бусад хөрөнгө оруулалтыг олж эзэмших болон худалдах үйл ажиллагааг хамарна.

6.5.3.Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын ажиллагааны мөнгөн орлого хэсэгт хөрөнгө оруулалт ба үндсэн хөрөнгийг (хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг оруулсан) худалдаад орсон мөнгөн орлогын дүнг харуулна. Мөн хүлээн авсан хүүгийн орлого, ногдол ашгийг нэмнэ.

6.5.4.Хөрөнгө оруулалтын ажиллагааны зарлага хэсэгт үнэт цаас болон өмчийн хэрэгсэл худалдан авах хэлбэрээр хөрөнгө оруулалт оруулах болон үндсэн хөрөнгө худалдан авах, олж бэлтгэхэд ба их засварт зарцуулсан мөнгөн зарлага зэргийг тусгана.

## **6.6.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**

6.6.1.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь аж ахуйн нэгжийн хувь нийлүүлсэн өмч ба зээлийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах үр дүн бүхий үйл ажиллагаа юм.

6.6.2.Мөнгөн гүйлгээний тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого хэсэгт бусад эх үүсвэр, хоёрдогч өглөгийг оруулсан урт хугацаагаар авсан зээл ба эх үүсвэр, үнэт цаас худалдсаны орлого, хувьцаа гаргаснаас олсон орлого,бусдаас авсан санхүүжилт болон бусад орлогуудыг харуулна.

6.6.3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага хэсэгт урт ба богино хугацаагаар авсан зээл болон урт хугацаат өглөгийн төлөлт, мөнгөөр төлсөн ногдол ашиг зэрэг мөнгөн зарлага зэргийг харуулна.

## **6.7.Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)**

6.7.1.Мөнгөн хөрөнгийн цэвэр өсөлт, бууралтыг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр тодорхойлно. Мөн үүнд мөнгөн хөрөнгөтэй холбогдуулан үүссэн ханшийн зөрүүний нөлөөллийг багтаах ба уг нөлөөллийг тооцоолохдоо мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг валютын албан ханшаар дахин илэрхийлж, өмнөх ханшаар илэрхийлж байсан дүнгээс хасна.

6.7.2.Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хассан мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайлангийн бүх цэвэр мөнгөн гүйлгээний дүнтэй тэнцүү байна.

6.7.3.Мөнгөн гүйлгээг нэмэгдүүлэх ба хорогдуулахад нөлөөлдөггүй ажил гүйлгээнд хувьцаа гаргаж орлогод авсан үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгө ба санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээ, хувьцаагаар олгох ногдол ашиг гэх мэт орно.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

7.1.Санхүүгийн тайлангийн тодруулгад доорх зүйлсийг хамруулна:

7.1.1.санхүүгийн тайланг бэлтгэх тулгуур үзэл баримтлал, ажил гүйлгээ ба үйл явдлыг бүртгэхээр сонгож авсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх тайлбарыг агуулсан байх;

7.1.2.санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан зэрэг санхүүгийн тайлангуудад тусгагдаагүй боловч СТОУС-аар шаарддаг мэдээллийг тодруулсан байх;

7.1.3.санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлантай холбоотойгоор хийсэн нарийвчилсан шинжилгээ, нэмэлт тайлбар, болзошгүй үүрэг гэх мэт нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусгасан байх.

7.2.Санхүүгийн тайлангийн тодруулгад санхүүгийн тайлангийн зүйл тус бүрийн мэдээллийг тайлангийн дэс дарааллын дагуу толилуулна. Толилуулж, тодруулж буй дүнг зэрэгцүүлэх сууриар бэлтгэнэ.

### **7.3.Тайлан бэлтгэх үндэслэл**

7.3.1.ТЗЭ-ийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хуулийн этгээдийн нэр, санхүүгийн тайлангийн дуусгавар болсон огноо, санхүүгийн тайлангийн хамарсан хугацаа, байгууллагын бүтэц, зохион байгуулалтад гарсан гол өөрчлөлт, санхүүгийн тайлан СТОУС-д нийцсэн тухай тайлбар, нягтлан бодох бүртгэлийн ашиглаж буй суурь, ерөнхий бодлогын товч тайлбар зэргийг товч тодорхойлж, харуулна.

7.3.2.Шинээр гарсан бөгөөд тухайн тайлант жилийн эхнээс мөрдөж эхлэх СТОУС, дараагийн тайлант үеэс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх СТОУС, тайлбарыг тус тус анхааран үзэж, мөрдлөг болгох ба шинэ стандарт, тайлбарыг мөрдсөн жилийн ба түүнээс хойших жилүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөллийг үнэлнэ. Энэ мэдээллийг СТОУС-д нийцүүлсэн тухай мэдэгдэл эсхүл санхүүгийн тайлангийн тодруулгын холбогдох хэсэгт дурдана.

7.3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахдаа санхүүгийн тайланд тусгасан үзүүлэлтүүдийг бүртгэх аргуудыг тайлбарлан үзүүлнэ. Зарим зүйлсийг хүснэгтээр илэрхийлж болно. Үүнээс гадна нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахдаа дараах зүйлсийн тухай дурдаж болно:

- а.Санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах арга ажиллагаа;
- б.Мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэл хөтлөх маягт, аргачлал;
- в.Бүртгэлийн ба тайлагналын валют;
- г.Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого;
- д.Бүх төрлийн нөөц, сан байгуулах арга;
- е.Бодит үнэ цэнийн үнэлгээ, тооцоолол;
- ё.Болзошгүй зүйлс;
- ж.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга;
- з.Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх зарчим.

7.3.4.Тайлант хугацааны төгсгөлд гадаад валютаар илэрхийлэгдсэн зүйлсийг төгрөгт хөрвүүлэхэд ашигласан гадаад валютын албан ханшийг тодруулж болно. Энэ мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн тодруулгын аль тохиромжтой гэж үзсэн хэсэгт дурдана.



## **7.4.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**

7.4.1.Энэ хэсэгт нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа, тооцооллыг өөрчлөлтийн талаар НББОУС 8-д заасны дагуу тодруулна.

7.4.2.Хэрэв ТЗЭ нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн бол өөрчлөх болсон шалтгаан, өөрчлөлтийн шинж чанар, шилжилтийн нөхцөлийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлого илүү найдвартай, хамааралтай мэдээллээр хангана гэж үзсэн шалтгаан, түүний санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөөлөл зэргийг тодруулна.

7.4.3.НББОУС 8-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг гүйцээн мөрдөх горимоор хүлээн зөвшөөрч байгаа бол түүний шинж чанар, санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөө, ирээдүйд үзүүлж болзошгүй нөлөөлөл зэргийг тодорхойлох боломжтой үед тодруулна.

7.4.4.Өмнөх тайлант хугацаанд хамаарах алдааг илрүүлж, залруулсан бол энэ талаар тодруулна.

## **7.5.Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

7.5.1.НББОУС 7-д заасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн шалгуур хангасан хөрөнгө, түүний тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэлд гарсан өөрчлөлт, бусад шаардлагатай нэмэлт тайлбарыг тодруулна.

## **7.6.Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө**

7.6.1.ТЗЭ-ийн эзэмшилд байгаа боловч өөрөө ашиглах боломжгүй, барьцаанд байгаа мөнгөн хөрөнгийг (барьцаанд тавьсан, эсхүл гуравдагч этгээдийн хязгаарласан данс гэх мэт) тусгайлан тодруулна.

## **7.8.Зээл**

7.8.1.Зээлийн өрийн үлдэгдлийг хугацаа, чанар, бүтээгдэхүүгийн төрлөөр харуулахын зэрэгцээ дараах зүйлсийг нэмж тодруулна:

- а.Зээлийн барьцаа, батлан даалт;
- б.Эрсдэлийн сангаас хаасан зээлийн дүн;
- в.Өмнөх тайлант хугацаанд сангаар хаасан зээлээс тайлант хугацаанд барагдуулсан дүн;

## **7.9.Дериватив санхүүгийн хэрэгсэл**

7.9.1.Дериватив санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг адил төстэй шинж чанар, төрлөөр нь ангилж харуулахын зэрэгцээ дараах зүйлсийг нэмж тодруулна:

- а.Форвард, своп, фьючерс, опшин хэлцэлтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн деривативын бодит үнэ цэнийн тооцоолол, түүнд ашигласан үнэлгээний арга;
- б.Тайлант хугацаанд нэмэгдсэн ба данснаас хассан деривативын дүн;
- в.Тайлант хугацаанд хэрэгжсэн форвард, своп, фьючерс, опшин хэлцэл, үүнтэй холбогдуулан үүссэн арилжааны олз ба гарз (деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлт);

г.Форвард, своп, фьючерс, опшин арилжааны авлага, өглөгийн тэнцлийн гадуур бүртгэсэн нэрлэсэн дүн, холбогдох нэмэлт тайлбар;

д.Гадаад валют худалдах эсхүл худалдан авахаар байгуулсан форвард, своп, фьючерс, опшин хэлцэлтэй холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, түүнд хийсэн үнэлгээ, шинжилгээ;

е.Хейжийн хэрэгсэл, хейжийн хэрэгслийн төрөл тус бүртэй холбоотой эрсдэл болон хейжээр хамгаалагдсан эрсдэлийн талаар тодруулна. Мөнгөн гүйлгээний эсхүл бодит үнэ цэнийн хейжийн хувьд СТОУС 9-д шаардсан бусад тодруулгыг нэмж тодруулна.

## **7.7.Хөрөнгө оруулалт**

7.7.1.Хөрөнгө оруулалтын үлдэгдэл, тайлант үед гарсан өөрчлөлт, эрсдэлийн санг хөрөнгө оруулалтын ангилал бүрээр тодруулахын зэрэгцээ дараах зүйлсийг нэмж тайлбарлана:

а.Тайлант хугацаанд худалдан авсан үнэт цаасны бодит үнэ цэнийн тооцоог хэрхэн хийсэн болон ашигласан үнэлгээний арга;

б.Үнэт цаасны ангилал тус бүрээр байгуулсан эрсдэлийн сан;

в.Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасны хувьд эргэн төлөгдөх хугацаа;

г.Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэдэг бол хяналтын эрхгүй хувь оролцоо, түүнд гарсан өөрчлөлт;

д.Барьцаанд байгаа үнэт цаас;

е.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэр төрөл;

ё.Хөрөнгө оруулалтыг данснаас хассанаас үүссэн орлого, зардал;

ж.Үнэт цаасны арилжаатай холбоотой хүлээж болзошгүй эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, шинжилгээ судалгаа.

7.7.2.Хөрөнгө оруулалтыг нэг ангиллаас нөгөө ангилалд шилжүүлж, өөрчилсөн тохиолдолд (ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн, борлуулахад бэлэн, хугацааны эцэс хүртэл эзэмших) дараах зүйлсийг заавал тодруулна:

а.Ангилал өөрчлөгдсөний улмаас ангилал бүрд нэмэгдсэн болон тухайн ангиллаас хасагдсан дүн;

б.Хөрөнгийг данснаас хасах хүртэл өмнөх ба тайлант жилд ангиллыг өөрчилсөн бүх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба дансны дүнг тайлант жил бүрээр;

в.Санхүүгийн хөрөнгийг хугацааны эцэс хүртэл эзэмших ангиллаас борлуулахад бэлэн эсхүл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжих ангилалд шилжүүлж өөрчлөх нөхцөл байдал;

г.Санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчлөх үед ашиг, алдагдал эсхүл бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн тайлант болон өмнөх үеийн бодит үнэ цэнийн орлого, зардал;

д.Санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчлөх, данснаас хасах хүртэлх тайлант хугацаа бүрд тухайн санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчлөөгүй байсан бол орлого, зардал, эсхүл бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх байсан бодит үнэ цэнийн орлого, зардал болон ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн орлого, зардал, олз, гарз.

## **7.10.Бусад санхүүгийн хөрөнгө**

7.10.1.Бусад авлага, урьдчилгаа тооцоотой холбогдуулан дараах тодруулгыг нэмж бэлтгэнэ:

а.Бусад авлагыг барагдуулах хугацаагаар ангилан харуулах;

- б.Бусад авлагын эрсдэлийн сангийн тайлант хугацааны өөрчлөлт, эрсдэлийн сангаас хаасан авлагын дүн;
- в.Бусад авлага, урьдчилгааг данснаас хасахад үүссэн олз, гарз.

### **7.11.Бусад санхүүгийн бус хөрөнгө**

7.11.1.Бараа материал, үнэ бүхий зүйлстэй холбогдуулан хөрөнгийн үнэ цэнийн бууралт, бараа, материал, үнэ бүхий зүйлсийг данснаас хасахад үүссэн олз, гарзыг нэмж тодруулж болно.

### **7.12.Өмчлөх бусад хөрөнгө**

7.12.1.Өмчлөх бусад хөрөнгийг чанар, нэр төрлөөр нь ангилж харуулах ба дараах зүйлсийг тодруулна:

- а.Тайлант хугацаанд зээлийн өрөнд авсан санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгийн дүн, холбогдох мэдээлэл;
- б.Данснаас хассан өмчлөх бусад хөрөнгийн дүн;
- в.Тайлант хугацаанд худалдан борлуулсан хөрөнгийн дүн, үүссэн олз ба гарз;
- г.Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн өөрчлөлт, үлдэгдэл;
- д.Тайлант хугацааны эрсдэлийн сангийн зардлын дүн.

### **7.13.Үндсэн хөрөнгө**

7.13.1.Үндсэн хөрөнгийн дараах мэдээллийг нэмж тодруулна:

- а.Ашигласан элэгдлийн арга, элэгдүүлэх хувь хэмжээ;
- б.Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралттай холбоотой хөдөлгөөн гарсан бол хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын зардал эсхүл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээ;
- в.Үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн бол үнэлгээ хийгдсэн өдөр, дахин үнэлгээний нэмэгдэл дансанд гарсан өсөлт, бууралт, ашигласан үнэлгээний аргачлал, эсхүл хөрөнгийн үнэлгээчнээр үнэлүүлсэн үнэлгээ;
- г.Санхүүгийн түрээсээр авсан хөрөнгө, холбогдох санхүүгийн түрээсийн өглөг;
- д.Барьцаанд байгаа үндсэн хөрөнгө;
- е.Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа үндсэн хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүн, бүтэц;
- ё.Үндсэн хөрөнгийн санхүүжилтэд бүртгэсэн, хараахан хүлээн аваагүй үндсэн хөрөнгийн худалдан авалтын урьдчилгаа;
- ж.Үндсэн хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз ба гарз.

### **7.14.Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

7.14.1.НББОУС 40-д заасны дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд ашигласан хэмжилтийн суурь, бодит үнэ цэнийн загвар ашигладаг бол бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан арга, бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн олз, гарз, хэрэв түрээсэлдэг бол түрээсийн орлого, түрээсэлсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зардал, хэрэв өртгийн загвар ашигладаг бол хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл тооцох арга болон бусад тодруулгыг хийнэ.

## **7.15.Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө болон өр төлбөр**

7.15.1.СТОУС 5 “Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа”-д заасны дагуу тодруулна.

### **7.16.Биет бус хөрөнгө**

7.16.1.Биет бус хөрөнгийн ангилал тус бүрээр дараах мэдээллийг нэмж тодруулна:

а.Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийн хувьд хорогдуулгыг тооцоход ашигласан арга, хорогдуулах хугацаа, норм, тайлант жилийн хорогдлын зардлын дүн;

б.Дахин үнэлгээний өөрчлөлтөөс гарсан өртгийн өсөлт, бууралт ба өмч, орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралт;

в.Биет бус хөрөнгийн үнэ цэнийг бууруулахтай холбоотойгоор хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын зардал эсхүл буцаалт, холбогдох тооцоолол, үнэлгээ;

г.Бүтээн босгох ажлын үе шатанд байгаа биет бус хөрөнгийн өртөгт хүлээн зөвшөөрсөн зардлын дүн, бүтэц;

д.Биет бус хөрөнгийн санхүүжилтэд бүртгэсэн, хараахан хүлээн аваагүй биет бус хөрөнгийн худалдан авалт;

е.Биет бус хөрөнгийг данснаас хасахад үүссэн олз ба гарз.

### **7.17.Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр**

7.17.1.Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэрийн үлдэгдлийг валютаар болон хугацаагаар ангилан тодруулж болно.

### **7.18.Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр**

7.18.1.Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийг валютын төрөл, дотоодын ба гадаадын гэж ангилах буюу материаллаг дүн бүхий эх үүсвэр, санхүүжилтийн талаар тусад нь тайлбарлаж тодруулна.

### **7.19.Бусад эх үүсвэр**

7.19.1.Шаардлагатай тохиолдолд материаллаг дүнтэй бусад эх үүсвэрийг тусад нь тодруулж болно. Мөн санхүүгийн түрээстэй холбогдуулан гэрээний ерөнхий мэдээлэл, хугацаа, түрээсийн төлбөр, болзошгүй өр төлбөр, буцаан түрээсэлсэн эсэхийг тодруулна. Аливаа эх үүсвэрийн хэлцлийн нөхцөлийг хязгаарласан тохиолдолд түүнийг тодруулах, үүнийг зөрчсөн эсэх талаар тодруулна.

### **7.20.Бусад санхүүгийн өр төлбөр**

7.20.1.Бусдад өгөх өглөгийн бүрэлдэхүүн тус бүрээр эхний ба эцсийн үлдэгдлийг тодруулна. Мөн шаардлага бусад нэмэлт тайлбар, тэмдэглэлийг хийнэ.

## **7.21.Санхүүгийн бус өр төлбөр**

7.21.1.Татварын өглөг, богино хугацаат нөөц, бусад өглөгтэй холбоотой тайлбар, тодруулгыг холбогдох СТОУС-ын дагуу хийнэ.

## **7.22.Өөрийн хөрөнгө, түүний удирдлага**

7.22.1.Хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлж буй хувьцааны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хувьцаанд хамааралтай эрх, давуу эрх, эрхийн хязгаарлалт болон тайлант хугацаанд нэмж гаргасан хувьцааны тоо, үүссэн нэмж төлөгдсөн капитал, нэмж төлөгдсөн капиталд гарсан бусад өөрчлөлт, халаасны хувьцаанд гарсан өөрчлөлт зэргийг тодруулна. Өөрийн хөрөнгөнд багтсан сангууд, тэдгээрийн зориулалтыг тодруулна.

7.22.2.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын улмаас хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд гарсан залруулгын дүнг тодруулж, дэлгэрэнгүй тайлбар хийнэ. Мөн холбогдох стандартад шаардсаны дагуу өөрийн хөрөнгөөр шууд хүлээн зөвшөөрсөн орлого, зардал, олз, гарзын дүнг зүйл тус бүрийн болон нийт дүнгийн хувьд тодруулна.

## **7.23.Хүүгийн зардал**

7.23.1.Тайлант хугацааны хүүгийн орлоготой холбогдуулан шаардлагатай нэмэлт тайлбар, тэмдэглэл оруулна.

## **7.24.Хүүгийн зардал**

7.24.1.Тайлант хугацааны хүүгийн зардалтай холбогдуулан шаардлагатай нэмэлт тайлбар, тэмдэглэл оруулна.

## **7.25.Эрсдэлийн сангийн зардал**

7.25.1.Зээл ба авлага нь буцаан төлөгдөх боломжгүй бол холбогдох журмын дагуу эрсдэлийн сангаар хаана. Зарим тохиолдолд хуулийн дагуу бүх асуудлууд шийдэгдэн, зардлын дүн тодорхой болсны дараа л зээл ба авлагыг данснаас хасдаг.Энэ тохиолдолд эрсдэлийн сангаас хаах зээл, авлагын талаар баримтлах бодлогоо тодруулна.

## **7.26.Арилжааны цэвэр орлого, зардал**

7.26.1.Валют, үнэт цаасны арилжааны орлого, зардлын дүнг өмнөх оны дүнтэй зэрэгцүүлэн харуулах ба томоохон ажил, гүйлгээ, арилжааны хэлцлийн тухай нэмэлт тайлбарыг тодруулж болно.

## **7.27.Үнэлгээний өөрчлөлтийн цэвэр орлого, зардал**

